

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY




“Тавантолгой бол
Монголын нэг эмгэнэл

“Топ-20”-ийн засаглал
ямар байна вэ

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2013. 04 сар. №08 (042)

www.mongolianeconomy.mn





ВАГНЕР АЗИ "САТ 793D" ХҮНД ДААЦЫН МАШИНЫГ АМЖИЛТТАЙ УГСАРЛАА



Вагнер Ази компанийн Замын-Үүд дэх салбарын машины тоног төхөөрөмжийн засварын баг "САТ 793D" хүнд даацын таван машиныг сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр амжилттай угсран Ухаа Худаг нүүрсний уурхайд хүргэж өгөхөд бэлэн боллоо.

Тус компанийн Замын Үүд дэх салбар нь уул уурхайн машины тоног, төхөөрөмжийг угсарч, засаж, сэлбэдэг томоохон салбар юм. Монгол Улсад уул уурхай эрчимтэй хөгжихийн сацуу сүүлийн үеийн дэвшилтэт технологийг хэрэглэх болсон нь дэлхийн түвшинд өрсөлдөхүйц хэмжээнд хүрээд байна.



Манай хамт олон САТ-ын шинэ техник, технологийг Монголд нэвтрүүлж, компаниудыг шинэ, орчин үеийн, дэвшилтэт технологиор хангаж байгаадаа үргэлж баяртай байдаг.

САТ-ын тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн горим нарийн чанд байдаг бөгөөд хүнд даацын трейлэр эсвэл галт тэргээр тоног, төхөөрөмжийг тээвэрлэж ирсний дараа нарийн горим, мэргэжлийн түвшинд угсарч, үйлчилдэг билээ. Өнгөрсөн таван жилийн хугацаанд Замын-Үүд дэх салбарт САТ-ын 100 орчим хүнд даацын машин угсран захиалагч байгууллагууддаа хүлээлгэн өгөөд байна. Уг салбарт одоогоор 30-35 засвар үйлчилгээний ажилтан ажиллаж байна.

MONGOLIAN ECONOMY

II улирлын нэмэлт захиалга

Редакцид захиалбал
үнэгүй хүргэнэ



www.mongolianeconomy.mn

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Х.Хулан

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Б.Лхагвачулуун

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /9409-2904/

Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР:

Б.Үүрийнтуяа

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетийн бүх салбар

"Макс" супермаркетийн бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall" салбарууд



БИЗНЕСИЙН ТАЙЛАНГИЙН ЦАХИМ ХЭЛ

XBRL гэдэг нь eXtensible Business Reporting Language буюу Бизнесийн тайлангийн өргөтгөсөн хэл бөгөөд бизнес мэдээллийг цахим хэлбэрээр харилцан солилцох глобал стандартчилагдсан хэл юм. Анх 1998 онд Вашингтоны мэргэшсэн санхүүч Чарлез Хоффманы зүтгэлээр бүрэн бүтээгдсэн, цахим хэлбэрт санхүүгийн тайлан мэдээллийг харилцан солилцох хэлний анхны санааг гаргаж, түүнийг нь Америкийн Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт дэмжин судалгаа, хөгжүүлэлтийг эхлүүлсэнээс хойш консерциум болтлоо өргөжин тэлж одоогоор XBRL-г нийт 27 улс орон нэгдэн үйл ажиллагаандаа нэвтрүүлээд байна. Үүний нэг нь Фүжицү Групп бөгөөд XBRL хэлд суурилсан шийдлийг боловсруулан Японы Үндэсний Татварын Газар, Токиогийн Хөрөнгийн Бирж болон бусад газруудад нэвтрүүлсэнээс гадна, Америк, Испани, Австралийн холбогдох газруудад амжилттай нэвтрүүлж, өдгөө Ази Номхон далай, зүүн Европийн орнуудад нэвтрүүлэхээр ажиллаж байна

XBRL ийн хамгийн өргөн хэрэглээний нэг нь санхүүгийн мэдээллийг солилцох буюу тайлагнах юм. Энэхүү хэлийг нэвтрүүлсэнээр бизнес мэдээллийг хэрэглэх, тайлагнахад цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэхээс өгсүүлээд санхүүгийн төрөл бүрийн байгууллагуудын цар хүрээг бүрэн хамарч бүх шатны татварын байгууллагууд, аудитын байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон банкуудад санхүүгийн тайлангийн мэдээллийг нэгдсэн нэг цахим стандартаар хүргэж, мэдээллийн үнэн зөв байдлыг өндөрсгөн түүнд богино хугацаанд үнэлгээ хийх боломжийг олгодог. Монгол Улсын хувьд Санхүүгийн тайлангийн системийг цахимжуулах ажил сүүлийн 20 гаран жил маш хурдацтай явагдаж ирсэн боловч харамсалтай нь түүний цахим стандартчилал нь орхигдсоноос анхан шатны тайланг бусад байгууллагуудад хүргэхийн тулд хүлээн авагч талын системд тохируулан олон дахин шивэх, шат шатны байгууллагуудад нэгтгэн эцсийн үр дүн шинжээчид хүрэх хүртэл асар их цаг хугацаа алддаг нь мэтгэшгүй үнэн юм. Нэн ялангуяа төсвийн байгууллагын хувьд санхүүгийн тайланг жилдээ нэг удаа тайлагнадаг (явцын тайланг эс тооцвол) нь тухайн байгууллагад гарч буй алдаа доголдолыг хөндлөнгийн шинжээч дүгнэж зөвлөгөө өгөхөд хэт оройтсон байх сул талтай тул, алдаа дутагдалыг илрүүлэн засах бус, арга хэмжээ авах зарчимаар ажиллахаас өөр замгүй болгодог.

Аливаа Улсын хувьд санхүүгийн нэгдсэн тайланг бодит цаг, богино хугацаанд гарган цаашдын төлөвлөгөө стратегийг цаг алдалгүй гаргах нь хөгжилд хүргэх түлхүүрийн нэг нь маргаангүй үнэн тул Монгол Улсын хувьд ч олон улсын стандарт жишигт хөл нийлүүлэн алхах, цахим технологийн шийдлийг цаг алдалгүй өөрийн болгох шаардлагатай юм.

FUJITSU

XBRL[®]
eXtensible Business Reporting Language



“XBRL ТАНИЛЦУУЛГА СЕМИНАР”-т
хүрэлцэн ирэхийг урьж байна.

Семинарын үйл ажиллагаа:

*2013 оны 04-р сарын 25-ны
Пүрэв гарагт 10:00 цагаас
Чингис Хаан Зочид буудлын
Conference Hall-д болно*

“XBRL International” байгууллагын
Тэргүүн Туршлагын
Зөвлөлийн дарга Макото Койзуми

**“ДЭЛХИЙ НИЙТИЙН XBRL-ЫН
ХАНДЛАГА болон ТҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ”**
сэдэвт лекц

Фүжицү Компаний Санхүүгийн Бизнес
Шийдэл Группын менежер Ёшинобу Савано
**“ФҮЖИЦҮ КОМПАНИ XBRL-д СУУРИЛСАН
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙГ НИЙТЭД
НЭЭЛТТЭЙ БОЛГОХ ШИЙДЭЛ болон
НЭВТРҮҮЛСЭН ТУРШЛАГА”** сэдэвт лекц

Ерөнхий зохион байгуулагч
“Ай Эн Ай” компани

www.XBRL.mn

Утас: 7015-0988
8807-9884.

Нөхөөсний төсөв



...Батлагдсан даруйдаа “сэрүүн зүүдэлсэн” төсөв хэмээн адлагдсан Монгол Улсын энэ жилийн төсөв захирагдах ёстой хуулийнхаа хормойд чирэгдэж чадах эсэх нь эдийн засагт үүсээд буй зарим нөхцөл байдлаас үүдэн тодорхойгүй байна.

8

Аз жаргалын хэмжүүр

..Уг санг байгуулах нь эдийн засгийн засгийн хэт халалт, “Голланд өвчин”-өөс сэргийлэх дархлаа юм. Энэ утгаараа Баялгийн сан ирээдүйдээ өгч буй “бэлэг”, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах “бамбай”...

16

“Топ-20”-ийн засаглал ямар байна вэ

...Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Топ-20” хувьцаат компанийн суурь шинжилгээг анх удаа цэвэр өгөөжийн үзүүлэлтээр нь хийжээ. Энэ талаар тус зөвлөлийн...

31

Ашигт малтмалаас ч их

Бээжингээс таван жуулчин хувийн онгоцоороо Африкийн Кени уулын доохнуур өнгөрч, цавчим хөндийгөөр аялж яваа нь энэ ажээ. Тэдний очих газар бол мөчиргүй шар мод болон манан шиг өнгөтэй хинийн модны мөчрөөр хүрээлэгдсэн онгоц буух шороон зурвас...



44

ЭДИЙН ЗАСАГ

- 8 Нөхөөсний төсөв
- 12 “Mongolianeconomy” сэтгүүлийн асуулт
- 14 Монголыг нөмөрч буй төсвийн хямрал
- 16 Аз жаргалын хэмжүүр
- 19 Д.Бямбасүрэн: Тавантолгой бол Монголын нэг эмгэнэл
- 23 Давуу эрхтэй ханган нийлүүлэгч

ОНЦЛОХ ТАЙЛАН

- 25 Хөгжил, хөрөнгө даллая
- 26 Цаг наашилж байна
- 31 “Топ-20”-ийн засаглал ямар байна вэ
- 34 Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр хэрэгжилтийн явц

БИЗНЕС

- 38 “Дэлхийн эмийн сан”-д нутагшсан кластер
- 41 Монгол даяаршсан ертөнцөд хүрч иржээ

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

- 44 Ашигт малтмалаас ч их
- 46 Оросын шархадсан аварга

МОНГОЛ



Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлөөс зээл, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн бодит салбар, бизнесийн эргэлтийг дэмжих зорилгоор бодлогын хүүг нэг хувиар бууруулж, 11.5 хувь болголоо. Мэргэжилтнүүд улсын төсвийн инфляцид үзүүлэх дарамт багасч, эрэлт, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл саарч, ирэх саруудад жилийн инфляци энэ оны зорилтот түвшинтэй нийцэх магадлал өндөр байгаа нь хүүг бууруулахад нөлөөлсөн хэмээн тайлбарлаж байна. Он гарсаар бодлогын хүү нийтдээ 1.75 хувиар буурлаа.

“Рин Тинто”-гоос дэлхийн удсууд жилд 15 сая тонн зэс ашиглаж байна гэсэн судалгаа гаргасан байдаг. Тэгвэл манай нийт экспортын орлогын 38.1 хувийг зэс бүрдүүлж, үүнээс 37.1 хувь нь зэсийн баяжмал үлдсэн нэг хувь нь сайжруулсан зэс болон зэсээр хийсэн бүтээгдэхүүн байдаг. Монгол Улс өдгөө жилд ойролцоогоор 130 мянган тонн зэс олборлож буй бөгөөд энэ нь дэлхийн зэсийн нийлүүлэлтийн 0.9 хувийг эзэлдэг аж. Оюутолгой төслийн олборлолт эхэлснээр энэ тоо 500 орчим мянган тонноор нэмэгдэх бөгөөд нийт зэсийн дөрвөн хувийг манайх дангаараа хангах юм байна.

“Хөдөө аж ахуйн бирж” анхны арилжаагаа хийлээ. Туршилтын арилжаанд 18 компанийн брокер оролцсон бөгөөд зөвхөн ноолуур

арилжсан байна. Захиалгын хувьд нэг тэрбум 439 сая төгрөгийн буюу 21 мянга 770 килограмм ноолуур худалдан авах санал ирсэн бол 434 сая 967 мянган төгрөг бүхий 5960 килограмм ноолуур худалдах захиалга иржээ. Мөн биржээр арилжаалаагүй ноолуурыг хилээр гаргахыг хориглосон байна.


“Амгалан”-гийн

дулааны станц барих газрыг чөлөөлөх ажлын хүрээнд УС-15-ын тоног төхөөрөмж, барилга байгууламжийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хассан байна. Одоогоор 987 сая орчим төгрөгийг барилга буулгах, газар чөлөөлөх ажилд зориулан шийдвэрлэсэн бөгөөд ирэх сарын 1 гэхэд газрыг чөлөөлж бүрэн дуусгана гэж тооцжээ. “Амгалан” дулааны станц ирэх арванхоёрдугаар сард эхний ээлжийн зуухаа ашиглалтад оруулах юм байна.



Энэ жил улсын хэмжээнд нийт 393.5 мянган га талбайд тариалалт хийхээр төлөвлөжээ. Төрлөөр нь авч үзвэл 324.7 мянган га талбайд үр тариа тариалах гэнэ. Үүнээс 313.7 мянга нь талбайд улаан буудай, 15.5 мянган га-д хүнсний ногоо, 20.7 мянган га-д малын тэжээл, тосны ургамал 25 мянган га талбайд тариалахаар төлөвлөсөн байна. Мөн 2014 оны тариалалтад зориулж 330 мянган га талбайн уриншийг энэ зун бэлтгэх аж.

Унгар улс дахь Эрчим хүчний зохицуулагчдын бүсийн нийгэмлэг (Energy Regulators Regional Association) -ээс Азийн зарим орны хэрэглэгчийн цахилгааны үнийг харьцуулсан судалгаа гаргасан байна.



Монгол Улсад нүүрс олборлолтын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд

УЛС	ГХОААН-ийн тоо
БНХАУ	18
Монгол-БНХАУ	9
Британи Виржини Арлууд	8
Сингапур	3
Австрали	2
Канад	2
Люксембург	2
Монгол-ОХУ	2
Люксембург, Британи Виржинж арлууд	1
Люксембург, Сейшалын арлууд	1
Монгол-АНУ	1
Монгол БНСУ	1
Монгол-БНХАУ /Хонконг/	1
Монгол-Люксембург	1
Нидерланд	1
Нийт	54

Эх сурвалж: ЭЗХЯ

ДЭЛХИЙ ДАХИНД



Оросын банк 2012 онд 49 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний гүйлгээ бүхий сэжигтэй үйл ажиллагааг олж тогтоожээ. “Оросын төсөв “сүүдэр доорх” бизнесийн үйл ажиллагаанаас үүдэн 30 сая ам.доллараар дутаж байна” хэмээх мэдээлэл өнгөрсөн сард хэвлэлээр гарч байсан. Тэгвэл дээрх асуултад тайлан хариулж байна. Мэргэжилтнүүд үүнийг дээрх сэжигтэй үйл ажиллагаа буюу тодорхой үйлчилгээ эрхэлдэггүй компаниудтай холбоотой гэснийг Russia Today мэдээллээ.

Хятад улсын хөрөнгийн урсгал түр хугацаанд гадагш чиглэх бөгөөд хянан зохицуулах боломжгүй гэдгийг тус улсын гадаад валют хариуцсан мэргэжилтэн мэдээлжээ. Үүнийг дэлхийн эдийн засгийн сэргэлт удааширч, хөгжингүй эдийн засагтай орнууд бодлогоо өөрчлөх, геополитикийн зөрчилдөөн гүнзгийрэх, гадаад өрийн хямрал дордох зэрэг нөхцөл байдалтай холбон тайлбарлаж байна.



Киприйн эдийн засаг банкны дампуурлаас үүдэн хүндхэн байдалтай байна. Тус улс 10 тэрбум еврогийн тусламж авахын тулд санхүүгийн цогц арга хэмжээ авч байна. Банкны тогтолцоо, Засгийн газрын санхүүжилтийг тогтворжуулах зорилгоор хүүгийн орлогын татвар 30 хувь, байгууллагын татвар 12.5 хувь хүртэл нэмэхээр болжээ. 100 мянган еврогоос дээш хадгаламж эзэмшигчид 60 хүртэл хувиар алдагдал хүлээж болзошгүй байгаа ч шийдвэр хараахан гараагүй байна.



Dow Jones, S&P 500 индексүүд энэ сард Wall Street дэх бүх цаг үеийн хамгийн өндөр түвшинд хүрэв. Dow Jones 89-өөр өсч, 14.684-т хүрч, хаалтын ханшаа 14.662-оор хийсэн байна. Харин S&P 500 1570-аар хаалтаа хийж, шинэ амжилт тогтоосон нь АНУ-ын эдийн засагт хөрөнгө оруулагчид итгэх итгэлээ дахин олж авч байгааг харуулж байна.

Азийн хөгжлийн банкнаас Азийн орнуудын 2013 оны эдийн засгийн ерөнхий байдлыг

удаашралтай сэргэж байна гэж дүгнэлээ. Энэ нь юуны өмнө Европын бүсэд үргэжлэх хямрал болон Ази дахь улс төрийн түгшүүртэй байдалтай холбоотой аж. Гэсэн ч Хятад болон Индонези тэргүүтэй улсуудын эдийн засаг сайжрах төлөвтэй байна гэж АХБ-ны тайланд бичжээ. Өнгөрсөн онд ДНБ-ий өсөлт 6.1 хувьтай байсан Азийн 45 орон 2013 онд 6.6 хувийн өсөлтөд хүрэх төлөвтэй байгаа аж. ■



А.АМАРСАЙХАНЫ БУЛАН





Шог зургийг А.Амарсайхан

ТӨСӨВ

НӨХӨӨСНИЙ ТӨСӨВ

Б.ЭНХЦЭЦЭГ

Батлагдсан даруйдаа “сэрүүн зүүдэлсэн” төсөв хэмээн адлагдсан Монгол Улсын энэ жилийн төсөв захирагдах ёстой хуулийнхаа хормойд чирэгдэж чадах эсэх нь эдийн засагт үүсээд буй зарим нөхцөл байдлаас үүдэн тодорхойгүй байна.

Төсөв төрхөмдөө буцаж, төр баталсан хуулиа дахин уландаа гишгэх нь үү гэх хардлага олны дунд төрөх болсон. Монгол Улсын төсөв өнгөрсөн жилүүдэд тодорхой тооцоолол, тодотголгүй зарлагатай байж үзээгүй. Тэгвэл энэ жилийн төсөв Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах эхний жилийн төсөв гэдгээрээ онцлог. Тодотголгүй, төлөвлөснөөс давсан алдагдалгүй байх ёстой.

Товчхондоо, төсвийн алдагдлыг хоёр хувиас хэтрүүлж үл болно. Сайхан санаа, сайн эхлэл. Гэвч амьдралд буух уу.

Өнгөрсөн онтой харьцуулбал 28.9 хувиар өсөхөөр тооцсон “Төсөв 2013”-ын нийт орлого энэ жилийн хувьд 7.2 тэрбум төгрөгт хүрнэ гэсэн мөрөөдөлтэй. Төлөвлөснөөр болдогсон бол эдийн засаг 18.5 хувиар огцом “үсэрч” ДНБ-ий хэмжээ 17.6 их наяд төгрөгт хүрч гялайлгана. Монголбанк инфляцийг 8.1 хувьд хазаарлан, экспорт 78 хувиар огцом нэмэгдэж, уул уурхайн олборлолт 60 хувиар өсчихвөл дээрх “Ерөөлийн төсөв” газарт бууж ирэх аж. Гэвч...

Гаднын болоод дотоодын байгууллагууд энэ ▶▶

► жилийн төсвийг хэт өөдрөг төсөөлөлд суурилсан учир орлого тасалдах магадлал өндөр хэмээн дүгнээд байгаа. Тухайлбал, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоолсноос үзэхэд 2013 оны төсвийн орлогыг өнгөрсөн оны урьдчилсан дүнтэй харьцуулахад 40 шахам хувиар өндөр байхаар төлөвлөжээ. Уул уурхайн нийт орлого төсвийн 24 хувийг бүрдүүлж, өмнөх оныхоос 62 хувиар өсөхөөр тооцоолсон байна. Энэ нь нэгдүгээрт, Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах хоёрдугаарт, алт, нүүрсний экспорт нэмэгдэнэ гэж үзсэнтэй холбоотой хэмээн Дэлхийн банкны тайланд дурджээ.

Оюутолгойн гэрээг өөрчилснөөр 445 тэрбум төгрөг нэмж халаасална гэж тооцсон ч байдал бүрхэг хэвээр байна. Нээлттэй нийгэм форумын төсөвт хийсэн тойм судалгаа-үнэлгээнд Оюутолгойн үйлдвэрлэл, борлуулалт төлөвлөж буй хэмжээнээс багасах, гэрээний нэмэлт (төсөвт хэдийн туссан) орлогыг олж чадахгүй байх магадлал бий гэж дүгнэжээ. Дээр нь гэрээнд өөрчлөлт орууллаа ч энэ жилийн төсөвт багтах уу эсэх нь эргэлзээтэй.

Нүүрснээс олох орлогыг өнгөрсөн оныхоос 55 тэрбум төгрөгөөр илүү тооцсон нь Эрдэнэс тавантолгойн олборлолт нэмэгдэнэ гэж төлөвлөсөнд оршиж буй. Гэвч өнөөдрийн байдлаар нүүрсний үнэ дэлхийн зах зээл дээр үлэмж хэмжээгээр унаж, зарим уурхай үйлдвэрлэлээ хумих эрсдэл үүсэхээр байна. Үнийн хэлбэлзлээс үүдэн ашиг олох байтугай зардалдаа шатаж болзошгүй монгол нүүрс хил дээр тэг зогсолт хийн, овоорч байна. Энэ жилийн төсвийн бас нэг онцлог нь шинээр хэрэгжиж буй Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу түүхий эдийн гол нэрийн бүтээгдэхүүнийг “тэнцвэржүүлсэн” үнээр тооцож, эрсдэлийг бууруулахыг зорьж буй. Өөрөөр хэлбэл, дунджилж тооцсон энэ үнэ нь 2013 оны хувьд таамаглаж буй дэлхийн зах зээлийн үнээс 18-22 хувиар доогуур байгаа аж. Энэ нь төсөв уг хэмжээний үнийн уналтыг даах ч үүнээс хэтэрбэл “дан нуруугаа хугалуулна” гэдгийг харуулж буй.

Хүснэгт 1. Батлагдсан 2013 оны төсвийн хураангуй

Бүтээгдэхүүнүүд	2012 Тодотгол		Батлагдсан 2013		
	Тэрбум төгрөг	ДНБ-д эзлэх %	Тэрбум төгрөг	ДНБ-д эзлэх %	өөрчлөлт хувь
А. НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖ	5,631.7	34.9%	7,258.1	41.1%	28.9%
В. НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖ	5,530.3	34.3%	7,088.3	40.2%	28.2%
Татварын орлого	4,925.6	30.5%	6,461.5	36.6%	31.2%
Татварын бус орлого	602.9	3.7%	626.0	3.5%	3.8%
С. НИЙТ ЗАРЛАГА БОЛОН ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,312.2	39.1%	7,444.6	42.2%	17.9%
УРСГАЛ ЗАРДАЛ	4,606.3	28.6%	4,906.1	27.8%	6.5%
Цалин хөлс	1,220.9	7.6%	1,406.2	8%	15.2%
Татаас шилжүүлэг	2,363.1	14.6%	2,028.4	11.5%	(14.2%)
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,719.7	10.7%	2,488.9	14.1%	44.7%
Дотоодын хөрөнгө оруулалт	1,409.0	8.7%	2,008.2	11.4%	42.5%
Д. ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ : В-С	(781.9)	(4.8%)	(356.3)	(2%)	
Е. НИЙТ ТЭНЦЭЛ: А-С	(680.5)	(4.2%)	(186.5)	(1.1%)	
Ф. ТОГТВОРЖУУЛАЛТЫН САНД: E-D	0101.4	0.6%	169.8	1%	

Эх үүсвэр: СЯ, 2013 төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Монгол үнэ VS Дэлхийн үнэ

Мөн уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, хэмжээ төсөвт эрсдэл учруулахуйцаар унах уу гэдэг асуудал гарч ирнэ. Энэ жилийн төсвийн дөрөвний нэгийг уул уурхайн орлого бүрдүүлнэ гэж тооцсон. Гэвч уул уурхайн орлогод жил бүр 35-40 хувийн хүнд жин дардаг нүүрсний үнэ уруудсаар байгаа нь салбарынхан цаашлаад улсын төсвийг хүндрүүлж мэдэхийг холбогдох хүмүүс хэлж байна. Хэдий энэ жил уул уурхайн бүтээгдэхүүнүүдийг тэнцвэржүүлсэн үнээр буюу өмнөх жилүүдийг бодвол доогуур үнээр тооцсон ч урд хөрш дотоод болон гаднынхны нүүрсэнд бялуурч, хямд үнэд “башийж” байгаагаас үүдэн үнэ төдийлэн сэргэхгүй бололтой. Мөн Хятадын эдийн засгийн энэ жилийн өнгөөс нүүрсний үнэ, эрэлт ихээхэн хамаарна. “Мандал даатгал” компанийн гаргасан Монгол Улсын эрсдэлийн 2013 оны тоймд “Энэ онд Хятадын эдийн засгийн өсөлт өндөр хэвээр хадгалагдвал нүүрсний үнэ эргээд өндөр түвшинд тогтворжих, эрэлтийн хэмжээ нэмэгдэх бололцоотой. Гэвч Хятадын эдийн засаг тогтвортой байсан ч барилгын салбарт нь саатал үүсвэл нүүрсний үнэ, эрэлтэд сөргөөр нөлөөлнө. Тиймээс 2013 онд Монголын

экспортын нүүрсний үнэ, эрэлтэд тодорхой эрсдэл байна” гэж үзжээ. Учир нь Хятадын Засгийн газрын зүгээс үл хөдлөх хөрөнгийн зах зээл дээрх хөсгийг хязгаарлахаар олон шатлалт арга хэмжээ авч эхлээд байгааг онцолжээ.

Төсөвт боловсруулсан нүүрс нэг тонныг 131.5, коксжсон нүүрс 80.2, чулуун нүүрс 65.5 ам.долларын тэнцвэржүүлсэн үнээр тооцсон /Хүснэгт-2/. Нийт 28 сая тонн нүүрс гадагш худалдаж, 466 тэрбум төгрөгийг ►

График 1. Нүүрсний экспортын хэмжээ, дундаж үнэ



Эх сурвалж: Reuters “Мандал Даатгал” компанийн Монгол Улсын эрсдэлийн 2013 оны тоймоос

► төсөвт оруулахаар төлөвлөсөн байгаа. Гэтэл эхний улирлын байдлаар уг 28 сая тоннын гурван сая хүрэхгүй шахам тонныг хилээр гаргасан аж. “Энержи Ресурс” компани он гарсаар нэг тонн коксжсон нүүрсийг хамгийн өндөртөө 99 ам.доллороор өгсөн удаатай аж. Одоо энэ үнэ 70-80 ам.доллар хүрэхтэй үгүйтэй байгааг холбогдох албаныхан хэлж байна. Дээр нь Тавантолгойн нүүрс хил дээр наашаа, цаашаа ч үгүй гацчихсан байдаг. БНХАУ-ын Төрийн өмчит “Чалко” компанитай хийсэн гэрээ ёсоор “Эрдэнэс Тавантолгой” нүүрсээ тонн тутамд 70 ам.доллараар худалддаг байсан ч үнэ унангуут, урд хөрш Монголыг чангалж, 53 ам.доллараар авах санал гаргалаа. Ерөнхий сайд Н.Алтанхуяг өнгөрсөн сард сэтгүүлчидтэй хийсэн уулзалт дээр Монголын нүүрс 70 ам.доллараас доошилбол их хэмжээний алдагдал хүлээнэ. Тиймээс, үнэ тохиролцохоо хүлээж байна” гэсэн. Монгол Нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирал Т.Наран “Тавантолгой компани “Чалко”-той үнийн хувьд учраа оллоо гэж өөдрөгөөр төсөөлсөн ч энэ жилийн нийт нүүрсний экспорт 15-16 сая тонноос хэтрэхгүй шинжтэй болсон. Төлөвлөснийхөө 50-60 хувьд л дөхөх болов уу” гэсэн.

Монгол Улсын дархан эрхт ганц худалдан авагч нь Хятад. Тус улсын зах зээлийн төлөө юугаа ч өгөхөөс буцахгүй олон орон бий. Хятадын уламжлалт нүүрсний түнш Австрали, Индонезийг сүүлийн үед Орос Мозамбик, Колумб зэрэг улс доогуур үнийн зөрүүгээр өрсөлдөж, зах зээлийг нь тарамдуулах болсон. Мөн энэ жилээс тус улсын тээвэрлэлт сайжирч, дотоодын нүүрс ханган нийлүүлэгчдийн зардал багассанаар Хятад гаднаас авах нүүрсний хэмжээндээ “гар татах” болсныг “Sanford C.Bernstein” судалгааны байгууллага энэ оны эхний тайландаа бичжээ. Хятадын нүүрсний гадаад худалдан авалт энэ жил 47 хувиар буурч, 150 сая тонн болохоор байгаа аж. Тус компанийн Хонконг дахь шинжээч Майкл Паркер “Дотоодын хямд үнэтэй нүүрсний нийлүүлэлт Хятадын гадаад дахь нүүрсний түншүүдийг шахаж, хилээрээ оруулах хэмжээг жилийн турш тасралтгүй бууруулахаар байна. Үүнийгээ дагаад

Хүснэгт 2. 2013 оны төсвийн гол нэрийн бүтээгдэхүүний үнэ, хэмжээний төсөөлөл

	Хэмжээ	Тэнцвэржүүлсэн үнэ	Зах зээлийн үнэ
Зэс	945 мянган тонн	Нэг тонн /6328.9 ам.доллар	Нэг тонн /8,152 ам.доллар
Боловсруулсан нүүрс	5.8 сая тонн	Нэг тонн /131.5 ам.доллар	Нэг тонн / 161.2 ам.доллар
Коксжсон нүүрс(5500 ккал дээш)	14.4 сая тонн	Нэг тонн / 80.2 ам.доллар	Нэг тонн / 96.7 ам.доллар
Чулуун нүүрс (4000-5500 ккал)	5.7 сая тонн	Нэг тонн / 65.5 ам.доллар	Нэг тонн / 83.17 ам.доллар
Нийт тэнцэл (ДНБ-д эзлэх хувь)	(4.2%)	(5.0%)	(1.1%)

Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв

Хүснэгт 3. Уул уурхайн татварын орлогын бүрэлдэхүүн хэсэг: 2013 Төсөв

Бүтээгдэхүүнүүд	Татварын эх үүсвэрүүд (тэрбум төгрөг)				Гаалийн татвар	Бусад	Нийт
	ААНОАТ	Нөөц ашигласны төлбөр	Өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр	Ногдол ашиг			
Алт	15.95	75.1	20.6	-	-	9.9	121.5
Нүүрс	72.9	188.9	74.6	16.30	52.2	61.27	466.1
Зэс	6.3	6.0	7.4	7.23			
Бусад	26.6	76.9	48.9		10.58	7.22	170.3
Дэд-Нийт уул уурхайн орлого	174.1	461.2	298.5	82.30	63.7	177.3	1,252.7
Нэмэлт ОТ орлого	224.5	-	221.3	-	-	-	445.8
Нийт уул уурхайн орлого	398.6	461.2	519.6	82.3	63.7	177.3	1,702.9

Тэмдэглэл: Дэд-нийт уул уурхайн орлого нь Засгийн газрын ОТ уурхайгаас авахаар хүлээгдэж байгаа нэмэлт орлого.

үнэ ч уруудна” гэв. Хэдийгээр Хятадын нүүрсний эрэлтэд нэмэгдэх хандлага байгаа ч хэмжээ ихэслээ гээд үнэ өндийх нь юу л бол. Австрали, Өмнөд Африк, Индонезийн хувьд тус улсад илүү их нүүрс нийлүүлэх боломжтой ч одоогийн үнэдээ эргэлдэж буй нөхцөлд л Хятадын босгыг даван гэдгийг мэргэжилтнүүд хэлж байна. Дэлхийн зах зээл дээр нүүрс хамгийн үнэтэйдээ Австралийн Нью Касел боомт дээр 90-98 ам.долларын хооронд одоогоор хэлбэлзэж байгаа аж. Цагтаа цалгиж, 250 гаруй ам.доллараар хар алтаа хаан сэнтийд залж байсан Австрали хүртэл Хятадын өмнө хошуу дэвсэж, харцаар нь хөдлөхөд хүрээд байна. Монгол Нүүрс ассоциацийн гүйцэтгэх захирал Т.Наран “Манай улсын төсөвт нүүрсний орлого төвлөрөхгүй байх хоёр шалтгаан байна. Үнэ ба хэмжээний бууралт. Монголын нүүрсний нийлүүлэлтийн хэмжээ дан ганц буурах байсан бол нэг хэрэг. Гэтэл түүнтэй зэрэгцэн үнэ доогуур байгаа нь нүүрсний орлого

төлөвлөснөөр төсөвт орж ирэхгүйг харуулж байна” гэсэн юм. Үнэ ба хэмжээний хавсарсан бууралтаас үүдэн төсөвт төвлөрөх ёстой нүүрсний хишиг 466.1 тэрбум төгрөг 150-160 тэрбум төгрөг болж буух магадлал өндөр байгаа аж. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр “Хэрэв Оюутолгойн асуудал шийдэгдэхгүй аваас төсвийн орлогод нөлөөлөх нь ойлгомжтой. Мөн нүүрсний орлого ихээхэн нөлөөлнө. Өмнөх оны төсвийн хүндрэл гэрээний үнээр нүүрсээ зарсантай холбоотой гэдгийг бид санах хэрэгтэй. Өнөөгийн түвшинд гэрээний үнийг хэрэглэх боломжгүй” гэсэн. Тэгвэл энэ сарын 1-нээс мөрдөхөөр төлөвлөсөн угаасан нүүрс тонн тутам нь 134.8, түүхий нүүрс 74.4 ам.долларын жишиг үнэд хувийн хэвшлийнхэн ихээхэн шүүмжлэлтэй хандаж байна. Энэ нь Хятадын Шанси мужийн хил дээрх үнэ бөгөөд Монголын зах зээлийн нүүрсний үнээс хавьгүй өндөр байгаа аж. Өөрөөр хэлбэл дээрх үнээс ►

Монголын нүүрс бараадхааргүй доогуур байна. Үүнээс үүдэн төр өөрийн компани болох Эрдэнэс Тавантолгойгоо хазаарлаж, Хятадын санал болгосон 53 ам.доллараар нүүрсээ өгөхгүй гэж гэдийн үйл ажиллагааг нь зогсоогоод байна. Одоо үйл ажиллагаа явуулж буй “МАК”, “Энержи Ресурс” хоёр хөл дээрээ дэнжигнэн чардагж байгаа ч удахгүй Эрдэнэставантолгойн араас ороход ойрхон байна. Нүүрсний үнэ газардаж буй өнөөгийн нөхцөлд жишиг үнийг салбарынхны хүзүүд тулгавал үйл ажиллагаа зогсох нь тодорхой. Компаниуд нам зогсвол, улс нүүрснээс авах татвар ч үгүй болно гэдгийг Монгол нүүрс ассоциацийнхан хэлж байна. Нүүрсний үнийн уналтаас үүдэн төсвийн орлого дутах нь бараг тодорхой болоод байна. Жишиг үнээр аргалахыг хичээвч их санасан газар есөн шөнө хоосон хононо гэгчээр хямд үнэтэй нүүрсний орлого байтугай авах татвар нь ч сох дутах вий.

Хэрвээ ингэвэл яах вэ?

Энэ жилийн төсвийн эхний улирлын гүйцэтгэл хараахан гараагүй байна. Магадгүй төсөв дутна, орлого тасарна гэж одоо хэлэхэд эртдэж ч мэднэ. Гэвч огцом эргэлт, өөрчлөлт л гардаггүй юм бол одоогийн нөхцөл байдалд олон улсын эдийн засагч, шинжээчдийн хийсэн таамаг, эрсдэлийн үнэлгээ хол зөрөх нь юу л бол. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгс “Энэ оны төсвийн орлогын бүрдэлт нэлээд тасрах магадлалтай. Засгийн газраас томоохон хэмжээний төсвийн алдагдалтай жил болох нь ээ гэдгийг сануулсан. Энэ тохиолдолд хамгийн түрүүнд хөрөнгө оруулалтын зардлаа танадаг нь манай түгээмэл тогтолцоо болсон. Төсвийн төлөвийг хэт өөдрөгөөр төсөөлсөнтэй холбоотой хөрөнгө оруулалтын зардлаа бууруулахаас өөр аргагүйд хүрдэг” гэв. 2013 оны төсөвт “бодит” хөрөнгө оруулалтын зардлын өсөлт нь урсгал зардлын өсөлтөөсөө илүү байгаа нь өмнөх жилүүдтэй харьцуулахад ахиц гэж мэргэжилтнүүд дүгнэсэн /График 2/. Сэргэн мандалтын шинэ эрин дээр ирсэн улсын хувьд ид хийж бүтээдэг


үе нь одоо. Үүнд юу хэрэгтэй вэ гэвэл хөрөнгө оруулалт. Тэгвэл энэ жил орлого тасалдаж, аль зардлаа яаж, хэрхэн танах вэ гэсэн асуудал босвол хаашаа харах вэ. Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсийн дарга Э.Батбаяр “Засгийн газрын хэмжээнд Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулахад нэг жилээс багагүй хугацаа орох байх. Уул уурхайн салбарын төлөвлөж байсан орлого багаслаа гэж үзэхэд хөрөнгө оруулалт болон урсгал зардлынхаа аль нэгийг нь танах сонголт үлдэнэ. Ирээдүйгээ бодвол бүсээ чангалаад, урсгал зардлаа хасах. Харин өнөөдрөө бодвол хөрөнгө оруулалтын зардлаа танах гарц бий. Гэхдээ байдал энэ хүртэл явахгүй байх” хэмээсэн юм.

Төсөв дутлаа гэхэд аль халаас руугаа гар дүрэх нь Монгол Улсын өнөөгийн нөхцөлд маш чухал гэдгийг хувийн хэвшлийнхэн ч хэлж буй. “Мандал Женерал Даатгал” компанийн ерөнхийлөгч Ө.Ганзориг “Орлого тасарсан ч ирээдүйд ашиг болох хөрөнгө оруулалтын зардлаа энэ үед хумих ёсгүй. Тэгснээс урсгал зардал руу орсон нь дээр. Одоо төсөв алдагдалтай ч хөрөнгө оруулалт урт хугацааны санхүү, эдийн засгийн зөв тооцоололтой байж чадвал хэдэн жилийн дараагаас ашгаа өгч, алдагдлаа нөхнө” гэв. Нээлттэй нийгэм форум судалгаандаа уул уурхайн салбараас хэт хамаарал бүхий эмзэг байдал буураагүй нөхцөлд

таваарын үнэ тооцоолж байснаас унавал яах вэ гэсэн эрсдэлийн нөөц төлөвлөгөө энэ төсөвт алга байгааг тусгажээ. Мөн хөрөнгө оруулалтад төсөв, гадаадын зээлээс бусад эх үүсвэрийг ашигладаггүй. Мөн хүлээж буй үр ашиг нь ч тодорхойгүй байгааг шүүмжилжээ.

Төсвийг анхнаас нь ул суурьтай зохиодог байх зарчмыг чанд баримтлах нь зүйтэй гэдгийг мэргэжилтнүүд байнга л хэлдэг. Энэ жилийн төсвийн алдагдлыг хоёр хувьд нь барина гэж заасан. Гэвч эхний улирлын байдлаар Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоолсноор улсын төсөв зургаан хувийн алдагдалд хүрч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хоёр хувийн хязгаараа зөрчихөөр байгаа. Гэвч дээрх алдагдлын хэмжээ төсвийн нэмэлт зардлыг төр хэрхэн төлөвлөхөөс шалтгаалан хэлбэлзэнэ гэдгийг мөн тэд хэлж буй. Олон улсын жишгээс үзэхэд төсөв өнөө, маргаашдаа заавал ашигтай гарах албагүй. Гэхдээ л орлого, зарлагын төлөвлөлтөө илүү бодитоор гаргаж, тодорхойгүй орлогуудыг багтааж, цээжний хонжоо хийгүй байх, эрсдэлээ урьдчилж тооцон түүнийгээ хэрхэн бууруулах тал дээр “Б” төлөвлөгөөтэй байх нь төсвийн баримтлах зарчим. Энэ жилийн төсөвт шинэлэг сайн талууд гарсан ч зарим “муу зуршлаа” таягдан хаяагүйн улмаас дахин хойд хормойгоо тасдан онгойлгож, урд хормойгоо нөхөхөд хүрэх бололтой. ■

График 2. Шинэ хөрөнгө оруулалт болон засварын үйлчилгээний өсөлт




Эх үүсвэр: Сангийн яам, 2013 оны төсөв, Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

Төсвийн цоорхойг хэрхэн нөхөх вэ?



Ц.Батсүх /СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор/



Б.Мөнхсөёл /“Нээлттэй нийгэм форум”-ын судлаач/

Төрийн цомхон, хүртээмжтэй бүтэц бий болгох нь зүйтэй

-Төрөөс стратегийн чиглэлтэй болон улсын эдийн засгийн үүргийн дагуу хийж байгаа хөрөнгө оруулалтыг төсвөөс санхүүжүүлэх ба хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр санхүүжүүлэх гэж ангилах шаардлагатай. Эдийн засгийн хөгжлийн бодлого, стратегитэй холбоотой үйлдвэржүүлэх, ажлын байр бий болгох, өөрийн үйл ажиллагаагаар ашиг олдог бизнес, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалтыг төрийн бодлогоор дэмжиж, хөрөнгө оруулалтын банкаар дамжуулан санхүүжүүлэх хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл, эдгээр үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх эх үүсвэрийг төр олж өгч байгаа гэсэн утгаар хандах. Энэ нь цэвэр хөрөнгө оруулалтын эсвэл Хөгжлийн банкны үйл ажиллагааны журмаар явах нь зүйтэй. Чингис бондыг Хөгжлийн банкинд байршуулж, хөрөнгө оруулах төслүүдийг шалгаруулан санхүүжүүлж, эргэн төлөгдөж, өсөн нэмэгдэх үр ашгийг нь харгалзах шаардлагатай. Түүнчлэн Сангийн яам, Хөгжлийн банкны хооронд эзэн, төлөөллийн байгууллагын зарчмаар гэрээ хийж үүнийг зохицуулбал илүү зохистой. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувиар тооцвол манай улсын эдийн засаг дахь төрийн оролцоо маш их байгааг илтгэж байна. Иймээс төрийн үүрэг, чиглэлийг харгалзан цомхон, хүртээмжтэй бүтэц бий болгох нь зүйтэй. Мөн урсгал зардлыг хэмнэх чиглэлд дорвитой арга хэмжээ авах хэрэгтэй.

Гаднын хөрөнгө оруулалтыг татах нь дөхөм гарц

-Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлснээр төсвийн алдагдлыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүй байх, мөн бусад шалгуур үзүүлэлт зохистой хэмжээнд байхаар төлөвлөсөн. Гэтэл одоогийн байдлаар энэ заалт, мөн хуулийн бусад заалт ч биелэх боломжгүй байдалд ороод байна. Энэ оны төсвийн төслийг хэлэлцэж байх үед манайхаас төсвийн саналд тойм судалгаа хийн үнэлгээ өгөхдөө төсвийн орлого, зарлага маш эмзэг тооцсоныг сануулж байсан. Богино хугацаандаа төсвийн орлогыг төлөвлөхдөө гол нэрийн түүхий эдүүдийн үнийг “тэнцвэржүүлсэн” үнээр тооцдог болсон нь эрсдэлийг тооцох шинэ практик болсон ч өөдрөг төсөөлөлд суурилсан. Үүний улмаас төсвийн орлого төсөвлөснөөс бага байх эрсдэл бодитой байсан. Урт хугацаанд бидэнд уул уурхайн бүтээгдэхүүний үнийн болзошгүй цочролд үзүүлэх хариу үйлдэл, нөөц төлөвлөгөө алга байна. Тиймээс төсвийн тодотгол хийх нь гарцаагүй. Тогтворжуулалтын сан ажиллаж эхэлж байгаа нь цаашид төсвийн алдагдлыг зөвхөн өрийн эх үүсвэрээр шийдэж ирсэн байдлыг өөрчлөх ач холбогдолтой. Гэвч одоогоор бидэнд дорвитой цугларсан мөнгө байхгүй.

Төсвийн дотор болон гадна олон тооны тусгай сан бий болж их хэмжээний мөнгө зарцуулж байгаа. Үүний дийлэнх нь санхүүгийн хувьд үр ашиггүй, татаасаар санхүүжиж байгаа ч нийтэд хаалттай, мэдээлэл ил тод бус байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь үндэслэл, судалгаа, үр ашиг муутай ч засч залруулах ажил хангалттай хийгдэхгүй байгаа. Гэхдээ манай төсвийн ихэнх зардлыг урсгал зардал эзэлбээс бодлогын хэрэгжилт болон бүтээн байгуулалтын ажлууд хийгдэхгүй, эдийн засгийн үр ашиг, өсөлтийн тухай ярих боломж муутай болно. Мөн бондын орлогоор зарим нэг төсвийн цоорхойг нөхөх саналууд цухалзаж байгаа нь манай улсын өрийн дарамтыг нэмэгдүүлнэ гэдгийг байнга санахад илүүдэхгүй. Гаднын хөрөнгө оруулалтыг татах нь ойрын үед хамгийн дөхөм гарц болов уу. Үүнээс гадна, төсвөөс үзүүлж буй нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэх хэрэгтэй.



Б.Түвшинтөгс /Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор/

Төсвийг бодитой төсөвлөдөг байх зарчмыг хатуу баримтлах шаардлагатай

-Чингис бондоос санхүүжүүлэх төслүүд одоогийн байдлаар тодорхойгүй байна. Зарчмын хувьд Хөгжлийн банкнаас болоод Чингис бондоор санхүүжигдэх төслүүд төсвийн гадуур хийгдэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үзэл санаанаас гажсан хандлага болно гэдэгтэй санал нэг байна. Чухамхүү баталсан хуулийнхаа хүрээнд ажиллаж байж бид “Голланд өвчин”-өөс дархлагдах боломжтой. Үүнээс гадна дэд бүтцийн бүтээн байгуулалтууд улсын төсөвт орж ирснээр төслүүдийг ач холбогдлоор нь ялгах, хяналтыг нь сайжруулах, цаашилбал төсөл үр ашигтай болох боломж нь нэмэгдэнэ гэж үзэх үндэстэй. Учир нь одоогийн байдлаар төсвөөс гадуур хийгдэх төслүүдийн хяналт тэр бүр тодорхой биш, ойлгомжгүй байдалтай байгаа нь санаа зовоох асуудлуудын нэг болчихоод байна.

Энэ оны хувьд төсвийн орлого нэлээд тасрах магадлалтай байна. Засгийн газраас төсвийн ихээхэн алдагдалтай жил болох нь ээ гэдгийг сануулсан байгаа. Төсвийн орлого тасалдах тохиолдолд хамгийн түрүүнд хөрөнгө оруулалтын зардлыг танадаг нь манай улсад түгээмэл. Энэ нь төсвийн төлөвийг хэт өөдрөгөөр төсөөлсөнтэй холбоотой учраас хөрөнгө оруулалтын зардлаа бууруулахаас өөр арга байдаггүй. Тийм учраас, төсвийг анхнаас нь бодитой төсөвлөдөг байх зарчмыг хатуу баримтлах шаардлагатай. Энэ жилийн төсвийн алдагдлыг хуулийн хүрээнд боломжит дээд хэмжээнд нь тулгаж баталсан нь энэ зарчим алдагдсаны илэрхийлэл.



Ж.Дэлгэрсайхан /СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын багш, дэд профессор/

Бодлогоо эргэн харах хэрэгтэй байна

-Төсвийн цоорхой буюу төсвийн орлого дутах магадлал өндөр байна. Монгол Улсын энэ оны төсвийн орлого болон зардал өмнөх оныхоос мөн л тэлэлттэй байхаар төлөвлөсөн. Төсвийн орлогод уул уурхайгаас олох орлогыг хэт өндөр байхаар тооцсон. Үүнд, Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний асуудлаас гадна нүүрсний экспортын хэмжээ болон үнийг хэт өндөр байхаар төсөвлөсөн. Жишээ нь, нүүрсний өнөөгийн байдлыг харахад энэ оны эхний гурван сарын байдлаар ердөө л 1.4 сая тонныг гадагшаа борлуулсан байна. Уг нь нүүрсний экспортын хэмжээг 34 сая тоннд хүргэхээр төлөвлөсөн. Төлөвлөлт бодит байдлын хоорондын зөрүү их байна.

Дэлхийн эдийн засгийн одоогийн байдал болон БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн төсөөлж байсан үнэ эсрэг хандлагатай гарч байна. Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын үнэ ойрын хугацаанд огцом өсөхгүй байх магадлал өндөр байна. Энэ байдлаас үүдээд манай төсвийн орлого дутах нь тодорхой болж байна. Төсвийн зохистой зарцуулалтад анхаарч, хэмнэлтийн сэтгэлгээг төлөвшүүлэх хэрэгтэй. Үүнээс гадна төсөвт тодотгол хийх замаар төсвийн цоорхойг нөхөх гарц бий. Төсвийн зарим үргүй зардлыг бууруулах, зарим зарцуулалтаас татгалзах, орлого нэмэгдүүлэх арга замыг хайх шаардлага үүснэ. Өөрөөр хэлбэл, төсвийг тодотгох нь гарцаагүй бөгөөд удахгүй хийх хандлага ажиглагдаж байна. Мөн бондын асуудал байна. Бондын мөнгөний зарцуулалт нь хэдийгээр төсвийн гадуур гэж буй боловч энэ нь ирээдүйд төсөвт, эсвэл аль нэг сангийн орлогод хүчтэй нөлөөлөх байдлаар сөрөг нөлөөллийг бий болгоно. Мөн энэ оны төсөвт бондын хүүгийн талаар тусгагдаагүй бөгөөд бид үүнийг төлөх шаардлагатай. Төсөвт гарч буй эдгээр хүндрэлийг эерэг байдлаар харах ганц боломж нь бид өмнө гаргаж байсан болон одоо явуулж буй бодлогоо эргэн харах. Буруу бодлого байвал засах хэрэгтэй. ■

ҮЗЭЛ БОДОЛ

МОНГОЛЫГ НӨМӨРЧ БУЙ ТӨСВИЙН ХЯМРАЛ



Найжил Финч
/Австралийн Сиднейн Бизнесийн
их сургуулийн профессор,
Монголын бизнесийн
зөвлөлийн гишүүн/

Улсын төсвийг гаргана гэдэг гарын дор хийчих ажил гэж хэн ч хэлж байгаагүй. Эдийн засаг агшиж, тэлж байдаг. Тиймээс ч дараа жилийн төсөв энэ жилийн бодит төсөв рүүгээ буцаад эргэдэг тул аль болох эртнээс тооцоо хийх нь боломж муутай байх талтай. Тухайн орлогын гол эх үүсвэр нь уул уурхай гэх мэт урьдчилан тааварлахад бэрх, маш хувьсамтгай хүчин зүйлсээс хамааралтай байгаа тохиолдолд татварын орлогоос Засгийн газарт төвлөрүүлэх хуримтлалыг тооцоход маш хүндрэлтэй байдаг. Австралийн Сангийн сайд Вэйн Максвэлл Свон тус улсын зөрчилдөөн ихтэй “Ашигт малтмалын түрээсийн татвар” (АМТТ)-аас татан төвлөрүүлсэн хуримтлал нь төлөвлөснөөс гайхмаар бага байгаа тухай ярьдаг нь эргэлзээгүй үнэн. Татвар нь таваарын үнэ болон биржийн ханшаас маш их хамааралтай байдаг. Хэврэгхэн, хувьсамтгай зүйлст суурилсан “амбицтай” татварын үр дүн ямар байхыг тааварлахад бэрхтэй. Үүний балгаар Австралид ашигт малтмалын түрээсийн татвар хоёр тэрбум австрали доллараар гэнэт дутсан бөгөөд энэ нь төсвийн илүүдэл мөнгийг дэмий үрж, бодит алдагдлыг улам доройтуулж байна.

Бүхэлд нь авч үзвэл ашигт малтмалын түрээсийн татварын хоёр тэрбум австрали доллар олох гэсэн Сангийн яамны хэт өөдрөг төсөөлөл нь тус улсын нийт хуримтлал болох 360 тэрбум австрали доллартай харьцуулахад ач холбогдолгүй бага тоо. Гэхдээ төсөөллийн үр дүн тийм хол зөрүүтэй гарах ёсгүй. Энэхүү

зөрүү нь бодит алдагдлыг хэдэн тэрбум австрали доллараар ч нэмэгдүүлэх эрсдэл өндөр. Гэвч тогтоогдсон нөөцийн зээлийн төлбөрийн чадвар сайтай болох нь мэдэгдэж буй тус улсын эдийн засгийн хувьд иймэрхүү тааламжгүй гэнэтийн зүйлийг зохицуулах чадвартай байх шаардлагатай.

Гэхдээ уул уурхайгаас ихээхэн хамааралтай, тогтвор муутай, хэврэгхэн эдийн засгийг жолоодож буй Австралийн Сангийн сайдын хүндхэн байдлыг бодолцох хэрэгтэй. Монгол Улсын шинээр гарч ирж буй эдийн засаг Австралийн эдийн засгийн хэмжээтэй харьцуулахад бутархай тоо төдийхнөөр яригдана. Монгол Улсыг үр дүнтэй удирдан жолоодох чадварыг мохоох улс төрийн тогтвортой байдлын талаарх асуудал санаа зовоож буй. Монголын Улсын Засгийн газар 3.5-4 тэрбум австрали долларын татвар хуримтлуулдаг нь Австралийн төрийн өмчийнх нь нэг гаруйхан хувьтай тэнцэж байна. Гэхдээ Монголд хөгжилтэй орнуудын эдийн засагт байдаг “жийргэвч” дутагдаад байгаа хэрэг.

Монгол Улсад Австралид мөрдөгддөг АМТТ гэж байдаггүй. Гэхдээ энэ нь ард иргэддээ зориулсан найдвартай орлогын эх үүсвэрийг бий болгоход шаардагдах үр өгөөж гэхээс илүүтэйгээр сонгуулийн тойрогт дахин санал авах зорилгоор татварын үр дүнгүй бодлогоос зайлсхийсэн гэсэн үг биш. Монгол Улсын татварын хуримтлал ашигт малтмалаас ихээхэн хамааралтай бөгөөд уул уурхайн салбараас хуримтлуулсан роялти, ногдол

▸ ашиг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын гуравны нэгийг эзэлж байна. Эдгээрийн дунд хамгийн том нь Тавантолгой нүүрсний орд, Оюутолгой зэс, алтны орд юм.

Монгол Улсын Засгийн газрын зуун хувь эзэмшилд байдаг Тавантолгой дэлхийн хэмжээнд ашиглагдаагүй байгаа хамгийн том нүүрсний орд газруудын нэг бөгөөд БНХАУ-ын хилд ойрхон байрладаг. Монгол Улсын нийт экспортын тэн хагасаас ч илүү хувийг нүүрс эзэлдэг бөгөөд эдийн засгийн өсөлтөд өндөр хувь нэмэр оруулдаг. Энэ нь улсын төсвийг улам томруулж, аль болох эрч хүчтэй, өөдрөг харагдуулах нөхцөл болж буй хэрэг. Гэвч Засгийн газрын татварын орлогыг хуримтлуулах сайхан боломжид уул уурхайтай холбоотой аюул заналхийлсэн асуудал ар араасаа цуврах болов.

Туршлагагүй менежмент, үр ашиг муутай практик, авлигын сүлжээ зэрэг нь уул уурхайн үйлдвэрлэлийг 50 хувиар бууруулжээ. Бас нэг таагүй хүчин зүйл бол БНХАУ-ын “Чалко” компанитай холбоотой сунжирсан зөрчилдөөн. Энэ нь Монгол Улсын нүүрсний импортын хэмжээг ихээр бууруулж байна. Үүний зэрэгцээ нүүрсний үнэ ихээр унах болсон нь Засгийн газарт хуримтлагдах татварт цаашид сөргөөр нөлөөлөх аюултай.

Энэ зуур уул уурхайн татвар төлөгч Англи-Австралийн хамтарсан “Рио Тинто” компанийн гүйцэтгэгч Оюутолгойн үйл ажиллагаа хойшлох болов. Энэ нь УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой улс төрийн хөндлөнгийн оролцоотой холбоотой. Оюутолгойн уурхай мөн л БНХАУ-ын хилтэй ойрхон байрлах бөгөөд дэлхийн хамгийн том зэс, алтны уурхайнуудын нэг. Уурхай дээр үйлдвэрлэл хараахан эхлээгүй байгаа ч Монгол Улсын Засгийн газар болон эдийн засаг аль хэдийнэ 6.6 тэрбум ам.долларын өгөөж хүртсэн. Уурхайн хөгжлийг эхний шатанд оруулах үүднээс барилгын ажилд хөрөнгө оруулалт хийжээ. Засгийн газар тус уурхайн 34 хувийг, үлдсэн хувийг Рио Тинто эзэмшдэг. Гэвч шинэчлэлийн Засгийн газрын зүгээс байгалийн баялгийг хэт үндсэрхэг болгохыг дэмжиж буй нь үйлдвэрлэл хойшлоход хүргээд байгаагийн зэрэгцээ илүү их хувьцаа эзэмшиж, татварын орлогоо нэмэгдүүлэхийг Засгийн газраас шаардах болов. Талуудын хоорондох маргаан дууссан ч Монгол Улсын хувьд одоо үргэлжилж буй барилгын ажлын дараах үр шимийг хүртэх боломж бага байхын зэрэгцээ энэхүү маргаан нь Оюутолгой бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед авч эхлэх цаашдын татварын хуримтлалыг хойшлуулж буй хэрэг юм.

Монголын төр уул уурхай, ашигт малтмалын экспортоос маш их хамааралтай эдийн засгаараа, үймээн самуун дундах хоёр том төслөөрөө өөрийн төсвөө гаргах томоохон сорилттой тулгараад байна. 2013 онд татварын хуримтлалаа жил бүр 31 хувиар нэмэгдүүлэх “амбицтай” өсөлтийг төсөвлөсөн нь одоогийн нөхцөл байдалд маш тохиромжгүй харагдаж байгаа юм. Зардал ихээр шаардагдах сонгуулийн

амлалтын сунжирсан жагсаалтыг тооцоод үзвэл саналаа алдахгүйгээр Засгийн газар зардлаа бууруулж харагдах нь юу л бол. Айсуй төсвийн хямрал бол Монголын хэврэг эдийн засгийн тогвортой байдлыг цаашид алдагдуулах, санхүүжилтгүй алдагдал юм.

Монгол Улс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа баталсан бөгөөд 2013 оны улсын төсвийг уг хуулийн хүрээнд баталсан нь шинэчлэлийн Засгийн газрын анхны төсөв болж байгаагаараа онцлог. Уг хууль Засгийн газрыг ДНБ-ий хоёр хувиас хэтрүүлэхгүйгээр төсвийн алдагдлыг дээд түвшинд тооцох арга замаар санхүүгийн менежментийг маш чамбай хийхэд зориулсан хууль юм. Гэхдээ энэхүү дээд түвшин алдагдах магадлал өндөр байгаа бөгөөд Дэлхийн банкнаас гаргасан төсөөллөөр төсвийн алдагдал ДНБ-ий зургаан хувиас хэтрэх шинжтэй байна. Энэ томоохон алдагдлыг зогсоосон ч энэ нь Засгийн газрын хувьд сонгуульд саналаа өгөх ард иргэд, гадаадын хөрөнгө оруулагчдад санхүүгийн чадвартай менежер гэдгээ харуулах сайны тэмдэг болж чадахгүй юм.

Монгол оронд нүүрлэж буй төсвийн хямрал гэдэг нь Засгийн газар өөрийн хөрөнгөө санхүүжүүлэх мөнгө олохын тулд арга зам хайх болно гэсэн утгатай бөгөөд хамгийн сайн эх үүсвэр нь өнгөрсөн арванхоёрдугаар сард босгосон 1.5 тэрбум ам.долларын Чингис бонд байх болно. Уг бондын зориулалт нь эдийн засгийн хувьд дэд бүтцийн чухал төслүүдийг санхүүжүүлэх явдал. Гэвч Засгийн газар бүтэлгүйтэж буй төсвөө хөшүүрэгдэхийн тулд бондын хөрөнгийн санхүүжилтийн зориулалтыг өөрчлөхөд хүргэж, “Өгөөш ба өөрчлөлтийн бонд” гэсэн нэр зүүлгэж, бүх зүйл талаар өнгөрөх вий дээ. Иймэрхүү тактик уг бондын үнэ цэнийг алдагдуулж, Монгол Улсын эрсдлийн талаарх гадаадын хөрөнгө оруулагчдын мэдрэмтгий байдлыг улам дордуулж, зээлийн төлбөрийн чадварын түвшин буурахад хүргэж болзошгүй.

Хамгийн томд тооцогдох зарим татвар төлөгчийн өнөөгийн байдал ямар байгаа нь нэгэнт тодорхой учраас Монголын Засгийн газар төсвийн алдагдлаа зогсоох зорилгоор Чингис бондыг зарцуулах гэж байна гэж харж болохоор байна. Гэхдээ үүгээр оролдох нь Засгийн газрын хувьд банкны салбараа дэмжих ямар нэг материаллаг дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадвараа хязгаарлаж байна гэсэн үг. Энэ нь цаашдаа эдийн засгийн чадавхиас хол давсан ханшийн уналт, Засгийн газрын зардлын асуудалтай тулгарч, аюултай байдалд оруулах төлөвтэй байна. Банкны салбар дахь аливаа хямрал нь Монгол Улсын мөнгөн тэмдэгтийг маш түргэн хугацаанд үнэ цэнээ алдахад хүргэх бөгөөд хөрөнгийн үнийг дахин бууруулахад маш хүндрэлтэй болох юм.

Монголд хэт өөдрөг олон эдийн засагч цаашдаа эдийн засгаа Голланд өвчинд нэрвэгдэхээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар удаан хугацаанд бясалгаж, хоосон цэцэрхэлд автан суух зуур зарим нэг эдийн засагч төсвийн бодит төсөөлөл гаргаж, Засгийн газрын санхүүгийн менежментийг чамбайруулахын тулд прагматик талаас нь түлхүү харахад анхаарлаа хандуулж байна. ■

ХУРИМТЛАЛ

АЗ ЖАРГАЛЫН ХЭМЖҮҮР

...Уг санг байгуулах нь эдийн засгийн засгийн хэт халалт, “Голланд өвчин”-өөс сэргийлэх дархлаа юм. Энэ утгаараа Баялгийн сан ирээдүйдээ өгч буй “бэлэг”, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах “бамбай”...

Б.БАЯРТГОХ

Уул уурхайн салбараас орж ирэх мөнгөн урсгалыг монголчууд их, бага хэмжээгээр олуулаа хүртэх болсон. Тиймээс хөгжлийн галт тэргийг урагш зүтгүүлэх таатай боломж ирээд буй. Баялгийг сохроор шүтэх бус хөрөнгө оруулалт хэлбэрээр ирээдүйдээ нөөцлөх холын ухаанд даруй суралцах хэрэг гарч байна. Хөгжлийн галт тэрэг биднийг баялгийн аз жаргал, нөөцийн хараалд хүргэх хоёр туйлтай. Иргэн нь хадгаламжтай, улс нь хуримтлалын сантай байж чадваас ямар ч хямралын өмнө бид өвдөг үл сөгдөнө.

Монгол Улс үрэлгэн, эдийн засгийн тооцоогүй. Олсон бүхнээ зарах өвчтэй. Байгаагаа бардаг, байхгүй бол зээлдэг. Ямар ч санхүүгийн сахилга батгүй гэж гаднынхан хэлдэг нь оргүй биш. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд олсон жаахан орлогынхоо бараг л 99 хувийг олуулаа хуваасан. Маргааш дэлхий сөнөх мэт хавтгайрсан халамж тараасан. Түүнээс бидний амьдралд наалдаж үлдсэн юу байна вэ.

Өнгөрсөн 15 жилийн хугацаанд манай улсын ДНБ нэрлэсэн дүнгээрээ арав дахин, бодит дүнгээрээ хоёр дахин өсч, олны анхааралд өртөв. Ам.доллараар илэрхийлсэн нэрлэсэн ДНБ 1.2 тэрбум ам.доллараас зургаан тэрбум ам.доллар болж өссөн. Ийм өсөлттэй, тэлж яваа эдийн засагт баялгийн сангаас өөр сонголт үгүй гэх. Манайх баялгийн сангийн шинэ тогтолцоог нэвтрүүлэх тухай цөөнгүй жил ярьж буй. Үүний хүрээнд Засгийн газраас Баялгийн сангийн удирдлагыг хэрэгжүүлэх шинэ хуулийн төслийг боловсруулж байгаа аж. Уг сангийн тогтолцоог ёс горимоор нь нэвтрүүлэх, жилдээ орлогынхоо хэчнээн хувийг хуримтлуулах, хэн удирдах эсэхийг судалж байгааг Сангийн сайд Ч.Улаан хэллээ.

Олж буй орлогоо ирээдүйдээ хадгалахын тулд Баялгийн сан байгуулах, түүнийгээ зохистой удирдах нь бидний тулгамдсан асуудал болоод буй. МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, дэд профессор Б.Эрдэнэбат “Байгалийн баялгийн хараал ба Монгол” илтгэлдээ “Байгалийн баялгаас орж ирэх орлого хувьсамтгай. Гэтэл энэхүү хувьсамтгай байдал нь эдийн засгийн урт хугацааны төлөвлөлт, хөрөнгө оруулалт хийх боломжийг хязгаарлаж, хэрэгжсэн ч эх үүсвэрийн тасалдлаас болж ашиг нь төлөвлөснөөс доогуур байхад хүргэдэг. Үүнээс үндэслэн ихэнх тохиолдолд нөөцөөс орж ирэх мөнгө хөрөнгө оруулалтад бус хэрэглээнд зарцуулагддаг” гэж бичжээ.

Манайд Засгийн газраар овоглосон сан байхгүй биш байгаа. Тэдгээр санг Баялгийн, Эргэлтийн, Үүргийн, Нөөцийн гээд хэлбэрийн хувьд ангилж болохоор. Нийгмийн даатгалын сангаас эхлээд Байгаль хамгаалах, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан гэсэн 40 орчим тусгай сан “ажиллаж” байна. Эдгээр сан нь ирээдүйд бус өнөөгийн хэрэгцээг хангаж буй. Үүнийг Баялгийн сантай андуурч болохгүй. Тэд бол нэмэх бус хасах утгатай. Хэзээд зарлага гаргаж, төсвийн халаасыг тэмтэрч байдаг. Тиймээс үр хойчид хүртээлгүй гэсэн үг.

Баялгийн сан нь ихэвчлэн төрийн өмчит хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр оршин тогтнодог бөгөөд өөрийн гэсэн хуультай. Сангийн орлого түүхий эдийн экспортын орлого, төлбөрийн тэнцэлийн илүүдэл, төсвийн ашиг, валют арилжаанаас олсон ашиг болон хувьчлалын орлогоос бүрддэг аж. Баялгийн сан нь байгуулагдсан зорилгоороо тогтворжуулалтын, хуримтлалын, болзошгүй нөөцийн сан гэсэн ерөнхий гурван төрөлд ▶



▸ хуваадаг. Сан нь олон улсын зах зээлд хөрөнгө оруулалт хийх, хувьцаа, бонд, үнэт металл болон бусад төрлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө байршуулах хэлбэрээр ажиллаж иржээ.

Хэлбэр талаасаа Тогтворжуулалтын сан Баялгийн сангаас ялгаатай ч агуулга нь ижил гэж үзэж болохоор. Өөрөөр хэлбэл, нэг зоосны хоёр тал. Гэхдээ зохицуулалт нь ондоо. Тиймээс Баялгийн санд Хүнийн хөгжил болон Тогтворжуулалтын санг нэтгэх нь зүйтэй гэж үзэх нэгэн ч бий. Уг асуудлыг нэгтгэн, энэ онд багтан УИХ-ын чуулганд танилцуулах ажлын хэсгийг Сангийн яамнаас байгуулжээ. Тус яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын Баялгийн сангийн хэлтсийн дарга Б.Төгөлдөр “Баялгийн сангийн тухай хуулийн төслийг энэ жилдээ багтаан УИХ-ын чуулганд оруулна” гэв.

Баялгийн сан үндсэндээ хөрөнгө оруулалтын байгууллага юм. Сангийн амжилт нь эцсийн дүндээ хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас олох тогтвортой хөгжил болохыг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкныхан хэлж буй. Өөрөөр хэлбэл, дунд болон урт хугацаандаа эдийн засагт баялаг бүтээх хөрөнгийг хэлж буй. Уг санг байгуулах нь эдийн засгийн засгийн хэт халалт, “Голланд өвчин”-өөс сэргийлэх дархлаа юм. Энэ утгаараа Баялгийн сан ирээдүйдээ өгч буй “бэлэг”, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах “бамбай”.

Олон улсад Баялгийн сан үүсгэх замаар эдийн засгаа “Голланд өвчинд” нэрвэгдэхээс сэргийлж, улс орныхоо хөгжилд хувь нэмэр оруулж буй сайн туршлага цөөнгүй бий. Тэдний нэг нь Зүүн Тиморын

сан. Манайхтай инфляцийн түвшин нь ижил, хүн амын тоо ч ойролцоо. Тэдний газрын тосны орлого нь жилд 2.75 тэрбум ам.доллар. Энэ нь Засгийн газрынх нь нийт орлогын 95 хувийг бүрдүүлж байна. Үүнээс өөр орлого олоод байх зэс, нүүрс, төмрийн хүдэр, жонш байхгүй. Гэсэн ч хөгжлийн түвшин, нэг хүнд ногдох ДНБ-ий орлогоороо биднээс түрүүлж явна. Газрын тосноос олж буй орлогоороо сан байгуулж, түүндээ 10 тэрбум ам.долларын хөрөнгө хуримтлуулж амжсан баян орон.

Газрын тосны орлого нь 30 тэрбум ам.доллар болох Зүүн Тиморын сангийн хадгаламж энэ хэрээр өсөх нь гарцаагүй. Сангийн баланс нь 11 тэрбум ам.доллар. Зорилго нь Зүүн Тиморын ард, иргэдийн урт хугацааны сайн сайхны төлөө үр дүнтэй санхүүгийн бодлогыг дэмжин хэрэгжүүлэх. Үүний төлөө ажиллаж буй сан өнөө болон ирээдүй хойч үед баялгийн ашиг тусыг хүртээхийг зорьдог аж. Тус улсын Сангийн яамны Санхүүгийн бодлого, газрын тосны сангийн зөвлөх асан Видар Овесен “Эдийн засгийн хүндрэлтэй үед ашиглах, зохистой бус зарцуулалтыг хязгаарлах, хойч үед хүргэх зорилгоор эдийн засгийн нөөцтэй байх нь чухал. Газрын тосны орлого тогтворгүй бөгөөд хязгаартай тул газрын тосны санг хуримтлал үүсгэх байдлаар байгуулсан” хэмээн “Үр ашигтай баялгийн сангийн удирдлага” сэдэвт олон улсын хуралд оролцох үеэр хэлсэн юм.

Монгол ашигт малтмалын нөөцөөрөө Австралийг Казахстантай нийлүүлсэнтэй тэнцэнэ. Нүүрс, алт, зэсийн ордын хосолсон баялгаараа Ази тивд ганцхан хувь. Эдийн засаг нь сүүлийн ▸

▶ 15 жилийн хугацаанд огцом өсч буй Монгол Улсад баялгийн сан цоо шинэ үзэгдэл биш ээ. Ботсвана, Чили, Катар, Кувейт, Норвегийн Баялгийн сангийн тухай бид дуулаагүй бус сонссон. Тэдний үнэтэй зөвлөгөөг авсан. Гэсэн ч төсөөлж буй Баялгийн сангаа байгуулж чадаагүй явна. Баршгүй баялагтай хэрнээ дөмөгхөн амьдарч чадахгүй байна.

Жонш, цайр, мөнгө, төмрийн хүдэр гээд газрын хэвлий рүү өнгийх аваас эдийн засгийн боломж нь байх Монгол Улс хэний загвараар замнах гэж байна вэ. Чили үү, Нигерийнх үү. Нэг нь баялгаасаа болж баларсан, нөгөө нь хөгжилд хүрсэн. Дээрх хоёр орны бэлэн жишээ бидний өмнө байна.

Баялгийн сан бол ирээдүйн өмч болохоос өнөөдөрт зарцуулах, түүнээс одоо цагийнхан хувь хишиг горьдох “Хүний хөгжил сан” биш. Энэ оноос хүчин төгөлдөр хэрэгжиж буй Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн мөн чанар нь байгаагаа үрэх бус хадгалах. Ихийг олсон ч зөв зарцуулах, зарж байгаагаа ухаалаг хэмнэх. Байгалийн баялгаас орж ирэх гэнэтийн орлогыг эдийн засагтаа зөв шингээх. Сорилт бас ирээдүйн зорилго тээсэн Төсвийн тогтворжуулалтын санд хадгалах. Уг хууль төсвийн тогтвортой байдлыг яв цав хангаж чадваас Баялгийн сан хөлжих юм. Нэг талаасаа Төсвийн тогтворжуулалтын сан Баялгийн сангийн үүргийг давхар гүйцэтгэж буй. Баялгийн сан нь байхгүй учраас Тогтворжуулалтын сангаар орлуулж байна гэж үзэж болохоор. Гэхдээ Тогтворжуулалт болон Хүний хөгжил санг нэтгэн, эрх зүйн орчинг боловсронгуй болгосноор Баялгийн сангийн тогтолцоог байгуулах боломжтой аж.

Өнөөдрийн байдлаар Тогтворжуулалтын санд 330 гаруй тэрбум төгрөг байгаа аж. Уг мөнгийг хэн, хэрхэн удирдах зохицуулалт тодорхой биш байгаагаас Монголбанкн дахь тусгай дансанд хүүгүй байршуулжээ. Уг нь хүүгээр төлжиж байх мөнгө өнөөгийн үнэ цэнээ алдаж, өндөр инфляцид идэгдэж байна. Нэг талаасаа төсвийн орлого хүндрэх үед ашиглаж болох нөөц юм.

Баялгийн сангийн зорилго нь ашигт малтмалаас олсон орлогоо оновчтой удирдан өнөөгийн хэрэгцээ хангахаас гадна хойч үедээ хуримтлал үлдээх. Өөрөөр хэлбэл, хүүхдийнхээ ирээдүйн төлөө сар бүр хадгаламжийн дэвтэр нь 20 мянган төгрөг хийх бидний өдөр тутмын амьдралын нэг хэсэг юм. Хэмжээ нь том болохоос зорилго нь ижил. Үүнээс гадна Баялгийн сан байснаар зөвхөн ирээдүйдээ хуримтлал хадгалахын сацуу эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж байдаг эерэг талтай. Тиймээс хоёр талд ашигтай гэсэн үг. Үнийн өсөлт, өндөр инфляци, хязгааргүй эрэлтийг хазаарлахад ач тустай. Уг санд төвлөрсөн хөрөнгийг санхүүгийн төрөл бүрийн хэрэгсэлд оруулж, хүүгээс нь ашиг олж болдоороо дээр өгүүлсэн Тогтворжуулалтын сангаас зарчмын хувьд бага зэрэг ялгаатай. Баялгийн сангийн хөрөнгөөр төсвийн алдагдлыг нөхөх боломжгүй. Харин Тогтворжуулалтын сангаас төсөвт туслалцаа үзүүлж болох аж. Гэхдээ

төсөв тогтвортой байснаар Баялгийн сан орлогожино гэсэн үг.

Оруулсан хөрөнгө нь ариаж байдаг “ид шидтэй” санг байгуулахаар Сангийн яамныхан толгойгоо гашилгаж сууна. Сангийн сайд Ч.Улаан “Урьдчилсан байдлаар хоёр Баялгийн сантай байх нь зүйтэй. Нэг нь төсвийн тогтвортой байдлыг хангах зорилготой Төсвийн Тогтворжуулалтын сан, нөгөө нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, уул уурхайн орлогын үе хоорондын хуваарилалтыг тэгш болгох зорилттой ирээдүй үеийн сан. Баялгийн сангийн хөрөнгийг ард түмний хяналтад, хараат бус бие даан, ил тод хариуцлагатай удирдах бүх нөхцөл, боломжийг хуулиар бүрдүүлнэ” гэж мэдэгдсэн.

Нөхөн сэргээгдэхгүй, хязгаарлагдмал байгалийн баялгийн орлогын тодорхой хувийг үр өгөөж өгөх хадгаламж буюу санхүүгийн нөөц хэлбэрээр ирээдүй үедээ өвлүүлж болохыг салбарын сайд тайлбарласан юм. Дэлхийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт сангуудын гуравны хоёр буюу 70 хувь нь байгалийн баялгийн орлогоос Баялгийн сангаа байгуулсан байдаг.

Австрали улсын шилдэг зөвлөх Брайн Фишер “Байгалийн баялгаар баян зарим улс хөгжиж чаддаггүйн гол шалтгаан нь санхүү, эдийн засгийн оновчгүй бодлого болон эдийн засгийн үр ашиггүй хөрөнгө оруулалтын хойноос хөөцөлдсөнд оршдог. Байгалийн нөөцөөс олох ашгийг оновчтой зарцуулах арга бол Баялгийн сан” гэж онцолсон. Тэрбээр “Байгалийн нөөцөөс олох гэнэтийн ашгийг оновчтой зарцуулах нэг шалгарсан механизм бол үндэсний баялгийн сан буюу хадгаламжийн сан. Ийм сан нь нөөц баялаг дууссан ч гэсэн хойч ирээдүй түүний хувиас хүртэх боломжийг олгоно. Өөрөөр хэлбэл, газрын хэвлийн эрдэс, баялаг ирээдүй хойч үед санхүүгийн хөрөнгө, хэрэгсэл болж үлдэж байгаа юм” гэв. Мөн олон улсад баялгийн сан олон байдаг ч үр дүн, амжилтын хувьд харилцан адилгүй. Гэхдээ муу засаглал, сул институцтэй оронд баялгийн сан амжилт олдоггүй нь нийтлэг болохыг Брайн Фишер бидэнд сануулсан.

Өнөөдрийн байдлаар дэлхийн хэмжээнд 60 гаруй орон Баялгийн сан байгуулжээ. Төсвийн оновчтой бодлогын хүрээнд Баялгийн сантай болсон дээрх орон ирээдүйнхээ өмнө нүүр бардам зогсох итгэлийг олж амжжээ. Монгол Улсын ДНБ-ий гуравны нэгтэй тэнцэх хэмжээний орлогыг бүрдүүлэх “Оюутолгой” төслийн үйлдвэрлэл удахгүй эрчимжиж, “Тавантолгой” гацаанаас мөдхөн гарах гэж байна.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Баялгийн сан улс төрийн амлалт хэрэгжүүлдэг, санхүүжүүлдэг байж болохгүй. Баялгийн сан манай улсын эдийн засгийн төрөлжилтийг нэмэгдүүлж, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал зэрэг бусад салбарыг хөл дээр нь босгоход үр ашгаа өгөх учиртай. Мөн өнөөдөр ашиглаад дуусах биш, нөхөн сэргээгдэхгүй баялгийнхаа тодорхой хэсгийг ирээдүй хойч үедээ өвлүүлэх ёстой” гэсэн. Ашигт малтмалын орлогоор үндэсний баялгийг өсгөх цаг иржээ. ■



Фотог Э.Зоригт

ЯРИЛЦЛАГА

Д.БЯМБАСҮРЭН: ТАВАНТОЛГОЙ БОЛ МОНГОЛЫН НЭГ ЭМГЭНЭЛ

И.ОТГОНЖАРГАЛ

Монголын төр нийгмийн нэрт зүтгэлтэн Монгол Улсын 17 дахь Ерөнхий сайд Дашийн Бямбасүрэнтэй манай сэтгүүлч Монголын эдийн засгийн талаар ярилцлаа.

-Та Монгол оронд болж байгаа уул уурхай, эдийн засаг, хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг байнга авч, анализ дүгнэлт хийж суудаг юм шиг санагдсан. Саяхан Японы Ерөнхий сайд Шинзэ Абэ Монголд айлчиллаа. Айлчлалыг эдийн засаг талаас нь авч үзвэл Тавантолгойн Баруун Цанхи дээрх сонгон шалгаруулалтад Японы байр суурь хүчтэй орж ирэх нь ээ гэж хүмүүс харж байна. Хятад, Япон, Америк гэсэн

гурван том гүрний дунд өрсөлдөөн явагдах хандлагатай байна. Та үүнийг хэрхэн харж байгаа вэ?

-Японы Ерөнхий сайдын айлчлал өндөр ач холбогдолтой. Хэлэлцэж ярьсан зүйл нь Монгол Японы харилцаа хамтын ажиллагааг эдийн засгийн стратегийн түншлэлийн хэмжээнд гаргаж байгаа нь чухал. Баруун Цанхийн хувьд манайхан олон ч жил ярилаа. Энэ бол Монголын нэг эмгэнэл юм шүү дээ. Тавантолгой нэг цогцолбор орд байсан. Гэтэл тав хуваачихаад, ийш тийш нь барьж гүйгээд, ганзагын наймаачин шиг “чамтай ч хамтарна, чамтай ч хамтарна” гэж хүн бүрт амлаад, сүүлдээ гацаанд орлоо. “Чалко”-той байгуулсан ▶

► гэрээг харах юм бол эдийн засгийг улс төрийн барьцаанд өгөх нь ямар хор холбогдолтой байдаг вэ гэдгийг харж болох юм. Тавантолгойн асуудал олон талаараа бүдгэрэх эргэлзээ төрүүлэх байдалд орчихоод байна. Ер нь тус орд газрыг ашиглахдаа дан ганц эрчим хүчний нүүрс юм уу, коксжсон нүүрс гаргана гэх биш, коксоо дотооддоо үйлдвэрлээд гаргавал тээврийн зардал ч бага гарна, үнэ нь ч өндөр болж, эдийн засаг дээшилнэ шүү дээ. Хэрвээ Тавантолгойд Японы тал оролцье гэж байгаа бол кокс, хагас кокс үйлдвэрлээд, тэрийгээ БНСУ, Японы зах зээлд борлуулах чиглэлд хамтарч ажиллах юм бол өндөр ач холбогдолтой. Тэр тусмаа манай урд хөрш Тавантолгойн нүүрсийг авна, авахгүй дээрээ тулчихаад сууж байгаа нөхцөлд коксоо гаргасан нь ашигтай биз дээ.

-Баруун Цанхид АНУ-ын “Пийбоди” компани байгаа. Энэ бол тогтвортой хөгжил, байгаль орчны ээлтэй үйл ажиллагаа гэдгээрээ Монголд нэлээд хэрэгтэй гэсэн байр суурь дуулддаг. Та энэ талаар ямар бодолтой байна вэ?

“Пийбоди” бол дэлхийн том компани гэдэг утгаараа технологи сайтай, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг, уул уурхайн соёл өндөртэй компани. Тавантолгой дээр дан ганц эрчим хүчний болон коксжих нүүрс гаргах болохоор “Пийбоди”-ийг оруулаад, тэндээс олборлосон нүүрсээ дотоодын цахилгаан станцад хэрэглэж, цахилгаан үйлдвэрлэхэд ч болохгүй зүйлгүй. Энд бол маш өргөн сонголт байдаг гэж боддог. Манай төр барьж байгаа хүмүүс хувилбарууд дээрээ жаахан дутмаг ажиллаад байна уу даа гэсэн бодолтой байдаг.

-“Үйлдвэржилтийн шинэ эрин” гээд шинэчлэлийн Засгийн газар нэлээд ярьж байгаа. Гэхдээ эхлүүлсэн зүйл алга байна. Үйлдвэржилтийг хөгжүүлэх тал дээр таны бодлыг сонсоё.

-Үйлдвэржилт гэдгийг манайхан олон удаа, олон янзаар ярьж үзлээ. Манайд энэ талын үндсэн ойлголт философи жаахан дутуу юм уу даа гэж боддог. Барууны орнуудын үйлдвэржилтийн үе шатыг аваад үзвэл үйлдвэржилт нь байгалийн түүхий эдийг боловсруулж, хүний оюун ухаан шингээсэн буюу инженерийн ухаан орсон бүтээгдэхүүн гаргахыг хэлмээр санагддаг. Гэтэл манайд үйлдвэржилт гэдэг нь гаднын техник худалдаж аваад юм уу, гадаадын хөрөнгө оруулагчдыг оруулаад, газраа онгичоод, хүдрээ шороо чигээр нь зөөж, гаргах гэж ойлгоод байна. Энэ хоёрын хооронд асар их зөрүү бий. Ер нь үйлдвэржилтийг зөвхөн уул уурхайтай холбоод эрдэс баялгаа гадагш нь зөөх арга хэрэгсэл гэж ойлгох юм бол нэг талаас энэ нь богино хугацаанд асар их хэмжээний ашиг хуримтлал өгөх боловч нөгөө талдаа хойч үедээ хэдэн зуун жилээр нөхөгдөшгүй гарз хохирол үлдээж, сүйрэлд хүргэх аюултай. Орчин үед дэлхийн улсууд үйлдвэржилтийн хөгжлийн дараагийн замдаа орлоо

гэж ярьдаг. Гэтэл манайх үүнийг уул уурхайгаар төсөөлөөд сууж байгаа нь их л өрөөсгөл ойлголт. Манайх Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийг ашиглаж эхэлснээс хойш 35 жил болж байна. Эрдэнэтийнхээ зэсийг бүрэн үйлдвэрлээд кабель хийгээд юм уу, кабелиараа цахилгаан хөдөлгүүр хийгээд гаргасан бол хангалттай хугацаа өнгөрлөө шүү дээ. Тэгж чадсангүй. Хэрэв Эрдэнэтийн зэсийг кабель болгох юм бол үнэ нь хоёр дахин өснө. Цахилгаан хөдөлгүүр хийгээд гаргавал бүр ашигтай. Ингэсэн тохиолдолд жинхэнэ үйлдвэржилтийн үйл ажиллагаа явж байна гэж ойлгож болно. Монгол Оюутолгой, Тавантолгой гээд хоёр том эх үүсвэрээ нээчихлээ. Үүн дээрээ хүний оюун ухаан, технологи шингээсэн үйлдвэрлэл эрхлэнэ гэсэн зорилттой ажиллавал дээрх ордууд Монголын эдийн засгийг, монголчуудын амьдралыг хангалттай түвшинд тэтгэх боломжтой. Гэтэл дээр нь нэмж уурхай нээх гээд гаднын хүмүүсийн мөнгө харсан хэдэн эрх мэдэлтнүүдийн уриа лоозонгоор хөдлөөд байх шиг.

Монголчуудыг төмөргүй байлгах нь хоёр хөршийн төрийн бодлого

-Түүхий эдэд суурилсан үйлдвэрлэл бий болгоход бодлого тодорхойлж, шийдвэр гаргагчдын зүгээс юу дутаад байна вэ. Сэтгэл үү, хөрөнгө мөнгө үү?

-Хоёр зүйл дутаж байна. Нэгдүгээрт, төрийн өөрийн бодлого, хүсэл зориг байх ёстой. Жишээ нь металлургийн үйлдвэрийг аваад үзье. Ер нь Их Монгол гүрнээс хойших түүхэн бүх үед монголчуудыг төмөргүй байлгана гэдэг манай хоёр хөршийн төрийн бодлого байсан. Батмөнх даян хаан, Алтан хааны үед ч монголчууд Мин улстай ширмэн тогоо Монголд худалдахыг зөвшөөрүүлэх гэж дайтаж байсан үе бий шүү дээ. Тэр үед монголчуудыг төмөргүй байлгавал сэлэм, зэвээ хийж чадахгүй гэдэг утгаар хандаж байсан. Ийм зүйл социализмын үед хүртэл монголчуудыг металлургийн үйлдвэргүй байлгана гэдэг бодлогоор дамжиж ирлээ. Гэтэл одоо төр ийм сайхан эрх чөлөөтэй хувь заяаны жолоогоо гартаа авсан үедээ металлургийн үйлдвэр хөгжүүлэе гэсэн өөрийн ухаан бодолгүй явна. Дарханы металлургийн үйлдвэрийг анх 71 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийнэ гэсэн хэлэлцээр хийж барьсан. Тэгэхэд арматур, ирисийн төмрөөс гадна автоматын ган гаргах ёстой байсан. Гэтэл технологийн үе шатыг нь таслаад өөрсдөө дундуур нь баахан хувийн эрх ашиг шургуулсаар байгаад технологийн ноу-хау авч чадаагүй шүү дээ. Үүнээс болоод энэ үйлдвэр өнөөдөр хагас бүтээгдэхүүн гаргах байдалд зогслоо. Тэгвэл төр үүнийг тууштай явуулах хэрэгтэй. Нөгөө талд нь хүнээ бэлтгэх. Гаднаас машин техник авна ►►

▶ гэдэг зөвхөн мөнгө зарах тухай асуудал юм. Хэзээ ч машин техник авч болно. Тэрийг эзэмших хүн хэрэгтэй. Хүнээ бэлтгэх тал дээр анхаарахгүй явж ирснээс өнөөдөр бусдын гар харах байдалд ороод байгаа.

-Хүнээ хэрхэн зөв бэлтгэх вэ?

-Металлургийн чиглэлийн хүн бэлтгэнэ гэвэл металлургийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн оронд хүнээ явуулах ёстой. Төмөр гэхэд л маш олон янз байна. Зөвхөн болд төмөр гэхэд л 300-гаад төрөл бий. Үүнийг мэддэг чаддаг газарт нь хүнээ явуулж сургах нь зайлшгүй. Миний бодоход энэ чиглэлээр төрийн бодлого дутагдаж байна. Дунд сургуулиа сайн төгсөж байгаа авьяаслаг залуусаа шилж сонгоод Засгийн газрын тэтгэлгээр гадаадын их, дээд сургуульд сургах. Харин ирсэн хойно нь тэр хүмүүстээ үйлдвэрээ өөрөө аваад явахад нь дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

-Хүмүүсээ сургаад, тэд эргэж ирээд үйлдвэр байгуулна гэхээр нэлээд цаг орох юм биш үү?

-Бид энэ тухай ярьсаар байгаад 22 жил өнгөрөөлөө. Энэ хооронд инженер техникчдийн 3-4 үеийг бэлтгэх боломж байсан. Алдаад л байна. Цаг их шаардана гэдэг дээр нэг жишээ бий л дээ. АНУ-ын Ерөнхийлөгч асан Жэффэрсон цэцэрлэгчдээ хэлж л дээ. "Энд нэг алимны мод тарьчихвал зүгээр юм даа" гэж. Нөгөөх нь цаг их шаардана шүү дээ гэсэн байна. Ерөнхийлөгч тэгвэл өнөөдөр тарь гэсэн гэнэ лээ. Тэр технологиор л бид ажиллах ёстой. Хүнээ бэлтгээгүй цагт хэн ч бидэнд ирж нарийн сайн зөвлөж, хийж өгөхгүй шүү дээ. Бүгд өрсөлдөгч гэж харна.

-Оюутолгойн гэрээг өөрчлөх тал дээр Та нэлээд тодорхой байр суурь илэрхийлсэн байсан. Хувь нийлүүлэгчдийн хурал хойшлоод, тодорхойгүй байдал үргэлжилсээр. Ийм нөхцөлд хөрөнгө оруулалтын гэрээ өөрчлөгдөх болов уу?

-Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага бий. Гэхдээ өөрчлөлтийн тухай ярихынхаа өмнө бид ямар өөрчлөлт хийх гэж байна вэ, юу хэрэгтэй вэ гэдгээ дотроо эхлээд ойлгох хэрэгтэй. Миний харж байгаагаар тавьж буй зарим асуудлаа манайхан өөрсдөө ойлгоогүй байна. Ганцхан жишээ хэлье. Норвегит уул уурхайн салбарт ашгийн 78 хувь хүртэл татвар авдаг. Манайх 2006 онд Татварын тухай хуулиа өөрчлөхдөө 35 хувь байсныг 25 хувь болгоод ганц шатлалтай болгож бууруулсан. Одоо ашиг орлогоо олж чадахгүй болохоороо Оюутолгойд оролцох хөрөнгийн оролцоогоо нэмнэ гэж зүтгээд байгаа. Үүний оронд өөрсдөө татварын хуулиа шатлалтай зөв болгочихоод асуудлаа тавибал цаад тал хүлээж авах магадлал нэмэгдэнэ шүү дээ. Миний бодоход өөрийгөө бэлтгээгүй, өөрсдөө сайн ойлгоогүй байж гэрээг өөрчлөх асуудал руу гэнэт үсрэн орох нь өмнөхөө улам дордуулахыг ч үгүйсгэхгүй. Гэхдээ Оюутолгойн гэрээг өөрчлөх шаардлагатай гэдэг дээр хувилбар байхгүй.

Манай эдийн засгийн олон салбар ил далд монополиудын гарт байна

–Монголбанк инфляцийг нэг оронтой тоонд аваачих, дундаж давхаргын чанарыг сайжруулах зорилт тавьсан. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд мах, гурил, нефтийн бүтээгдэхүүнд Засгийн газраас хөнгөлөлттэй зээл олгож байгаа. Үүний үр дүн хэрхэн гарна гэж Та бодож байна?

-Одоогийн инфляцийн мөн чанарыг бид зөв ойлгох хэрэгтэй. УИХ-ын болон орон нутгийн сонгууль болоод жил болоогүй байна. Сонгууль угтаж баахан мөнгө тараасан. Үүний цохилт инфляциар ирлээ. Монголын эдийн засгийг хараад байхад инфляцийн нэг түлхэлт бий болоход түүнийг зургаан сарын дараа эдийн засаг шингээдэг. Жишээ нь махны үнэ байна. Өнгөрсөн жил сонгуулийн өмнө нэг кг нь 6000-7000 төгрөгийн үнэтэй байсан бол өнөөдөр 10000 гаруй мянган төгрөг боллоо. Нөгөө талд инфляци яагаад өсөж байна гэхээр Монголын эдийн засаг чөлөөт өрсөлдөөнтэй эдийн засаг болж чадаагүй байна. Манай эдийн засгийн олон салбар ил далд монополиудын гарт байна. Гуравдугаарт, инфляцийг хөөрөгдөж байгаа зүйл гэвэл манайхан бүтээн байгуулалт гэж сонин лоозон гаргаад түүнийгээ туг болгоод явж байгаа. Бүтээн байгуулалт гэж жишээ нь нэг эрдэмтэн хүн шинэ технологи боловсруулаад, үйлдвэрт нэвтрүүлбэл тэр нь хамгийн үнэтэй бүтээн байгуулалт байх ёстой. Гэтэл бид төсөвт их хөрөнгө хураагаад тэрүүгээрээ шавар овоолоод сумын төвд байшин барихыг бүтээн байгуулалт гэж ойлгодог. Нийлүүлэлтээ зохицуулж чадаагүй учраас инфляци үүсдэг. Дөрөв дэх шалтгаан нь манай төрийн бодлоготой холбоотой. Төсөв батлах үед юм уу, эсвэл сонгууль ойртоод ирэхээр Засгийн газар цалин тэтгэвэр тэтгэмжийг төдөн хувиар нэмнэ гээд л жилийн өмнөөс зарладаг. Энэ сургаар наймаачид барааныхаа үнийг өсгөдөг. Үндсэндээ төрийн бодлого инфляцийг хөөрөгддөг уриа лоозон болж хувирдаг. Ийм үед мөнгөний бодлого барьж байгаа Монголбанкны зүгээс нарийн зохицуулалт хийх шаардлагатай.

-Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлах тухай хууль, Оюутолгойн тодорхойгүй байдлаас болоод Монголд хөрөнгө оруулалт буурлаа гэж ярих боллоо. Та энэ тал дээр ямар байр суурьтай байна вэ?

-Бид нэг зүйлийг л ойлгох хэрэгтэй. Оюутолгой гэдэг бол том объект. Үүний анхны хөрөнгө оруулалтын оргил үед эдийн засагт хөөс бий болсон. Энэ үед манай эдийн засаг 17 гаруй хувиар өслөө шүү дээ. Түүнээс биш, эрүүл эдийн засаг бол ийм өндөр өсөлт гарахгүй. Хамгийн гол нь дээрх өсөлтийг тасралтгүй үргэлжлэх юм шиг бодно гэдэг бол дэндүү гэнэн юм. Монголын эдийн засаг жилдээ ▶

- ▶ 8-10 хувийн өсөлттэй явахад хэвийн байна гэж ойлгож болно.

Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг сонин зүйл л дээ. Хэрэв гадаадын хөрөнгө оруулалтыг дагуулаад дотооддоо түүхий эдийн баазаа босгоод, өөрсдөө ажиллана, хүнээ сургана гэх юм бол шинэ технологи авчрах, хүмүүсийг мэргэшүүлэх, менежмент талаасаа үр ашигтай арга зам юм. Харин гадаадын хөрөнгө оруулалтыг манай баялгийг ухаад бай, дээрээс нь би хэдэн зүйл дамлаж худалдаад ашиг олно гэсэн өнцгөөс харвал энэ нь улсыг сүйрэлд хүргэнэ. Энд эрүүл бодлого хэрэгтэй. Уул уурхайн салбарт зогсонги байдал үүслээ.

Гаднын хөрөнгө оруулалтын зарим нь гарах шинжтэй байна гээд яриад байгаа. Гарвал гараг. Хууль бус лиценз авсан хүн байвал орхиод явахад муу юм байхгүй. Нөгөө талаас Оюутолгой, Тавантолгой дээрээ боловсруулах үйлдвэрүүд бариад явахад эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах нөхцөл бүрдэж байгаа. Ер нь гаднын хөрөнгө оруулалтыг манайхан эдийн засгийн зайлшгүй хөшүүрэг гэж ойлгоод байх шиг. Хөрөнгө мөнгө дутагдаад өөрсдийнхөө хөгжлийн асуудлыг шийдэхэд гаднын хөрөнгийг ашиглаж болно. Түүнээс биш, “Али баба ба 40 дээрэмчин” гэдэг шиг Монгол гэж агуулах сав байна. Энд байгаа зүйлийг гадагшаа зөөгөөд бай, би дундаас нь ашиг хонжоо олоод байя гэдэг сэтгэхүйгээр хандах юм бол бүтэхгүй. Энэ удаа бид жолоогоо татсан нь дээр.

-Монголчууд нэг үеэ бодоход мөнгөтэй болсонтой ч холбоотой байх. Хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй болсон. “Монголын эдийн засгийн чуулган-2013” монгол брэнд хэрхэн бий болгох вэ сэдэвтэй болсон. Таны бодлоор монголчууд юу үйлдвэрлэж, хийж чадах вэ?

-Зэрэгцүүлж л харах хэрэгтэй. Сингапур улс манайхтай адил 3.0 сая хүн амтай. Израиль мөн тооны хүн амтай. Тэр улс юу хийж чадаж байна. Израилчууд элсэн цөлд хамтаараа хооллож, хамтаараа нэг майханд унтаж байгаад улсаа байгуулсан. Тэд өнөөдөр онгоц хийж чаддаг болоод байна. Бусад зүйлийг хийгээд дэлхийд нэр төртэй амьдарч болоод байна шүү дээ. Тэгэхээр хүн цөөдөхгүй ээ. Хийж бүтээхийн тулд улс үндэстэнд хоёр зүйл чухал байдаг. Нэгдүгээрт, технологийн мэдлэг. Нөгөөх нь зохион бүтээлт. Гэтэл манай аль ч үйлдвэр аж ахуйн газарт зохион бүтээж, туршилт нэвтрүүлдэг шат дамжлага байхгүй. Манай компаниуд гаднаас юм оруулж ирээд, олон түмэнд худалдаж мөнгө олдог юм уу, эсвэл дотроо байгаа зүйлийг гадагш нь худалдах чиглэлд л ажиллаж байна. Үндэснийхээ бүтээх чадавхыг бий болгох төвүүдээ байгуулах хэрэгтэй. Арьс шир гэхэд үйлдвэрлэл эрдэм шинжилгээний төв ажиллаж, төрөл бүрийн технологи боловсруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ёстой. Манай шинжлэх ухааны салбарын санхүүжилт ДНБ-ий 0.25 хувь хүрэхгүй шахам байдаг.

Бусад орон үйлдвэрлэлээ хөгжүүлбэ гэвэл судалгаа, шинжилгээнийхээ салбарт ДНБ-ийхээ ес хүртэлх хувийг зарцуулж байж тодорхой үр дүнд хүрдэг. Тийм болохоор Монголд өнөөдөр окуны цөм бүрдэж чадахгүй байна.

Эдийн засгаа улс төрийн барьцаанаас чөлөөлөх хэрэгтэй

-Төсвийн мөнгийг танил тал, хэсэг бүлгээрээ хувааж иддэг байдал нэг хэсэгтээ амь бөхтэй орших юм шиг байна. Авлига хээл хахуулийн асуудал ард түмний санааг улам бүр зовоох боллоо.

-Нэг жишээ авъя. Би саяхан цахим хуудаснаас уншсан. Хөдөө аж ахуйн есөн бирж эрхээ авч, туршилтын арилжаа хийжээ. Малчид нэг кг ноолуурыг 64.000-72.000 төгрөгөөр өгье гэж байгаа юм байна. Миний бодоход ноолуураа ийм үнээр өгч байгаа малчид төрөөс хэзээ ч юм гуйхгүй. Гэтэл улстөрчид эдийн засаг хямрахаар ямаанд мөнгө өгч байна гэдэг нь өөр сонирхолд хөтлөгдөөд байгаа. Энэ нь төр цэвэршээгүй байхад эдийн засгийн бодлого бохирдоод байгааг харуулаад байна.

-Төр хэзээ цэвэрших вэ. Хүлээхээс өөр сонголт алга байна. Та юу гэж боддог вэ?

-Энэ тухай ярьсаар бид удаж байна. Миний мэдэхийн төрийн ялзарлын тухай Монгол Улсын сүүлийн гурван Ерөнхийлөгч ярилаа. Ямар ч байсан олон түмний анхааралд орно гэдэг бол нэг шат. Хэр зөв явах вэ, хэр цаг хугацаа шаардах вэ гэдэг өөр асуудал л даа. Ер нь Оюутолгойн гэрээг будилаантай хийгээд түүнийгээ магтан дуулж байсан үе бий. Тавантолгойг тараачихаад будилж байсан үе ч байгаа. Энд гол зүйл нь эдийн засгаа улс төрийн барьцаанаас чөлөөлөх хэрэгтэй. Улс төрийн намууд эдийн засгаа барьцаалж амлалт өгдөг байдлыг өөрчлөх ёстой. Авлигачдын явсан замыг товчхон харъя. Өмчийг хялбархнаар олж авах гэж өмч хувьчлал явуулсан. Дараа нь төсвийн ам тоссон баячууд бий болсон. Гурав дахь шат төрийн албыг худалдаж авсан. Үүнтэй зэрэгцээд газар, байгалийн баялгаа худалдсан. Байгаль гомдол нэхдэггүй юм байна. Тийм болохоор төр би мэднэ гээд нийт нутгийнхаа 60 хувийг гадныханд өгчихөөд сууж байсан үе байлаа шүү дээ. Одоо тав дахь үе эхэлж байна. Монголынхоо ирээдүйг барьцаалж бонд юм уу, зээл аваад төрд байгаа эрх мэдэлтнүүд нь өөрийнхөө бизнесийн төслийг намын хөтөлбөр санхүүжүүлж байна гэж алга болгох. Эдийн засгаа улс төрийн барьцаанаас салгахын тулд дээрх таван хаалгыг хаах ёстой. Үүнд л төрийн чанд бодлого хэрэгтэй. ■

ОЮУТОЛГОЙ

...Урт хугацаанд
ажиллах
дотоодын ханган
нийлүүлэлтийн
сүлжээг бий
болгохоор зорьж
байгаа...

ДАВУУ ЭРХТЭЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧ

Б.ТОГТОХ

Оюутолгойг тойрсон олон асуудлын нэг нь ханган нийлүүлэлт. Хэзээд араасаа хардлага төрүүлдэг сонгон шалгаруулалт. Хэн нэгэн даргын нөлөө бас шахаа гэж харддаг урьдын сэтгэлгээ. Аль, аль нь хуучирсан “моод”. Үүнийг халах үндэслэл нь стандарт. Хэний ч хүн байлаа гээд үл тоох, хэн ч байсан дүрмээрээ явах нь бизнесийн алтан зарчим. Энэ бүхэн хөгжиж буй эдийн засгийн шударга сонголт. Цаашдаа чөлөөтэй хөгжих, аливаад баригдахгүй,

задгай сэтгэх гарц юм.

Өнгөрсөн хоёрдугаар сарын 6-нд хуралдсан хувь нийлүүлэгчдийн хурал өнөөдрийг хүртэл сунжирч буй шалтгааны нэг гогцоо нь ханган нийлүүлэлт. Оюутолгойг “Эрдэнэт”-тэй жишиж болно. Гэхдээ “Эрдэнэт”-ийн “муу” жишгээр явуулж болохгүй. Тавантолгой төслийг Оюутолгойн бүтээн байгуулалттай харьцуулах ямар ч боломжгүй. Боломжгүй гээд Тавантолгойн шахааг Оюутолгойд давтах бүр ч боломжгүй. Үүнийг хувь



“Оюутолгой” компани 280 сая ам.долларын татвар төлжээ

“Рио Тинто” группээс олон нийтийн хүртээл болгож нийтэлсэн “Татвар төлөлтийн тайлан”-даа өнгөрсөн онд “Оюутолгой” компани Монгол Улсад 280 сая ам.доллар төлсөн гэж мэдэгдлээ. Тус группын үйл ажиллагаа явуулж буй орнууд дотроос татвар төлөлтийн хэмжээгээрээ тавдугаар байрт оржээ. “Рио Тинто” групп дэлхийн хэмжээнд нийт 11.6 тэрбум ам.долларын татвар төлөөд байгаа аж. “Оюутолгой” компанийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх ерөнхий захирал Камерон МакРей “Оюутолгой компани үйлдвэрлэлээ бүрэн хэмжээгээр эхлүүлээгүй ч Монгол Улсын эдийн засаг, хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж байна” хэмээн онцлон тэмдэглэлээ.

Үүнд:

- ▲ 33.3 сая ам.долларыг Татварын Ерөнхий Газарт,
- ▲ 94.6 сая ам.долларыг Өмнөговь аймгийн Татварын хэлтэс, Гаалийн газарт,
- ▲ 122.5 сая ам.долларыг ханган нийлүүлэгчдийн НӨАТатварт,
- ▲ 29.7 сая ам.долларыг нийгмийн даатгал болон бусад хураамжинд тус тус төлжээ.

► нийлүүлсэн хоёр тал хүсэхгүй ч хүсч байгаа хэсэг бас бий.

Монголын хувь нийлүүлэгчдийн зүгээс Оюутолгой компанийн ТУЗ-д 13 асуудлыг хөндөж тавьсан. Үүнд, дотоодын аж ахуйн нэгжүүдийн оролцоог нэмэгдүүлэх хүсэлт. Мөн Монголын банк, санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх асуудал багтаж яваа. Өнгөрсөн хугацаанд гурван ч удаа хуралдаад буй хувь нийлүүлэгчдийн хурлын тов энэ сард гарсан. Гэвч асуудал цэгцэрч, хоёр тал нэгдсэн дүгнэлтэд хүрэх өдий бололтой. Гурван сар дамжин хуралдаж буй хувь нийлүүлэгчид байр сууриа нэгтгэх эсэх нь эргэлзээ төрүүлсээр.

Долоон Эрдэнэт, 50 Бороо-гоулд, зургаан Асгаттай тэмцэх Оюутолгой ордыг хүрээлсэн зах зээлд хүлээлт үүсч эхэллээ. Энэ нь сар тутам төсвөө батлуулж буй “Оюутолгой” компанийн ханган нийлүүлэгчдэд хүндрэл учруулах сөрөг нөлөөтэй. Уул уурхайгаас хамаарсан эдийн засагт “Оюутолгой” төсөл хүрээгээ тэлсээр буй. Гэсэн ч хөрөнгө оруулалтын гэрээнээс үүдэлтэй хоёр талын маргаан намжих шинжгүй нь. Үүнээс гадна Оюутолгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах замаар 445.8 тэрбум төгрөг төвлөрүүлэх төсвийн “зурхай” гажуудаж мэдэхээр. Эдгээр үл ойлголцол ханган нийлүүлэлтийн зах зээлд сайныг дуудахгүй нь мэдээж.

“Оюутолгой” компанийн зүгээс үндэсний ханган нийлүүлэгчидтэй хамтран ажиллах, тэднийг хөгжүүлэх замаар найдвартай, эдийн засгийн үр ашигтай, урт хугацаанд ажиллах дотоодын ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгохоор зорьж байгаа аж. Мөн энэ оны үндэсний ханган нийлүүлэгчдэд зарцуулах төлөвлөгөө болон явцын тайлангаа нээлттэй зарласан байна.

Компани 2011 оноос өнөөг хүртэл 1.1 тэрбум ам.доллар буюу 1.4 их наяд төгрөгийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг үндэсний компаниудаас худалдан авчээ. Мөн 1131 үндэсний компаниудтай хамтран ажилласан нь нийт ханган нийлүүлэгчдийн 67 хувийг эзэлж байна. Үүнээс гадна, Өмнөговь аймгийн ханган нийлүүлэгчдэд зориулсан жижиг зээлийн хөтөлбөрийг Хаан, Хас банкттай хамтран үргэлжлүүлэхээр болжээ.

Тус хөтөлбөр нь ханган нийлүүлэгчид бизнесээ өргөжүүлэхэд эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зориулалтаар сарын нэг хувийн хүүтэй 30 сая хүртэлх төгрөгийн зээл авах боломжийг нээжээ. Өнгөрсөн хугацаанд хөтөлбөрийн хүрээнд 70 гаруй бизнес эрхлэгч 823 тэрбум 625 сая төгрөгийн зээл авсан мэдээлэл бий.

Тасалдаж буй хөрөнгө оруулалтын цангааг тайлах дэлхийн хэмжээний төслийн анхны хөрөнгө оруулалтад цэг хатгах ойртсон. Уг нь үйлдвэрлэл эрчимжиж, үндэсний орлого нэмэгдэх үе. Тиймээс Оюутолгойг тойрсон мөнгөний урсгалыг дотооддоо аргамжих гарц нь ханган нийлүүлэх замаар мөнгө “саах” явдал. Үүнийг бид “овжин” ашиглаж чадваас татвараас ч илүү ашиг олж болохоор.

“Оюутолгой” компанийн Үндэсний ханган нийлүүлэлтийн менежер Б.Сэржмаа “Үндэсний ханган нийлүүлэгч гэдэг нь Монгол Улсад бүртгэлтэй, тухайн компанийн 50-иас дээш хувийг Монгол иргэн эзэмшдэг компанийг хэлдэг. Энэ жил үндэсний хэмжээнд Монголын компаниудтай нийт зарцуулалтынхаа 50 хувийг төлөвлөөд байгаа. Үүнээс гадна Өмнөговийн ханган нийлүүлэгчдээс 36.4 тэрбум төгрөгийн худалдан авалт хийх зорилт тавьсан” гэв.

Манай эдийн засаг өнгөрсөн онд 12.3 хувиар өссөн ч гаднын хөрөнгө оруулалт өмнөх оныхоос бараг 40 хувиар буюу 800 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй гарсан. Эдийн засагт буй мөнгөний хомсдлыг Чингис бондоор нөхөж болох ч төсвийн орлого бүрдэхгүй байх таамаг аль хэдийнэ “жиргээд” эхэлсэн. Түүхэндээ төсвийн орлого 100 хувь биелсэн нь бас л ховор. Давуу эрхтэй ханган нийлүүлэгч буюу үндэсний аж ахуй нэгжүүдэд амжилт хүсье. ■



Õ°ãæèë, õ°ð°íã° äàëëàü



ЦАГ НААШИЛЖ БАЙНА

...ТУЗ бол компанийг урт хугацаанд ажиллаж, амьдрах чадавхыг бий болгодог бол гүйцэтгэх удирдлага богино хугацаанд ашиг олохыг чухалчилдаг...

И.ОТГОН

“Монголд гурван “нөхөр” компанид маш хүчтэй нөлөөлж, идэж уучих гээд байна. Нэгдүгээрт, төр, хоёрдугаарт, том хувьцаа эзэмшигч, гурав дахь нь гүйцэтгэх удирдлага. Хараат бус гишүүн энэ гурваас хамааралгүй байх ёстой. Тэр бол компанийн төлөө жинхэнэ үйл ажиллагаа явуулах ёстой хүн. Энэ утгаараа хараат бус гишүүнд бусад ТУЗ-ийн гишүүдээс илүү эрх, үүрэг ногдуулж өгсөн байгаа” хэмээн АХБ-ны Компанийн засаглалын төслийн

зөвлөх Б.Байлийхүү “Топ-20 компанийн ТУЗ-ийн гишүүдэд компанийн засаглалын сертификат олгох” сургалтын үеэр цохон тэмдэглэв. Хатуу ч үнэн үг. Гадаадын хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татсан компаниуд үйл ажиллагааныхаа тухай хувьцаа эзэмшигчдэдээ байнга мэдээлж, асуудлаа тогтмол танилцуулдаг. Гэтэл Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй 328 хувьцаат компаниас үйл ажиллагаа нь тодорхойгүй, тэрбитгий хэл, хаана ▶

► байршилтай, гүйцэтгэх удирдлага нь хэн гэж хүн байдаг, ТУЗ-тай эсэх нь мэдэгдэхгүй компани олон бий. Ийм компаниудын хувьд ТУЗ-ийн хурал, санхүүгийн тайлан, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, ногдол ашиг тараах эсэх тухай ярих гээд ч нэмэргүй. Тиймээс СЗХ-ноос МХБ-д бүртгэлтэй компаниас 116-гийнх нь дансны гүйлгээг хаасан. Ийм арга хэмжээнд хүрсний эцэст өнгөрсөн онд арван компани бүртгэлээ сэргээлгэсэн байх жишээтэй.

Өнөөдөр 2013 оны дөрөвдүгээр сарын 12. Үүрэглэж байсан ХК-иудын хувьд жил бүрийн гуравдугаар сарын 10, дөрөвдүгээр сарын 30-ны өдөртэй уралдаж сэрдэг уламжлалтай. Компанийн тухай хуулиар санхүүгийн жил дууссанаас хойш 45 хоногийн дотор санхүүгийн тайлангаа МХБ, СЗХ-нд ирүүлсэн байх. Жил бүрийн дөрөвдүгээр сарын 30-ны дотор Хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийх. Тус хурлын товийг хуульд заасан хугацаанд холбогдох газруудад ирүүлэх ёстой гэсэн хуулийн заалттай. “Манайх чинь нээрээ хувьцаа эзэмшигчидтэй шүү дээ. Өдийд нэг тайлан энэ тэр өгдөг дөө” гэж санаа зовох булчирхайтай нь энэ үеэр сэрнэ. Хуулийн цагийн сэрүүлэгт сэрэхгүй бөх гэгч нойрсох компани ч цөөнгүй. 2011 оны аравдугаар сараас хэрэгжсэн Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга МХБ-ээр дүүрэн хөглөрөх засаглал муутай компаниудыг дэгэнд оруулахаар байгаагаараа олзуурхуштай.

Тус хуульд компанийн засаглалын олон улсын зарчмуудыг нэлээд сайн тусгаж өгсөн бөгөөд үүнтэй холбоотой 400-гаад нэмэлт, өөрчлөлт орсон аж. Уг хуулийг муугүй болсон гэдэгтэй олон хүн санал нэгддэг. Гагцхүү одоо хуулийн хэрэгжилт жил гаруйн хугацаанд ямар байсан бэ гэдгийг дүгнэх хэрэгтэй. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал өнгөрсөн нэгдүгээр сард Компанийн тухай хуулийн гол заалтуудын хэрэгжилт ямар байгаа талаар Засгийн газарт асуулга хүргүүлж байсан. Улсын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад үндэсний компаниудын хөгжил чухал үүрэгтэй. Тиймээс “Mongolian Economy” сэтгүүл УИХ-ын гишүүний асуулгыг үргэлжлүүлж, Компанийн тухай хуулийн хэрэгжилт, компанийн засаглалын асуудлыг цогцоор нь “Онцгой тайлан” булан нээн хүргэж байна.

Оюутолгой, Тавантолгой гээд дэлхийд нэртэй орд газруудынхаа буянаар монголчууд таван тивийн том компаниудын төлөөлөлтэй хамтран хөрөнгө оруулалт

хийх, ашиг хуваах зэрэг үйл ажиллагаа одооноос эхэлж буй. Газрын хэвлийдээ 80 гаруй төрлийн ашигт малтмал “нуусан” монголчууд энэ чиглэлд улам туршлагажих нь дамжиггүй. Мэдлэг туршлага дутаж “Рио Тинто” мэтийн том гаруудад мад тавиулчих гээд сандарч, сандарсандаа Оюутолгойн ТУЗ-ийн хараат бус гурван гишүүнээ солих, солихгүйн тухай асуудлаар нийгэмд маргаан дэгдээв. МИАТ-ийн удирдлагуудын идсэн уусан баримт, баривчилгаа гээд хүссэн хүсээгүй компанийн засаглал Монголын нийгэмд тухлах цаг болжээ. Аз болоход компанийн засаглалын сул хөгжилтэй холбоотой урган гарах маргаануудыг эмх цэгц дэг журамд оруулах хуультай болсон нь яамай даа. Хуулийн хэрэгжилтийнхээ үндсэн асуудал руу оръё.

СЗХ-ноос гаргасан мэдээллээр өнөөдрийн байдлаар МХБ-д үйл ажиллагаа нь хэвийн явж байгаа 216 хувьцаат компанийн хувьд авч үзэх юм бол 50 орчим нь хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарлаагүй, 20 гаруй компани санхүүгийн тайлангаа хуульд тусгасан хугацаанд ирүүлээгүй гэсэн мэдээ байна.

Ямар компанийг сайн засаглалтай гэх вэ

“Компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан өргөн ойлголт. Тиймээс ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талын ашиг сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо” гэж Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт томъёолжээ. MCS группын ерөнхийлөгч Ж.Оджаргал “Компанийн засаглалыг би дутуу ойлгож явжээ. Ямар хэцүү зүйл байдгийг Хонконгийн биржид “Энержи ресурс”-ийн IPO гаргахад ойлголоо” хэмээн хоёр жилийн өмнө Монголын эдийн засгийн чуулганы үеэр хэлж байсныг компанийн удирдлагуудад хэлмээр санагддаг” хэмээн Сангийн яаман дахь Дэлхийн банкны “Олон салбарын техникийн туслалцаа”-ны төслийн зөвлөх Б.Аюуш ярьж байсан. Мөн тэрбээр “Бүх оролцогч талынхаа итгэлийг хүлээж ажилладаг компанийг сайн засаглалтай гэнэ” гэж оновчтой тодорхойлолт хэлсэн юм. Үүнийг тэмдэглэсэн учир нь Компанийн тухай хуулийн 75.8-д “ТУЗ-ийн гишүүн болон нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна” гэж заасан. Энэ заалтын хэрэгжилт ямар байгааг аваад үзье. Хөрөнгийн биржид үйл ажиллагаа явуулж байгаа 216 компаниар жишээлэхэд, нэг компанийн ТУЗ есөөс доошгүй гишүүнтэй гэж тооцох юм бол ТУЗ-ийн 1944 гишүүн бий гэсэн үг. Тэд компанийн засаглалын сургалтад цаг алдахгүй сууж, гэрчилгээ авах ёстой. Гэтэл тэдний дөнгөж тавхан хувь нь сургалтад хамрагдаад байгаа аж. Өнгөрсөн онд Компанийн засаглалын үндэсний зөвлөл 70 гаруй сургагч багш бэлтгэж, өдгөө компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтыг Банк санхүүгийн академи, Арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн холбоо, МҮХАҮТ зэрэг есөн байгууллагатай хамтран явуулж байна. Түүнчлэн ►

Хувьцаат компанийн тухай мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн хувьцаат компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал ирүүлсэн хувьцаат компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн хувьцаат компанийн тоо	Шинэчилсэн дүрмээ баталсан хувьцаат компанийн тоо
172 ХК	169 ХК	141 ХК	139 ХК

Төрийн өмчит хувьцаат компанийн тухай мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлээ ирүүлсэн төрийн өмчит хувьцаат компанийн тоо	Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал ирүүлсэн төрийн өмчит хувьцаат компанийн тоо	Санхүүгийн тайлан ирүүлсэн төрийн өмчит хувьцаат компанийн тоо	Шинэчилсэн дүрмээ баталсан төрийн өмчит хувьцаат компанийн тоо
11 ХК	24 ХК	22 ХК	22 ХК

Эх сурвалж: СЗХ

► Компанийн засаглалын үнэлгээний аргачлалыг боловсруулсан, Топ-20 компанийн засаглалын үнэлгээ хийж байгаа гээд компанид хөгжил, хөрөнгө даллах зүйлсийг холбогдох байгууллагуудаас хийгээд эхэлжээ. Гагцхүү хөгжлийн галт тэргэнд суух чин хүсэл эрмэлзлийг ХК-ийнхан хошуучлах учиртай. Энэ талаар Байлийхүү “Нэг талаас хуулийн хэрэгжилт муу байна.

Нөгөө талааскомпанийнхан хуулийн мөн чанарыг ойлгохгүй байна. Энэ хуулийг өмнөх шиг ямар нэгэн захиргааны шахалт шаардлагаар хэрэгжүүлэхгүй. Компани бүр дүрмээ хуульд нийцүүлж шинэчилнэ. ТУЗ есөн гишүүнтэй байна. Түүний гуравны нэг нь хараат бус гишүүн байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаа зарласан байна гээд хуулийн хүссэн хүсээгүй хэрэгжүүлэх ёстой. Эдгээрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага автоматоор эрх зүйн чадамжгүй болж байгаа. Магадгүй тэр хүн ажлаа хийгээд, бодлого шийдвэрээ гаргаад яваад байж болно. Өрсөлдөгч нь ч юм уу, эсвэл хэн нэгэн хувьцаа эзэмшигч, харилцагчдын зүгээс тухайн компанийн ямар нэгэн асуудлаар шүүхэд хандахад эрх зүйн чадамжгүй удирдлага уснаас гарах аргагүй болсноо мэдрэнэ. Энэ үед л хуулийн мөн чанарыг ойлгоно” гэв. Тиймээс л уг сургалтыг дархлаа болгох үүндээс хуульд тусган байж явуулж байгаа аж.

Монгол Улс 90 гаруй мянган аж ахуйн нэгжтэйгээс 40 гаруй мянга нь компани гэсэн судалгаа бий. Компанийн засаглалын олон улсын нийтлэг дүрэм журмаар баяжсан Компанийн тухай шинэ хууль ТӨХК болон ХК-иудад илүү хамааралтай. Нөгөө талаас компанийн засаглал сайн байна гэдэг хөрөнгө оруулалт татах нэг хэлбэр тул ХК-иудын хувьд шинэ хуулийг наашаа харж инээж, цаашаа харж уйлж байгаад ч болтугай нь хэрэгжүүлэх учиртай. Ихээхэн цаг хугацаа, хөрөнгө гаргаж, гүрийсний эцэст инээх цаг ирнэ.

ТУЗ, гүйцэтгэх удирдлага нэг хүний халаасанд багтдаг албан тушаал биш

Шинэ хуулиар ТУЗ, гүйцэтгэх удирдлага, Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг тодорхой гаргаж өгснөөрөө ялангуяа жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьд ялгаж, салгаж ойлгоход бэрхтэй олон асуудлыг цэгцэлжээ. Тухайлбал, манайд ТУЗ-ийн дарга болон гишүүн нь гүйцэтгэх захирлаа хийх нь олонтаа.

Түүнчлэн тухайн хүн бараг өөрөө ч мэдэхгүй баахан компанийн ТУЗ-д орох нь бий. Тэгвэл мэргэжлийн сургагч багш нарийн зааж буйгаар ТУЗ гэдэг бол компанийг урт хугацаанд ажиллаж, амьдрах чадавхыг бий болгодог байна. Харин гүйцэтгэх удирдлага богино хугацаанд ашиг олохыг чухалчилдаг аж. Мөнгө эргэлдүүлж, ашиг олох авьяас чадлыг эзэмшсэн байх нь өндөр цалинтай гэрээт ажилтан гэж хэлж болох

гүйцэтгэх захирлын хувьд тун чухал. Тэгэхээр ТУЗ, гүйцэтгэх удирдлага хоёр явч нэг хүнийн халаасанд багтдаг албан тушаал биш аж. Өөрөөр хэлбэл, зорилго чиглэл нь өөр учраас хоёр албан тушаал дээрээ тэр хүний чиг үүрэг зөрчилдөнө гэсэн үг. ТУЗ бол гэрээгээр ажиллаж байгаа гүйцэтгэх удирдлагын гэрээ хэлцэл, бодлого шийдвэр хэр үнэн зөв яваад хяналт тавих учиртай юм.

Компанийн тухай хуулиар компанид онцлох хэд хэдэн албан тушаал, ажил мэргэжил бий болжээ. Түүний талаар энд цухас дурдъя. ТУЗ-ийн хараат бус гишүүн. Энэ албан тушаалтны талаар Байлийхүү гуай товч бөгөөд тодорхой хэлсэн. Хараат бус гишүүнийг ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос нэр дэвшүүлж, томилох заалттай. Мөн ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын гэсэн гурван хороо байна. Хороо тус бүрийн үйл ажиллагааны чиглэл, эрх үүргийг хуульд тодорхой заажээ. Тухайлбал, Аудитийн хороог заавал Хараат бус гишүүн даргална гэсэн байх жишээтэй. Үүнээс гадна ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гэдэг албан тушаалтан Компанийн тухай хуулиар цойлж гарч ирсэн. Энэ хүн нь ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ-өөс томилсон эрх бүхий албан тушаалтан байх аж. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хурдан шаламгай, зохицуулах авьяастай хүн байх ёстой. Энэ албан тушаалтан өнөөдрийг хүртэл манай ХК-иудад байхаасаа байхгүй нь их. Байсан ч компанийн хуулийн мэргэжилтэн ч юм уу, захирлын туслах нь хавсран гүйцэтгэх байдлаар явж ирсэн. Тэгвэл хуулиар ийн тусгайлсан үүрэг хариуцлагатай, бодлого боловсруулах түвшний оролцоотой албан тушаалтан болж тодорсон байна. Ингэсан нь бас учиртай. Харин ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хуулиар хүлээсэн үүргээ буруу ухамсарласан, ажилдаа алдаа гаргаж, улмаар түүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй компани болоод хувьцаа эзэмшигчдэд хохирол учирсан гэж үзвэл хохирлыг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулах хуулийн хатуу заалттай. Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд ч мөн өөрийн буруутай үйл ажиллагаанаас болж алдаа гаргасан тохиолдолд хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулахаар байгаа билээ. Жишээ нь, хуулийн хэрэгжилтийг хойш тавьж, том толгойлж яваа ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага тус бүрийг өөрийн хөрөнгийн гурван сая төгрөгөөр торгохоор байгаа аж. Энэ мэтийн хэрэгжүүлж чадвал сайн үр дүн авчрах, хуулийн онцлог цөөнгүй. Хувьцаат компаниудын удирдлагуудыг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэг болтол нь “сургахын” тулд мэдээж багагүй хугацаа хэрэгтэй. Гэхдээ л компаниуд олон нийтэд мэдээллээ ил тод түгээдэг, хариуцлагатай буюу хууль хэрэгжүүлдэг хяналтын тогтолцоо бүрдэх цаг наашилж байна. ■

Үнэт цаасны арилжааг нь зогсоосон 166 хувьцаат компанийн жагсаалт

Д/д	Хувьцаат компанийн нэр	Байршил	49	"Дэл баянбулаг" ХК	Архангай аймаг	64	"Увс хийц" ХК	Увс аймаг
1	"Автотээвэр-27" ХК	Баянгол дүүрэг	50	"Шинэ-Өргөө" ХК	Архангай аймаг	65	"Усжуулах" ХК	Увс аймаг
2	"Агро-Амгалан" ХК	Баянгол дүүрэг	51	"Ус-Архангай" ХК	Архангай аймаг	66	"Туруун" ХК	Увс аймаг
3	"Бат хийц" ХК	Баянгол дүүрэг	52	"Орхон" ХК	Өвөрхангай аймаг	67	"Арилжаа" ХК	Увс аймаг
4	"Их даац" ХК	Баянгол дүүрэг	53	"Хангай" ХК	Өвөрхангай аймаг	68	"Улаанхотгор" ХК	Увс аймаг
5	"Их үүсгэл" ХК	Баянгол дүүрэг	54	"Хужирт Өргөө" ХК	Өвөрхангай аймаг	69	"Алтандуулга" ХК	Увс аймаг
6	"Монсав" ХК	Баянгол дүүрэг	55	"Гантээрэм" ХК	Өвөрхангай аймаг	70	"Увс" ХК	Увс аймаг
7	"Разноимпекс" ХК	Баянгол дүүрэг	56	"Гантөмөрт" ХК	Завхан аймаг	71	"Жимст" ХК	Баян-өлгий аймаг
8	"Тээвэр цагааннуур" ХК	Баянгол дүүрэг	57	"Жинст" ХК	Завхан аймаг	72	"Асгат" ХК	Баян-өлгий аймаг
9	"Монгол ЭЭГ" ХК	Хан-Уул дүүрэг	58	"Завхан тээвэр" ХК	Завхан аймаг	73	"Цагааннуур" ХК	Баян-өлгий аймаг
10	"ЦаСТУ" ХК	Хан-Уул дүүрэг	59	"Завхан тээв" ХК	Завхан аймаг	74	"Мерей" ХК	Баян-өлгий аймаг
11	"Чимбай" ХК	Хан-Уул дүүрэг	60	"Модлог" ХК	Завхан аймаг	75	"Арилжаа импекс" ХК	Баянхонгор аймаг
12	"Шинэст" ХК	Хан-Уул дүүрэг	61	"Улбаа" ХК	Завхан аймаг	76	"Баянхонгор гео" ХК	Баянхонгор аймаг
13	"Монгол эд импекс" ХК	Сонгинохайрхан дүүрэг	62	"Улиастай тэгш" ХК	Завхан аймаг	77	"Зоос трейд" ХК	Баянхонгор аймаг
14	"Автодаац" ХК	Сонгинохайрхан дүүрэг	63	"Их нуур" ХК	Увс аймаг	78	"Өргөн жим" ХК	Баянхонгор аймаг
15	"Туул баян" ХК	Баянзүрх дүүрэг						
16	"Баяндехем" ХК	Баянзүрх дүүрэг						
17	"Гүн галуут" ХК	Багануур дүүрэг						
18	"Налайх Өргөө" ХК	Налайх дүүрэг						
19	"Монел" ХК	Сүхбаатар дүүрэг						
20	"ХААБЗ" ХК	Чингэлтэй дүүрэг						
21	"Эрдэнэт авто зам" ХК	Орхон аймаг						
22	"Жаргалант үйлс" ХК	Орхон аймаг						
23	"Өргөн хэрэглээ" ХК	Орхон аймаг						
24	"Торгон -Ур" ХК	Дархан-Уул аймаг						
25	"Уужимхангай" ХК	Дархан-Уул аймаг						
26	"Дар зам" ХК	Дархан-Уул аймаг						
27	"Дархан импекс" ХК	Дархан-Уул аймаг						
28	"Орхон жимс ногоо" ХК	Дархан-Уул аймаг						
29	"Мандал" ХК	Хөвсгөл аймаг						
30	"Цагаанчулуут" ХК	Хөвсгөл аймаг						
31	"Алтан үсэг" ХК	Төв аймаг						
32	"Атар төв" ХК	Төв аймаг						
33	"Баянбадрах" ХК	Төв аймаг						
34	"Баянтөлгой" ХК	Төв аймаг						
35	"Борнуур" ХК	Төв аймаг						
36	"Сүмбэр өлзий" ХК	Төв аймаг						
37	"Хорго хайрхан" ХК	Төв аймаг						
38	"Даваанбулаг" ХК	Төв аймаг						
39	"Жаргалант-Төв" ХК	Төв аймаг						
40	"Залуучууд" ХК	Төв аймаг						
41	"Ноён шанд" ХК	Төв аймаг						
42	"Угтаал Төв" ХК	Төв аймаг						
43	"Шар хоолой" ХК	Төв аймаг						
44	"Эрдэнэтөлгой төв" ХК	Төв аймаг						
45	"Тээвэр төв" ХК	Төв аймаг						
46	"Ундрам төв" ХК	Төв аймаг						
47	"Хүнс төв" ХК	Төв аймаг						
48	"Ардын зориг" ХК	Төв аймаг						

Д/д	Бүртгэлээс хассан ХК-ийн жагсаалт	Тогтоолын дугаар ХК-ийн жагсаалт	Арилжааг нь сэргээсэн	Тогтоолын дугаар
1	Баян Уул ХК	2010.04.19 №116	Чацаргана ХК	2008.10.22 №216
2	Дархан өргөө ХК	2008.07.07 №178	Дархан тээвэр ХК	2008.10.22 №217
3	Дорнын бэрс ХК	2008.12.12 №218	Хар хорин ХК	2009.04.29 №68
4	Их өртөө ХК	2008.11.28 №262	Номинхишиг ХК	2009.05.26 №46
5	Төв оргил ХК	2009.01.29 №26	Бааз ХК	2009.09.10 №180
6	Манзушир ХК	2009.03.26 №42	Монгол шинэс ХК	2009.09.10 №186
7	Зүрх уул ХК	2009.03.26 №62	Увс хүнс	2010.4.28 №125
8	Жирмэн сүлжээ ХК	2009.03.26 №62	Ар хуст шунхлай ХК	2010.05.28 №125
9	Эд хэрэглэгчдийн төв ХК	2009.03.26 №62	Мөнх үндэс ХК	2010.5.28 №153
10	Шанх ХК	2009.03.26 №57	Сөдөт ХК	2010.12.09 №409
11	Найд ХК	2009.03.26 №58	Дөрвөн уул ХК	2011.02.23 №67
12	Дархан худалдаа ХК	2009.03.26 №59	Хөдөөгийн тээвэр ХК	2011.02.23 №71
13	Мон ургац ХК	2009.03.26 №60	Ар баянхангай ХК	2011.03.28 №82
14	Магсаржав ХК	2009.03.26 №61	Хуртай ХК	2011.9.14 №263
15	Мөнх сансар ХК	2009.03.26 №57	Эрэнцэв ХК	2011.12.23 №386
16	Саван трейд ХК	2009.06.25 №149	Цагдуултай ХК	2011.12.23 №385
17	ЗГМС ХК	2009.11.03 №171	Өв ханын материал ХК	2012.6.20 №209
18	Дэлгэр трейд ХК	2009.09.10 №179	"Дархан гурил тэжээл" ХК	2012.5.23 №161
19	Монхөлөг ХК	2009.10.08 №201	"Баянхайрхан" ХК	2012.11.28 №338
20	Дээж ХК	2009.10.28 №216	Батширээт ХК ,	201.10.27 №310 Давхардсан
21	Буянт төв ХК	2009.12.23 №279	Орд Харш ХК	Давхардсан
22	Цацрал мон ХК	2010.01.27 №30		
23	Авто 28 ХК	2010.03.24 №90		
24	Хаш орд ХК	2010.03.24 №91		
25	Автокомбинат ХК	2011.05.06 №126		
26	Ардын эрх ХК	2010.8.25 №233		
27	Монэнзим ХК	2012.04.07 №297		
28	Хаш өргөө ХК	2011.05.06 №59		
29	Батширээт ХК	2012.05.09 №138		
30	Орд Харш ХК	2011.5.06 №137		

79	"Асралт хайрхан" ХК	Сэлэнгэ аймаг	92	"Хангайн царам" ХК	Булган аймаг	105	"Баян хаан" ХК	Дорнод аймаг
80	"Баянбулаг-Сэлэнгэ" ХК	Сэлэнгэ аймаг	93	"Шахайт хайрхан" ХК	Булган аймаг	106	"Дэвшил мандал" ХК	Дундговь аймаг
81	"Жинчин" ХК	Сэлэнгэ аймаг	94	"Чандгана" ХК	Хэнтий аймаг	107	"Дээд буян" ХК	Дундговь аймаг
82	"Зүүнхараа-Өргөө" ХК	Сэлэнгэ аймаг	95	"Жоншит тээвэр" ХК	Хэнтий аймаг	108	"Өлзий Дундговь" ХК	Дундговь аймаг
83	"Иж бүрэн" ХК	Сэлэнгэ аймаг	96	"Буянт булаг" ХК	Хэнтий аймаг	109	"Чандмана Дундговь" ХК	Дундговь аймаг
84	"Мандал Оргил" ХК	Сэлэнгэ аймаг	97	"Баянмод Уул" ХК	Хэнтий аймаг	110	"Говь шанд" ХК	Дорноговь аймаг
85	"Монгол шүдэнз" ХК	Сэлэнгэ аймаг	98	"Тахилгат" ХК	Хэнтий аймаг	111	"Сайншанд" ХК	Дорноговь аймаг
86	"Сэл.Дулаанхаан" ХК	Сэлэнгэ аймаг	99	"Дорнод импекс" ХК	Дорнод аймаг	112	"Баянбогд" ХК	Дорноговь аймаг
87	"Сэлэнгэ Ар хөвч" ХК	Сэлэнгэ аймаг	100	"Дорнод тээвэр" ХК	Дорнод аймаг	113	"Говьсүмбэр" ХК	Говьсүмбэр аймаг
88	"Сэлэнгэ гур.тэж" ХК	Сэлэнгэ аймаг	101	"Дорнод ноос" ХК	Дорнод аймаг	114	"Буян" ХК	Ховд
89	"Сэлэнгэ импекс" ХК	Сэлэнгэ аймаг	102	"Дорнод хүнс" ХК	Дорнод аймаг	115	"Бүтээл" ХК	Ховд
90	"Сэлэнгэ Хүрд" ХК	Сэлэнгэ аймаг	103	"Халх Буудай" ХК	Дорнод аймаг	116	"Алтай ханын материал" ХК	Ховд
91	"Шинэс" ХК	Сэлэнгэ аймаг	104	"Хэрлэн хивс" ХК	Дорнод аймаг			

Эх сурвалж: СЗХ

САЙН ТУРШЛАГА

ИРЭЭДҮЙН СТРАТЕГИ ХҮНЭЭ ХӨГЖҮҮЛЭХ

ТУЗ-ийн гишүүдийн тоо: ес /түүнээс гурав нь хараат бус гишүүн

Гүйцэтгэх захирал:

Цэдэнсодном овогтой Батбаяр
2000 онд ШУТИС-ийн КТМС-ийг Үйлдвэрлэл, автоматжуулалтын инженерийн мэргэжлээр төгссөн
2000-2008 онд- "Бэрэн констракшн" компанийн ерөнхий инженер
2008-2011 онд- "Бэрэн группийн ерөнхий менежер
2011 оноос одоог хүртэл "Бэрэн майнинг"-ийн гүйцэтгэх захирал

Гол бизнес:

Төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэлийн чиглэлээр Монголдоо анхдагч. Архангай аймгийн Төвшрүүлэх суманд байрладаг баяжуулах үйлдвэр нь 2007 онд ашиглалтад орсон. Жилд 250000 тонн, 64-67 хувийн агуулгатай төмрийн баяжмал нойтон аргаар үйлдвэрлэх хүчин чадалтай.

2012 оноос хувьцаат компани болон зохион байгуулалтаа өөрчилж, үйлдвэрийн хүчин чадлаа жилдээ 500000 тн баяжмал, 300000 тн шууд ангижруулсан төмрийн үйлдвэр барихаар ажиллаж байна. /дэлгэрэнгүйг зургаар явуулав/

ТУЗ болон хувь нийлүүлэгчдийн хурлаас хуралдуулдаг зарчим:

Хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүдийн

хуралдааныг амжилттай зохион байгуулах, хурлаас гарах шийд нь хуралд нийцсэн, биелэгдэх боломжтой, эдийн засгийн үндэслэлтэй, хэрэгжүүлэгч нарын санаанд бүрэн нийцсэн байх урьдчилсан бэлтгэлийг сайтар хангах юм. Үүний тулд нэгдүгээрт, хурлаар хэлэлцэж шийдвэрлэвэл зохих хойшлуулшгүй компанийн өмнө тулгамдсан асуудлыг түүж, удирдлагатай тохирох. Хоёрдугаарт, хурлаар хэлэлцэхээр тохирсон асуудлаа зөв эрэмбэлэх.

Монгол Улсад компанийн засаглалыг хөгжүүлэхэд юуг анхаарах ёстой вэ:

Засаглалаа сайжруулах ирээдүйн стратеги нь хүнээ хөгжүүлэх явдал юм. Учир нь, компанийн засаглалыг хүн хэрэгжүүлнэ. Иймд ерөнхий боловсролын сургуулиас авахуулаад бүх шатны сургуульд компанийн засаглалын хичээлийг оруулж өгөх хэрэгтэй. Компанийн засаглалын стратегийн чиглэлийн эрдмийн бүтээлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх. ■



ШИНЖИЛГЭЭ

“ТОП-20”-ИЙН ЗАСАГЛАЛ ЯМАР БАЙНА ВЭ



Б.САНЖААХАНД

Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Топ-20” хувьцаат компанийн суурь шинжилгээг анх удаа цэвэр өгөөжийн үзүүлэлтээр нь хийжээ. Энэ талаар тус зөвлөлийн дарга Д.Ганбаяраас тодрууллаа.

-Хувьцаат компаниудын суурь шинжилгээ юу өгүүлж байна вэ?

-Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс засаглалыг сайжруулах чиглэлд цөөнгүй ажил эхлээд байгаагийн нэг нь бизнесийн байгууллагын санхүүгийн ил тод байдлыг бий болгох. Хуулиар ХК-иуд санхүүгийн тайлангаа жил бүрийн хоёрдугаар сарын 10-ны дотор МХБ, СЗХ-нд албан ёсоор ирүүлсэн байх ёстой. Энэ тайланд үндэслэн Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс болон миний бие олон улсын хөрөнгийн зах зээлд ажиллаж байсан туршлагадаа тулгуурлан ХК-иудын хувьцааны суурь шинжилгээ хийлээ. Одоогийн байдлаар 204 компанид санхүүгийн шинжилгээ хийхэд 167 компани СХЗ-нд санхүүгийн тайлангаа бүрэн ирүүлсэн. 120 компани тодорхой хэмжээний ашигтай, 47 компани алдагдалтай ажилласан байна. Монголын хөрөнгийн биржид арилжаа хийдэг компаниуд ашиг орлоготой байж хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийг арвижуулж өгөх ёстой. Гэтэл талаас илүү хувь нь алдагдалтай ажиллаж байна гэдэг бол хөрөнгө оруулагчдын ХК-д итгэх итгэл нь буурч байгааг харуулж байна. Бид шинжилгээний дүнг СЗХ-ны хуралдаанд танилцуулсан. Зөвхөн “Топ-20” төдийгүй цаашид 204 ХК-ийн санхүүгийн шинжилгээг ч мөн олон нийтэд дэлгэх болно.

–“Топ-20” компанийн хувьцаа эзэмшигчдэд дуулгах ямар мэдээлэл байна вэ?

-Өнгөрсөн оны байдлаар тэдний зургаа нь хасах тайлантай гарсан байна. Энэ бол маш том дохио өгч байгаа юм. Энэхүү шинжилгээг хийснээр ХК-иудыг цаашдаа ашигтай

ажиллах, ашигтай ажиллаж байгаа компаниудыг “Топ-20”-д оруулах хөшүүрэг болох юм. Мөн шинжилгээ нь хувьцаа эзэмшигчид хэдэн төгрөгийн ногдол ашиг авах боломжтой вэ гэдгийг бодитой харуулж байгаагаараа онцлог. Жишээ нь, 2011 оны байдлаар “Топ-20”-ийн тал нь, 2010 онд таван компани, 2009 онд зургаан компани тус тус ногдол ашиг тараасан байх жишээтэй. Гэтэл бодит орлоготой нь харьцуулахад ногдол ашиг авах боломж маш өндөр байдаг. Монголд ХК-ийн мэдээллийн ил тод байдал байхгүй. Компанийн тухай шинэ хуулиар ТУЗ-ийн хурлаар ногдол ашиг тараах үгүйгээ шийдээд, түүнийгээ хувьцаа эзэмшигчдийн хурлаараа баталгаажуулах ёстой. Хувьцаа эзэмшигчид үүнийг л хүлээж суудаг. Тэд хоёр л тохиолдолд ашиг олдог. Нэгдүгээрт, хувьцааны үнэ өссөн үед зарж, эсвэл ногдол ашиг авах байдлаар ашиг хүртдэг.

Бид “Топ-20”-ийн хувьцааны суурь шинжилгээг хийхдээ цэвэр өгөөжийн хэмжээгээр нь ангилсан. Борлуулалтын орлогыг цэвэр ашгийн түвшинтэй харьцуулахад цэвэр өгөөж гардаг. Энэ үзүүлэлтээрээ хамгийн сайн нь “Баянгол” зочид буудал байна. Өгөөж нь 0.45 хувьтай. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл нийт борлуулалтаас олж байгаа цэвэр ашиг нь 45 хувь байна гэсэн үг. Борлуулалтын орлогын бараг тал хувь нь цэвэр ашиг байгаа учраас менежмент сайтай зөв ажиллаж байна гэдгийг харуулж байгаа.

-Хүснэгтээс харахад ногдол ашиг тараах боломжтой компани нэлээд байгаа юм байна. Өмнөх онуудад ч тэд ногдол ашиг тараах боломжтой байж. Гэтэл ихэнх нь тараагаагүй байх юм. Энэ юутай холбоотой вэ? ▶

Цэвэр өгөөжийн үзүүлэлт	№	Symbol Хувьцааны үрсэн код	Company name - Хувьцаагч компанийн нэрс	Sector - Салбар	Balance sheet - Блансын тайлан (мянган төгрөг)			Income statement - Орлогын тайлан (мянган төгрөг)			
					Asset Хөрөнгө	Liabilities Өр төлбөр	Stock holders equity Эзэмшигчийн хөрөнгө	Revenue Борлуулалтын орлого	Operational expense Үйл ажиллагааны зардал	Non-Operational profit - Үйл ажиллагааны бус ашиг	Net profit - Цэвэр ашиг
20% дээш	1	BNG	BAYANGOL HOTEL	hotel	30,855,471.60	4,969,536.70	25,885,934.90	8,658,014.20	1,064,049.40	50,130.30	3,868,959.70
	2	ULN	ULAANBAATAR HOTEL	hotel	11,283,547.26	598,642.88	10,684,904.38	6,120,241.80	2,690,738.84	99,576.26	2,286,167.85
	3	BDS	BDSEC	Investment bank	9,923,790.10	239,990.78	9,683,799.32	5,802,926.51	3,019,336.04	-38,666.11	1,479,479.04
10%-20%	4	RMC	REMICON	construction materials	16,723,426.07	5,676,899.48	11,046,526.59	19,258,078.37	2,682,133.41	-111,097.89	2,738,601.71
	5	SHG	SHARYN GOL	coal mining	41,097,779.82	1,402,611.38	39,695,168.43	13,784,353.36	3,609,189.21	389,043.64	1,872,804.53
	6	GOV	GOBI	cashmere products	67,704,952.60	30,766,893.30	36,938,059.30	40,826,785.90	5,643,730.50	763,378.90	5,250,708.70
	7	SUU	SUU	Dairy product	28,923,153.80	18,033,749.90	10,889,403.90	24,880,484.10	3,351,744.30	-475,671.90	2,533,625.30
0%-10%	8	TTL	TAVANTOLGOI	coal mining	67,250,227.40	22,815,638.50	44,434,588.90	102,696,824.00	923,671.10	-1,879,132.10	9,188,233.50
	9	JTB	GENCO TOUR BUREAU	Tourism	8,968,655.60	385,350.90	8,583,304.70	2,773,012.60	1,090,506.90	-28,277.50	237,617.50
	10	APU	APU	beverage	169,776,504.57	83,683,144.85	86,093,359.72	284,335,454.42	109,375,446.71	-1,189,432.71	23,455,152.38
	11	TCK	TALKH CHKHER	bakery	33,277,517.90	15,750,326.00	17,527,191.90	20,688,667.60	3,419,243.00	-64,764.70	1,385,664.80
	12	BDL	MOGOIN GOL	coal mining	2,731,797.90	862,614.70	1,869,183.20	1,154,392.00	102,636.20	13,160.50	33,868.40
	13	MCH	TELECOM MONGOLIA	telecommunication	42,533,545.10	10,180,868.30	32,352,676.80	23,043,615.40	4,209,793.10	412,774.70	309,968.90
	14	MDR	MONGOLIAN DEVELOPMENT RESOURCE	Real Estate	18,215,518.17	1,917,527.30	16,297,990.89	540,767.10	1,003,688.90	1,356,380.77	810,871.33
0% доош хувь	15	MSH	HOTEL MONGOLIA	Tourism/hotel	5,592,605.10	2,317,207.00	3,275,398.10	909,575.70	635,336.00	-8,620.10	-18,415.40
	16	SIL	SILICATE	silk, brick, lime	9,041,974.70	5,126,646.80	3,915,327.90	3,206,251.60	284,745.30	-86,452.80	-109,452.10
	17	BAN	BAGANUUR	coal mining	94,060,833.10	70,525,623.30	23,535,209.80	74,145,520.60	10,356,729.80	-165,724.50	-5,802,392.40
	18	SHV	SHIVEE OVOO	coal mining	87,161,792.90	71,118,991.36	16,042,801.55	27,190,377.80	1,371,330.10	-314,216.40	-4,234,857.40
	19	UID	STATE DEPARTMENT STORE	trade, service	10,926,797.20	11,049,368.50	-122,571.30	2,279,703.10	2,908,329.80	-26,627.30	-655,257.10
	20	HGN	KHUKH GAN	Iron ore product	16,260,903.80	8,322,224.50	7,938,679.30	413,974.50	221,380.30	-13,927.90	-133,170.90

► -Ногдол ашгийг энд хамгийн дээд хувиар нь гаргасан. Өөрөөр хэлбэл, Цэвэр ашгаа нийт гаргасан хувьцааныхаа тоонд хуваахаар нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ гардаг. “Баянгол” зочид буудал гэхэд бүх цэвэр ашгаа ногдол ашгаар хуваарилна гэж үзэх юм бол нэгжийн үнэ нь 9145 төгрөг болно гэсэн үг. Тус компани өнгөрсөн гурван жилийн хугацаанд 250-300 төгрөгийн ногдол ашиг тарааж байж. “Сүү” ХК гэхэд өнгөрсөн гурван жилд нэг ч удаа ногдол ашиг өгч байгаагүй. Энэ удаа нэгж хувьцаанд 7300 төгрөгийн ногдол ашиг өгөх боломжтой. “Говь” компани 2011 онд 100 төгрөгийн ногдол ашиг тарааж байсан. Энэ жил 673 төгрөг өгч болж байна. Энэ мэтчлэн суурь шинжилгээ хувьцаа эзэмшигчдэд анализ хийх бэлэн мэдээлэл болж байгаа юм. Зөвхөн хувьцаа эзэмшигчид ч гэлтгүй ХК-ийн удирдлагууд анхаараад, энэ жил “Топ-20”-ийн хэдэд нь жагссан байна, дараа жил байраа хэдээр урагшлуулах боломжтойгоо харах ёстой.

-Ногдол ашиг заавал тараах ёстой биш, тараахгүй байсан ч болох юм биш үү?

-Ер нь бол компани заавал ногдол ашиг тараах ёстой биш л дээ. Олсон орлогоороо өөртөө хөрөнгө оруулалт хийгээд, хийсэн хөрөнгө оруулалтынхаа үр дүнд ашигтай ажиллаж байгаа бол нэг хэрэг. Харин дараа онд өгөх ногдол

ашгийн хэмжээг өмнөх жилийнхээс нь өсгөсөн байдлаар өгч болно.

Монголын нөхцөлд бизнесийн байгууллага 20 хувиас дээш хувийн ашигтай ажиллаж байж банкны 15-18 хувийн зээлээ төлөх боломжтой. Тэгэхээр жагсаалтын эхэнд орсон компаниуд бол зах зээл дээр оршин тогтнох чадавхитай гэдэг нь харагдаж байгаа. Дараа нь 10-20 хувийн өгөөжтэй компаниуд, тэгээд 0-10 хувь хүртэлх хэмжээтэй нь жагссан. Сүүлийн зургаан компани хасах тайлантай гарсан гэсэн үг. Борлуулалтын орлого олж байгаа ч гэсэн үйл ажиллагааны зардал нь нэмэгдсэн ч юм уу эсвэл их хэмжээний зээлтэй компаниуд алдагдалтай гараад байгаа.

-Нэр нь нэлээд сайнаар дуулддаг “Хөх ган” компани сүүл мушгисан байх юм.

-“Хөх ган” компанийн хувьд хэд хэдэн төмрийн ордтой. Өнгөрсөн жилийн хувьд сонгуультай холбоотой төмрийн баяжмалын бүтээгдэхүүний экспорт сайнгүй байсан нь үүнд нөлөөлсөн байх талтай. Хөрөнгийн хэмжээ нь 16 тэрбум, өр төлбөр нь 8.0 тэрбум, эзэмшигчийн хөрөнгө нь мөн хэмжээтэй байгаа нь боломжийн. Хамгийн гол нь өнгөрсөн оны борлуулалт нь тааруу байсан гэдэг нь харагдаж байна л даа. Борлуулалт хийсэн мөртлөө хасах тайлантай гараад байгаа компаниудын хувьд асуудалтай. ►►

Outstanding shares - Нийт гаргасан хувьцаа (ширхэг)	Хаалтын ханш 2013 оны 3-р сарын 21-ны байдлаар	Market Capitalization-Зах зээлийн багтаамж	Нэгж хувьцаанд ногдох (төгрөгөөр)					Net Margin - Цэвэр өгөөж	Ratio-Харьцаа			Market Indicators Зах зээлийн үзүүлэлт	
			Book value per share - Дансны үнэ	EPS - Нэгж хувьцаанд ноогдох борлуулалт	Dividend per share - Ногдол ашиг, FY2009, MNT	Dividend per share - Ногдол ашиг, FY2010, MNT	Dividend per share - Ногдол ашиг, FY2011, MNT		Өөрийн хөрөнгийн өгөөж ROE	Нийт хөрөнгийн өгөөж ROA	P/E Хувьцааны үнэ	P/B Дансны үнэ	
423,065	39,000.00	16,499,535,000	61,186.66	9,145.07	340.00	343.00	350.00	0.45	0.15	0.13	4.26	0.64	
335,297	93,600.00	31,383,799,200	31,866.98	6,818.34	250.73	300.00	300.00	0.37	0.21	0.20	13.73	2.94	
11,000,000	3,500.00	38,500,000,000	880.35	134.50	-	-	50.00	0.25	0.15	0.15	26.02	3.98	
78,679,464	196.00	15,421,174,944	140.40	34.81	-	1.60	5.00	0.14	0.25	0.16	5.63	1.40	
8,523,985	8,500.00	72,453,872,500	4,656.88	219.71	-	-	-	0.14	0.05	0.05	38.69	1.83	
7,801,125	4,510.00	35,183,073,750	4,734.97	673.07	-	100.00	100.00	0.13	0.14	0.08	6.70	0.95	
344,000	80,000.00	27,520,000,000	31,655.24	7,365.19	-	-	-	0.10	0.23	0.09	10.86	2.53	
52,665,200	6,600.00	347,590,320,000	843.72	174.46	550.00	1,300.00	1,368.00	0.09	0.21	0.14	37.83	7.82	
100,000,000	85.28	8,528,000,000	85.83	2.38	1.20	1.25	1.50	0.09	0.03	0.03	35.89	0.99	
74,287,700	3,503.00	260,229,813,100	1,158.92	315.73	20.00	40.00	60.00	0.08	0.27	0.14	11.09	3.02	
1,023,703	11,230.00	11,496,184,690	17,121.36	1,353.58	-	-	90.00	0.07	0.08	0.04	8.30	0.66	
829,622	14,000.00	11,614,708,000	2,253.05	40.82	-	5.00	5.00	0.03	0.02	0.01	342.94	6.21	
25,870,276	1,800.00	46,566,496,800	1,250.57	11.98	32.00	32.00	13.28	0.01	0.01	0.01	150.23	1.44	
13,750,000	910.00	12,512,500,000	1,120.10	58.97	-	-	-	N/A	0.05	0.04	15.43	0.81	
10,000,000	1,000.00	10,000,000,000	327.54	-1.84	-	-	-	-0.02	-0.01	0.00	-543.02	3.05	
46,334,602	198.00	9,174,251,196	84.50	-2.36	-	-	-	-0.03	-0.03	-0.01	-83.82	2.34	
20,974,360	4,500.00	94,384,620,000	1,122.09	-276.64	-	-	-	-0.08	-0.25	-0.06	-16.27	4.01	
13,419,101	7,000.00	93,933,707,000	2,025.84	-315.58	-	-	-	-0.16	-0.26	-0.05	-22.18	3.46	
36,807,850	390.00	14,355,061,500	-3.33	-17.80	-	5.00	-	-0.29	5.35	-0.06	-21.91	-117.12	
101,317,557	180.00	18,237,160,260	78.35	-1.31	-	-	-	-0.32	-0.02	-0.01	-136.95	2.30	

Жишээлэхэд “Шивээ –Овоо” ХК гэхэд 27 тэрбум төгрөгийн орлого олсон атлаа –4.2 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь хачирхалтай. Борлуулалт сайн хийсэн хэрнээ яагаад хасах тайлантай гараад байна вэ гэдгийг манай Компанийн засаглалын үндэсний зөвлөл маш чухалчилж үзнэ. Шаардлагатай гэвэл холбогдох байгууллагад мэдэгдэж, хамтарсан шалгалт оруулж, арга хэмжээ авна.

-Салбарын өрсөлдөөн талаас нь харвал ямар дүр зураг ажиглагдаж байна вэ?

Өнгөрсөн жил зочид буудлын салбар нэлээд боломжийн ажилласан гэдгийг “Баянгол”, “Улаанбаатар” компаниас харж болно. Гэтэл “Hotel Mongolia” компани борлуулалтын орлого нь 909 сая төгрөг байсан мөртлөө цэвэр ашиг нь -18 сая төгрөг байна. Яагаад үйл ажиллагааны зардал нь өндөр гараад байна вэ гэдэг асуудал тулгарч байна. Энд гурван төрлийн таамаг дэвшүүлж болно. Нэгдүгээрт, менежмент нь муу болоод үйл ажиллагааны зардал их гарч байж болох. Үгүй бол ногдол ашиг тараах зорилгогүй учраас ашгаа нуугаад зардлаа их гаргахыг үгүйсгэхгүй. Гуравдугаарт, өр төлбөр ихтэй компаниудын хувьд зээлдээ мөнгө нь яваад алдагдалтай гарсан байх талтай.

-Шинжилгээний үр дүн юу байх вэ?

Компанийн засаглалын үүднээс бизнес эрхлэх ёс зүйг

хэрэгжүүлэх, компанийн менежментийг сайжруулахад анхаарч буй юм. Хэрвээ менежмент нь муу байгаад үйл ажиллагааны зардал их гаргасан бол хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-өө өөрчлөх боломж гарч ирж байгаа гэсэн үг. ТУЗ нь хурлаа хийдэггүй, Компанийн тухай шинэ хуульд зааснаар ТУЗ-ийн гишүүд нь сургалтад сууж гэрчилгээ аваагүй байж болно. Гэтэл хууль хэрэгжээд жил гаруйн хугацаа өнгөрч байхад үл тоож яваа бол ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага нь өнөөдөр эрх зүйн чадамжгүй болсон гэдгийг онцлон хэлье. Тиймээс хувьцаа эзэмшигчдэд хуулиар нээгдсэн боломжоо ашиглах хэрэгтэй шүү гэдгийг дахин хэлэх байна.

-Хасах тайлантай компаниуд яагаад “Топ-20”-д байгаад байна вэ. 204 ХК-д шинжилгээ хийхэд 92 компани ашигтай ажилласан гэсэн биз дээ. Тэднээс ийшээ оруулж ирж болдоггүй юм уу?

Асуудлын гол нь энэ л дээ. Монголын хөрөнгийн биржийнхэн ч гэсэн хасах тайлантай компаниудыг яагаад “Топ-20”-д байлгаад буй нь сонин. Ашигтай ажиллаж байгаа 92 компаниас энд орж ирэх ёстой. Одоо бид компаниудыг салбарын түвшний өгөөжөөр нь гаргана. Тэгж байж сайн, муу ажилласныг нь бодитоор гаргаж, тухайн компанийн менежмент дээр ТУЗ нь хяналт тавьдаг, хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-дөө хяналт тавьдаг шаардлага бий болох юм. ■

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ



Засгийн газрын 2011 оны 69 тоот тогтоолоор Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр /КЗХҮХ/-ийг баталсан. Энэ хүрээнд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ТӨХК болон олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах юм. Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн даргаар СЗХ-ны гишүүн Д.Ганбаяр 2012 оны хоёрдугаар сараас томилогдон ажиллаж байна.

Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.

Компанийн засаглалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр

Зорилго 1. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх

- › Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах
- › ХХК, банк, санхүүгийн байгууллага мөрдөх онцлог заалтыг холбогдох Компанийн засаглалын кодекс нэмж тусгах
- › Засгийн газрын гадаадын хөрөнгө оруулалттай байгуулах төсөл, хөтөлбөрийн гэрээнд компанийн засаглалыг хэрэгжүүлэх талаар зүйл, заалт тусгасан байх

Зорилт 2. Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага манлайлах

- › Кодексыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гарган хэрэгжүүлэх
- › ТӨХК-иудын засаглалын түвшинг тогтоож олон нийтэд мэдээлэх
- › ТӨХК-иудын гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүн, хариуцлагын байдалд үнэлгээ хийж ангилал тогтоох
- › ТӨХК, үйлдвэрийн газрын ТУЗ, гүйцэтгэх удирдлагын хариуцлага болон урамшууллыг компанийн засаглалын түвшинтэй уялдуулах

Зорилго 3. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх компани, аж ахуйн нэгжийн удирдлага, менежментийг сайжруулах

- › ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг томилох үйл ажиллагааг засаглалын зарчим, хэм хэмжээнд нийцүүлэх
- › Хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах, хувьцаат засаглалд хөндлөнгийн үнэлгээ, хяналт, шалгалт хийх, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах механизмыг бий болгох
- › ТУЗ-ийн үйл ажиллагааг илүү боловсронгуй, хариуцлагатай болгох, өөрчлөлт хийж үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх
- › Засаглалын үнэлгээ хийх, олон нийтэд мэдээлэх тогтолцоо бий болгох ▶▶

► **Зорилго 4. Компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэхэд оролцогч талууд, тэдгээрийн төлөөллийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх**

- Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоод, хувьцаа эзэмшигчийн төлөөллийн байгууллагаар гүйцэтгүүлэх замаар тэдгээрийн чадавхийг бэхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх
- ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн төлөөллийн байгууллагад зориулсан сургалт, семинар зохион байгуулах, гарын авлага бэлтгэн хэвлүүлэх, түгээх
- Компанийн засаглалыг хөгжүүлэх хүрээнд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэх
- Компанийн засаглалын асуудлаар олон улсын байгууллага, гадаад орнуудтай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, туршлага судлах, түүнийг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

► Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мэргэжил-арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Компанийн засаглалын Үндэсний зөвлөлийг СЗХ-ны гишүүнээр ахлуулж ТӨХ, ЭЗХЯ, Монгол банк, Монголын хөрөнгийн бирж, Банкуудын холбоо, МҮХАҮТ, КЗХТ, АОЭНХ зэрэг байгууллагын удирдах албан тушаалтнаар бүрдүүлсэн.

► Үндэсний зөвлөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг жил бүр Засгийн газарт танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.



Ж.БОЛОРМАА
КЗҮЗ-ийн ахлах рефрент

Б.ГЭРШИХБӨРТЭ
КЗҮЗ-ийн рефрент

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үр дүн

Уг хөтөлбөрийг 2016 он хүртэл хэрэгжүүлэх бөгөөд дараах үр дүнд хүрэхээр ажиллаж байна. Үүнд:

- Хөрөнгийн болон санхүүгийн зах зээлийн хөгжилд ахиц, дэвшил гарна
- Компанийн засаглал, хариуцлага, хяналтын тогтолцоо сайжирна, нийгмийн өмнө хүлээх компанийн хариуцлага бий болно
- Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа өргөжинө
- Оролцогч талуудын мэдлэг, чадавхи дээшилнэ
- Татвар төлөгчдийн хөрөнгө зүй зохистой зарцуулагддаг болно
- ТӨХК, ХК-иудын ашиг, орлого нэмэгдэнэ
- Татвар төлөлт, ногдол ашиг тараалт ихэснэ
- Хөрөнгө оруулалт татах таатай нөхцөл бий болж эдийн засгийн өсөлт бий болно. ►►

► Үндэсний зөвлөл, ажлын албаны 2012 оны ажлын хэрэгжилт

Өнгөрсөн онд хийсэн ажлуудаас:

- Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн хурлыг хуралдуулах
- Дугуй ширээний уулзалт, хэлэлцүүлэг, форум зохион байгуулах
- Компанийн засаглалын портал сайтыг ажиллуулах
- Компанийн засаглалын сургалтын хөтөлбөрийн стандарт боловсруулж сургалтын есөн байгууллагаар хэрэгжүүлж байна
- Монгол-англи хэл дээр 14 хоног тутам хэвлэгдэн гардаг эдийн засаг, бизнесийн “Mongolian Economy” сэтгүүлтэй хамтран ажиллаж, байнгын нийтлэл гаргаж байна
- Мэргэжлийн холбоодуудын хүрээнд компанийн засаглалын чиглэлээр хамтран ажиллаж байна.
- Компанийн засаглалын зарчим, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, зөвлөмж, удирдамж гаргаж байгаа
- Компанийн засаглалын 2013 оны үндэсний тайлан боловсруулж байна.

Компанийн засаглалын портал сайт www.governance.mn

- Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны талаархи мэдээлэл
- Компанийн засаглалтай холбоотой линк, мэдээ, мэдээлэл
- ХК, ТӨХК-иудын Засаглал, санхүүгийн гүйцэтгэл, тайлан, мэдээ мэдээллийн дэд сайт
- ХК, ТӨХК-иудын Засаглал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дэд сайт
- ТУЗ-ийн гишүүдийн онлайн харилцаа холбоо тогтоох дэд сайт
- Компанийн засаглалын үнэлгээний дэд сайт
- Компанийн засаглалын онлайн сургалтын дэд сайт
- ТУЗ-ийн гишүүн болох хүсэлтэй хүмүүсийн мэдээллийн баазын дэд сайт

Компанийн засаглалтай холбоотой иж бүрэн мэдээллийг авч болох боломж бүрдүүлж өгөх бөгөөд Сайтаар дамжуулан СЗХ, ТӨХ нь компаниудын ТУЗ-ийн гишүүдийг хянах, тэдэнд мэдээлэл хүргэх өргөн боломж бүрдэх бөгөөд компанийн ТУЗ-ийн гишүүд нь хоорондоо онлайнаар холбогдож шаардлагатай мэдээ, мэдээллийг солилцох боломж бүрдэнэ. Цаашилбал компанийн хараат бус ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулахад хүний нөөцийн мэдээллийн баазыг бүрэн ашиглах боломжтой юм.



Компаниудын засаглалын үнэлгээ хийж зэрэглэл тогтоох

- USAID, ВПИ-төслийн боловсруулсан Компанийн засаглалын үнэлгээний аргачлалыг боловсруулж дууссан.
- ► IFC байгууллагатай хамтран ТОП-20 ХК-ийн компанийн засаглалын үнэлгээг хийж байна.

▶ **“Mongolian Economy” сэтгүүлтэй хамтран ажиллаж байна**

▶ Монгол-англи хэл дээр 14 хоног тутам хэвлэгдэн гардаг эдийн засаг, бизнесийн “Mongolian Economy” сэтгүүлтэй хамтран ажиллаж, “Компанийн засаглал” гэсэн байнгын булан нээгээд байна.

Компанийн засаглалын талаархи онол, практикийг бизнес эрхлэгчдэд ойлгуулах, зөвлөгөө өгөх, Үндэсний зөвлөлөөс гаргаж байгаа зөвлөмжүүдийг хүргэх Сайн засаглалтай ХК, ТӨХК-иудын засаглалыг нэвтрүүлсэн туршлагаас хуваалцах, мэдээлэл хүргэх

▶ Оролцогч компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, мэдээллийг олон нийтэд хүргэх байдал, засаглалын зарчмын хэрэгжилтийн талаарх мэдээлэл багтдаг.



Компанийн засаглалын сургалт

▶ Компанийн тухай хуулийн 75.8-д “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна” гэж заасан.

▶ Сургалтын хөтөлбөр нийт 14 сэдвээс бүрдэх бөгөөд анхан шатны хоёр өдрийн, ахисан түвшний мөн өдрийн нийт дөрөв хоногийн сургалт юм.

▶ Дотоодын найман сургалтын байгууллагын 70 гаруй үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг 2012 оны аравдугаар сард Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс санаачилан Банк, санхүүгийн академитай хамтран зохион байгуулсан.


▶ Дараахи байгууллагууд Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалт явуулахаар КЗҮЗ-тэй гэрээтэй ажиллаж байна.

Үүнд:

- Банк, санхүүгийн академи
- Арилжаа эрхлэгчдийн холбоо
- Компанийн засаглалын хөгжлийн төв
- Компанийн засаглалын институт
- Ажил олгогч эздийн холбоо
- Удирдлагын академи
- Худалдаа аж үйлдвэрийн танхим
- Юрэ Партнерс
- Монголын мэргэшсэн НББ институт



КЛАСТЕРИЙН ТУРШЛАГА



“ДЭЛХИЙН ЭМИЙН САН”-Д НУТАГШСАН КЛАСТЕР

Х.ХУЛАН

Дэлхийн зах зээл дээр санхүүгийн Хямралын харанга дэлдсээр л байна. Өнөөдөр Европд, маргааш хаана ч нүүрлэж болзошгүй энэхүү хямралыг “хазаарлах” арга байдаг болов уу. Эдийн засагчид энэхүү асуултад олон хариулт өгч байгаагийн нэг нь бизнесийн сайн стратеги гэдэг. Инновацийг нэвтрүүлэн дэмжиж, хямралын эсрэг тууштай тэмцэх арга бол кластер гэдгийг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч байна.

Хямралыг “хазаарлагч”

Эл бизнесийн стратегийг Харвардын Их сургуулийн профессор Майкл Портман анх 1990-ээд онд “Улс, орнуудын өрсөлдөөний давуу байдал” номондоо дэвшүүлсэн. Үүнээс хойш кластерийг дэлхийн олон улсад амжилттай хэрэгжүүлж буй. Нэгэн жишээ дурдахад, кластерийн сүлжээнд нэгдсэн компаниуд 2008 оны эдийн засгийн хямралыг хохиролбагатай туулсан гэж ХБНГУ-ын Хессен мужийн Эдийн засгийн яамны мэргэжилтэн Хайке Бассе ярьж байсан. Хямрал газар сайгүй тохиолдох ч маргаашийн зах зээл дээр “мишээсэн ирээдүйтэй” гэж хэлж болохуйц салбарууд багагүй бий. Эдгээрээс бидний амьдралд хамгийн ойр байдаг нэгэн салбарт

хэрэгжүүлж буй Германы CI-3 кластерын туршлагаас танилцуулъя.

Дархлаагаа сайжруулья

“Дэлхийн эмийн сан” нэрээр алдаршсан Райн-Майн бүс нь Европын эмзүйн хамгийн том төв. Бүс нутгийн хэмжээнд дөрвөн том, 200 гаруй жижиг, дунд био-технологийн үйлдвэр, Майнц хотын их сургууль болон томоохон судалгааны байгууллагууд оршдог. Гучин мянган ажилтантай дээрх эмзүйн компани жилд 20 тэрбум еврогийн орлоготой ажилладаг. Эм, эмийн бүтээгдэхүүн Германы экспортын 54 хувийг эзэлж буй нь энэхүү салбар улсын эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна (Хүснэгт 1-ийг үзнэ үү). Сонирхуулахад, тус үйлдвэр нь судалгааны төв, их сургуулиудтай хамтарч жилийн турш эмийн 150 шинэ бэлдмэл туршилтаар гаргадаг. Эм зүй болон анагаах ухааны салбарын мэргэжилтэн, судлаач, бизнесийн төлөөллийн нэг дор төвлөрсөн энэ нөхцөл нь дархлаа судлалын CI-3 (Immunology Cluster гэсэн үгний товчлол) кластер хөгжих боломж болсон юм. Өөрөөр хэлбэл, кластерийг хөгжүүлэх хүний нөөц тэнд бүрэлдэн бий болсон гэсэн үг. Өнөөдөр ►►

► зах зээл дээр гарч байгаа эмийг ихэвчлэн тухайн өвчтний ерөнхий хэв шинжэд үндэслэн гаргадаг. Гэтэл хүний онцлог, амьдралынх нь хэв маягаас шалтгаалж зарим эм тэр бүр таарахгүй тохиолдол олон. Учир нь, эмзүйн салбар ихэвчлэн нийт хүн амд зориулсан эм бэлддэг. Дархлаа судлалын CI-3 кластер үүнээс ондоо, шинэлэг зарчмаар ажилладаг. Юуны өмнө масс бус, хэсэг бүлэг хүний өвчнийг судалж, тэдгээрийн генетик болон дархлаагаар нь дагнасан цогц судалгаа хийдгээрээ онцлог юм.

Райн-Майн буюу хоёр бүс дамнасан энэхүү кластер нь эмчилгээгүй гэгдэх хавдар, халдварт өвчнийг анагаах эм бэлдмэлийг олон улсын зах зээлд нийлүүлэх, эрүүл мэндийн салбарыг ахисан түвшинд хүргэх, эмчилгээний шинэ нээлт хийх урт хугацааны зорилготой. Германы Засгийн газраас кластерийг бодлогоор дэмжихээс гадна санхүүжилт дээр мөн хувь нэмрээ оруулдаг. CI-3 кластер эдүгээ улс төр, эдийн засгийн салбарын 120-иод түнш байгууллага, 35 судалгаа шинжилгээний төвтэй хамтран ажиллаж байна. Олон талт хамтын ажиллагааг өрнүүлж, анагаахын салбарт жинтэй хувь нэмэр оруулан нэмүү өртөг бий болгож буй нь эрүүл мэндийн салбарын кластер жинхэнэ утгаараа хөгжиж байгаагийн тод жишээ юм.

Дархлаа судлалын CI-3 кластер үүнээс ондоо, шинэлэг зарчмаар ажилладаг. Юуны өмнө масс бус, хэсэг бүлэг хүний өвчнийг судалж, тэдгээрийн генетик болон дархлаагаар нь дагнасан цогц судалгаа хийдгээрээ онцлог юм.

ХБНГУ-ын экспортын гол бүтээгдэхүүн- 2012 (тэрбум евро)



Др.Райнер Вессель /CI-3 кластерийн менежер/



Д.Цацрал /Кластерийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Шинэчлэлд хүргэх боломж

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга” хөтөлбөрөөс “Кластерийн хэрэгжилт, бодлоготой танилцах аялал”-ыг 2012 онд санаачлан зохион байгуулсан билээ. CI-3 кластерийн менежер Др.Райнер Вессель, хөтөлбөрийн кластерийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Цацрал нараас дараах тодруулгыг авсан юм.

-Др. Вессель, эрүүл мэндийн салбарт кластерийн аргыг хэрэгжүүлэхэд нэн тэргүүнд юуг анхаарах ёстой вэ?

Др.Вессель: -Үүнд юуны өмнө тухайн орон нутагт байрлах эмзүй, биотехнологийн компанийн байршил, судалгааны байгууллагын чадавх чухал үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн кластерийн чиглэл, зорилго маш зөв гаргах нь зүйтэй.

-Эрүүл мэндийн салбарт кластерийг хөгжүүлэх нь давуу тал авчрах уу?

Др.Вессель: -Эрүүл мэндийн салбарын кластерийг хөгжүүлснээр аж үйлдвэр, улс төр, судалгаа болон эрүүл мэндийн салбарын байгууллагуудын нэгдсэн сүлжээ бий болгож, хамтын хүчин чармайлттайгаар нэмүү өртгийн сүлжээн дэх инновацийн нөөц бололцоог гаргахад оршдог. Энэ нь шинэ зах зээлийн боломжийг нээж, бэхжүүлэх ач холбогдолтой юм. ►

► -Эрүүл мэндийн салбарт кластер бий болгохыг сонирхсон монгол эмч нарт Та юу зөвлөх вэ. Кластерийн бүтэц эрдэм шинжилгээний ажлыг сайжруулж, эмч нарын ур чадварыг нэмэгдүүлж чадах уу?

Др. Вессель: -Тухайн бүсийн бизнесийн байгууллагууд эрдэм шинжилгээний тэргүүлэх туршлагыг нэвтрүүлснээр зах зээл дээр шинэлэг бүтээгдэхүүн гаргах шинэ стратеги бий болгодог. Кластер хэрэгжүүлэх орон нутгийн мэргэжилтний боловсрол, мэдлэг чадвараас шалтгаалж тухайн кластерийн тогтвортой байх эсэх нь шийдэгддэг.

-CI-3 кластерийн туршлагаас юу суралцсан бэ. Ямар шинэлэг мэдээлэл, санаа олж авсан?

Д.Цацрал: -Бид кластерийн аяллын явцад төрөөс хүн ам, нийгэмд хэрэгтэй салбарыг бодлогоор дэмжиж болдгийн тод жишээг харсан. Эрүүл мэндийн салбар бизнесийн салбар биш болохоор судалгааны томоохон ажлыг дан ганц эмнэлэг юм уу, судалгааны байгууллага үндсэн үйл ажиллагааныхаа хажуугаар бие даан хийхэд хүндрэл гардаг. Ер нь кластерийг хөгжүүлэхийн давуу тал нь аливаа салбарыг цогцоор нь системтэй эцсийн хэрэглээ хүртэл хөгжүүлэх, дэмжих боломжтой болдог оршино.

Үүнээс гадна бидний ойлгож авсан шинэ зүйл бол Life science гэж англи орчуулга нь боловч шууд амьд байгалийн юм уу, биологийн шинжлэх ухаанаас арай өөр шинэ ойлголт юм. Энэ нь амьд байгаль, түүний хүрээлэн байгаа орчин ба нийгмийн төлөв байдлын хоорондын хамаарлыг судалдаг шинжлэх ухааны салбар юм байна. Өөрөөр хэлбэл өнөөгийн нийгмийн хэв шинж, үйлдвэрлэлийн хөгжил, хүмүүсийн ухамсартай, санамсаргүй үйлдэл, хэвшил зэрэг нь бидний өдөр тутмын амьдрал, цаашлаад эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдгийг судалдаг. Энэхүү шинжлэх ухааны судалгаагаар өнөөдрийн эм зүйн салбарт үйлдвэрлэн нийлүүлж буй эм бэлдмэлүүд бидний биед үнэхээр үйлчилдэг үү. Эм уух жор, тун хүн бүрт адилхан байна гэдэг зөв үү зэрэгт хариулт олохыг зорьдог байна.

-Монголын нөхцөлд эрүүл мэндийн салбарын кластерийг хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна уу?

Д.Цацрал: -Шууд тийм, үгүй гэхээсээ илүү "Энэ чиглэлийн суурь боловсон хүчин, судалгааны туршлага байгаа бил үү" гэдгийг бодолцох хэрэгтэй байх л даа. Өнөөдөр бид энгийн шинжилгээ хийлгэхээр Солонгос, Тайланд юм уу урд хөрш рүүгээ өндөр зардлаар явж байна. Ийм хэмжээний ажлыг эхлүүлэх хөрөнгө оруулалтыг нь ямар нэг байдлаар шийдлээ гэхэд бид монгол хүний дархлааг судалсан цогц суурь судлагаа бий юу. Ийм өндөр түвшний судалгааг нэвтрүүлэх эм зүй, биотехнологийн хэдэн үйлдвэр байгаа вэ, тэдний үйлдвэрлэлийн түвшин, чадамж хэр вэ гээд асуудал их гарах байх.

Гэхдээ бид өнөөдөр чадахгүй гээд хойш тавих биш хамтран туршлага солилцох, ядаж тэр Life science гэдэг ойлголтыг нэвтрүүлэх, гол нь ийм ажлыг дааж явуулах боловсон хүчнийг бэлтгэх ажлаас эхлэх нь зүйтэй байх.

Кластер гэдэг шууд эхлэхдээ л тийм олон байгууллага багтаасан том бүрэлдэхүүнтэй байдаггүй. Хөгжлийн явцад хүрээгээ тэлдэг. Сайн боловсон хүчин, санааг нь үйлдвэрлэлдээ нэвтрүүлэхэд бэлэн бизнесийнхэн, эрсдлээс илүү ирээдүйн өгөөжийг олж харах санхүүгийн институт, тэдний үйл ажиллагааг дэмжих төрийн зөв бодлого байвал жижгээс том руу хөгжих боломжийг кластерийн менежмент олгодог. ■

ШИЛДЭГ ИЛТГЭЛ

ЯАН КЛАВИТТЕР

/Женев дэх Дэлхийн эдийн засгийн форумын уул уурхай, хүнд үйлдвэр харууцсан захирал/

Монгол Улс нь нийгмийн хөгжилд татан оролцуулах чиглэлд өөр өөр зарчмууд байдгийг танин мэдэж судлахын зэрэгцээ стандартуудаа боловсруулах талд суралцах хэрэгтэй. Даяаршил Монголд ирж, Монгол даяаршсан ертөнцөд хүрч иржээ. Орон нутгийн компаниуд нь ч олон улсын компаниудын адил хөгжил өөд хүрэхээр зүтгэж байна.

Зөвлөлт холбоот улс болон Монголын социалист тогтолцоо нуран унасны дараах 10 жилд буюу 90-ээд онд дэлхийн эдийн засаг Монголын эдийн засагт маш бага нөлөө үзүүлж байв. Худалдаа, экспорт, дотоодын нийт бүтээгдэхүүн, валютын ханш гэх мэт хүчин зүйлсийг хамруулаад шүү дээ. Харин 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал Монголын эдийн засагт багагүй нөлөөлсөн нь Монгол орон дэлхийд хэдийнэ хөл тавьсны дохио болж байна. Өнөөдөр танай улс дэлхийн тавцанд шинэ байр сууриар улс орноо удирдах үүрэг хүлээж байна. Компаниудын хувьд урьд өмнө нь байгаагүй шинэ дарамт шахалтыг хэрхэн давах талд суралцаж байна.

КНХ-ын тал дээр гаргах амжилт тодорхой зүйлд анхаарлаа хандуулсан байдал, хүчтэй санаачлагчид болон захиалагчийн баазаас хамаарна. Хамгийн чухал нь захиалагчийн бааз ашиг тус их хүртэхэд оролцохын адил хөтөлбөрүүдийг бий болоход ч гэсэн түлхүү оролцох ёстой. Аль хэдийнээ хийх ажил их болсон ба цаашид ч их хэмжээгээр өсөх болно. Монгол Канадынх шиг бодлого хэрэгжүүлж болох юм. Канад улсад гадаад, дотоодод ажилладаг уул уурхайн компаниудыг зохицуулах КНХ-ын зөвлөл байгуулагдсан билээ. ►

МОНГОЛ ДАЯАРШСАН ЕРТӨНЦӨД ХҮРЧ ИРЖЭЭ

► Компанийн нийгэмд гүйцэтгэх үүргийн таван зарчим

Компанийн дэлхий дахины иргэншил: Дэлхий нийтийг хамарсан нийгмийн гол бэрхшээл рүү чиглүүлсэн үйл явц, түншлэлд иргэний нийгэм, төр болон их дээд сургуулийн хамт оролцох явдал

Компанийн нийгмийн хариуцлага: Оролцогч талын хүлээлтэд хариу үйлдэх, санхүү, байгаль орчин, нийгмийн нөлөөг авч үзэж, ашигтай байдлыг дээд хэмжээнд нь тултал өсгөх

Компанийн засаглал: Үнэ цэнэ болон зарчмыг чиглүүлэх, ёс зүйн хэм хэмжээ, хуулийг хэрэгжүүлж баримтлах

Компанийн нийгмийн аж ахуй эрхлэлт: Дэлхийн хэмжээнд нийгмийн сайн сайхныг сайжруулж дээшлүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн шинийг бүтээн байгуулах чадамжийг ашиглах

Компанийн буяны үйл ажиллагаа: Мөнгө, бараа, цаг заваа хандивлах эсхүл буяны үйл ажиллагааг дэмжсэн хичээл зүтгэл



Стандарт дээр гарах бэрхшээл /Сайн дурын зарчим/

1. Стандартын будлиантай болон давхцсан дүр төрх
 - Бэрхшээл болон хамрах хүрээ
 - Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл
2. Үр ашиг тодорхой бус
 - Хэмжиж болохуйц
 - Шууд хамааруулна
3. Хэрэгжүүлэлт
 - Хүчин чадал
 - Бэлэн байдал
 - Захиргааны саад бэрхшээл
 - “цаасан дээр” эсхүл “газар дээр”
4. Хариуцлага
 - “шүд”
 - Удирдлагын механизмын хэрэгжилт:
 - Хяналт
 - Мэдээлэх
 - Итгэмжлэл
 - Үр дагаврын удирдлага
5. Амжилтын шүүмжлэлтэй хүчин зүйлс
 - Гол чиглэлээ тодорхой болгох
 - Хүчтэй санаачлагч
 - Хэрэглэгчийг төлөөлөх үндэс суурь ■

БОДЛОГЫН СУДАЛГАА

ХЭРЭГЛЭГЧИЙН СОНГОЛТ БА АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ

СЭЗДС-ийн Бизнесийн удирдлагын тэнхимийн багш Э.Одонтамир, Ч.Долгорсүрэн нарын “Монгол хүний амьдралын үнэ цэнийг тодорхойлох нь” сэдэвт судалгааны товч дүгнэлтийг хүргэж байна.



Хөтөч

Хүн амьдралын хэв маяг, үйлдлээрээ дотор байгаа үнэт зүйлсээ илэрхийлж гаргадаг. Үүнээс гадна зугаа цэнгэлээс илүүтэй өөрийгөө хүндлүүлэх, элэгсэг харилцаанд илүү тааламжтай ханддаг аж. Мөн амьдралын үнэ цэнэ бусдаар хүндлүүлэх, элэгсэг харилцаа, өөрийгөө хүндлэх, санхүүгийн хангамж, амжилтын мэдрэмж, инээд хөөр, өөрийн гүйцэтгэл гээд олон зүйлээс хамаарч байна. Өнөө цагт хэрэглэгчээ таних мэдэх нь бүхий л бизнесийн байгууллагын нэн тэргүүний асуудал болж ирсэн. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчээ таних нь амжилтын гол үндэс болж байна. Хэрэглэгчид юу хүсдэг, тэдний дотор юу нуугдан байгааг нээн илрүүлснээр бизнесийн байгууллагууд ямар бараа, үйлчилгээ буй болгох, хэрхэн хүргэх арга замаа тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчдээ хүрэх зах зээлийнхээ гүүрийг тодорхойлдог юм.

Хэрэглэгчдийн зан төлөв нь тухайн хэрэглэгчдийн амьдарч байгаа газар нутаг, хүрээлэн буй орчин, соёл, нийгэм эдийн засгийн нөхцөлөөс хамааран улс бүрт харилцан адилгүй. Дэлхийн хөгжингүй орнуудын эрдэмтэн, судлаачид өөр өөрийн орны хэрэглэгчдийн зан төлөвийг тал бүрээс нь судалж тогтоон, үечлэлтэйгээр өөрчлөлт, хөгжлийг нь тодорхойлж ирсэн.

Хүн аливаа зүйлд эрхэмлэн хандаж буй итгэл үнэмшлийг амьдралын үнэ цэнэ гэдэг. Нэг талаасаа хэрэглэгч бол тааварлашгүй оньсого юм. Та хэзээ ч тэдний нүдийг харж байгаад пепси эсвэл кола авна гэдгийг хэлж

► чадахгүй. Гэвч хэрэглэгчийн үнэт зүйлс, сэтгэл зүйг судалснаар магадгүй энэ хүн жүүс авах байх гэдгийг таамаглаж болно.

Учир нь, хэрэглэгчийн үнэ цэнэ нь шийдвэр гаргалтад хүчтэй нөлөөлдөг гол үзүүлэлт болдог аж. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчийн гол үнэт зүйлс нь тухайн хүний итгэл үнэмшил, хандлага, зан төлөвийн суурь болж, урт хугацаанд бүрэлдэн тогтдог. Үнэт зүйлс нь ёс заншил, гэр бүл, хүрээлэн буй нийгэм гээд олон нөхцлийн дор бүрэлддэг байна.

Хүн амьдралын хэв маяг үйлдлээрээ дотор байгаа үнэ цэнэтэй зүйлсээ гаргадаг. Ерөнхийдөө үнэ цэнэ гэдэг нь хэрэглэгч тодорхой нөхцөлд, нэг чигт зүйлийг хүсэмжлэх, тийш чиглэх, итгэл үнэмшил, зан төлөвийн сонголтын хөтөч болдог байна.

Хүмүүс бараа, бүтээгдэхүүн худалдан авахдаа тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээ тэдний үнэ цэнэд суурилсан, зорилгодоо хүрэхэд нь тусална гэдэгт итгэдэг. “Blackwell”-ийн судалгаагаар хүмүүс өөрт хамгийн ойрхон үнэ цэнэтэй зүйлсийг сонгож авдаг нь нотлогджээ. Ажилдаа дуртай, ажил нь хамгийн чухал гэсэн хүмүүс энэ төрлийн агууламж бүхий бараа, сурталчилгааг сонгосон бол гэр бүл хамгийн үнэ цэнэтэй гэсэн хэрэглэгчид гэр бүлд нь тус болох бараа, үйлчилгээг сонгож буйг судалгааны үр дүн харуулжээ. Хэрэглэгчийн үнэт зүйлс нь улс бүрт өөрийн онцлогтойгоор, тэдний итгэл үнэмшил, хандлага, зан төлөвийн суурь болж, урт хугацаанд бүрэлдэн тогтдог хэмээн дүгнэсэн байдаг. Монгол хэрэглэгчид өөрсдийн гэсэн өвөрмөц амьдралын үнэт зүйлсийн тогтолцоотой.

Дүгнэлт:

Энэ судалгааны үндсэн зорилго нь Монгол хэрэглэгчдийн үнэ цэнэтэй зүйлсийг тодорхойлох. Энэ нь амьдралын хэв маяг, хувь хүний хүчин зүйлстэй хэрхэн хамаарч байгааг судлах. Судалгааны үр дүнгээс, үнэ цэнэтэй зүйлс нь Монгол хэрэглэгчдийн зан төлөвийг тодорхойлохуйц хүчтэй хүчин зүйл болох нь нотлогдлоо. Энэ нь нэг талаар өөрийгөө танин мэдэх, хөгжүүлэх, өөртөө сэтгэл хангалуун байх хэрэгцээ өндөртэйг илтгэнэ. Судалгаагаар амьдралын үнэ цэнэтэй зүйлс хэрэглэгчийн наснаас бүрэн хамааралтай, ялгаатай бөгөөд хүйс, гэр бүл орлого, боловсролын хувьд өндөр хамааралтай биш ч, тодорхой ялгаа бүхий хандлагууд байдаг нь ажиглагдлаа.

Мөн таван үнэ цэнэтэй зүйлс /бусдаар хүндлүүлэх, өөрийгөө хүндлэх, өөрийн гүйцэтгэл, амжилтын мэдрэмж, хамаатай байх мэдрэмж/ нь хэрэглэгчийн амьдралын хэв маягаас хамааралтай болох нь судалгаагаар илэрч байна. Судалгааны үр дүнд үндэслэн дараах гол дүгнэлтэд хүрлээ. Үүнд:

Нэгдүгээрт: Монгол хэрэглэгчийн үнэ цэнт зүйлс өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Франц болон Японы хэрэглэгчдийн баримталж буй эхний хоёр үнэ цэнт зүйлс болох өөрийгөө хүндэтгэх, элэгсэх харилцаа чухал гэсэн эрэмбийн хувьд ижил байв. Харин бусад орнуудтай харьцуулахад ялгаатай байлаа.

Хоёрдугаарт: Судалгааны үр дүнг бизнесийн болон бусад байгууллага маркетинг, сурталчилгааны шийдвэр гаргалтад бүрэн ашиглаж болохуйц байна. Ялангуяа хэрэглэгчид насны ангиллаас хамааран үнэ цэнэтэй зүйлс нь ялгаатай байх байдал хүчтэй хамааралтай байна. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч залуу байх тусмаа өөрийгөө хүндлэх үнэт зүйл давамгайлж байгаа тул тэдэнд хандсан энэ төрлийн мэдэгдлийг илгээх, дунд насныхны хувьд санхүүгийн хангамжийг илүү чухалчилдаг байна. Хэрэглэгч нас ахих тусам бусдаар хүндлүүлэх үнэ цэнэ, хэрэгцээ нэмэгдэж байгаа зэрэг нь байгууллагуудын хувьд анхааралдаа авах хүчин зүйлст тооцогдож байна. Мөн хүчтэй хамааралтай биш боловч тухайн хүний боловсрол, гэрлэлт, орлого, шүтлэгийн байдал нь тодорхой үнэ цэнүүдийн хүрээнд ялгаатай байх хандлага ажиглагдлаа.

Зөвлөмж:

Хэрэглэгчийн судалгаанд үндэслэн зорилтот зах зээлээ тодорхойлох, баримжаалах боломжийг олгож байна. Судалгаа нь “Монгол хэрэглэгч”-ийн гэдэг тодотголтойгоор хүмүүний зан төлөвт хамаарах олон хүчин зүйлийн суурийг таних оролдлого боллоо. Хэрэглэгчдийг сегмент болгон хуваахдаа “хувь хүний хүчин зүйл” болох нас чухал ач холбогдолтой байгааг анхаарах хэрэгтэйг судалгааны дүн илэрхийлж байна.

Бараа, үйлчилгээний онцлог, маркетингийн харилцаа буюу зар сурталчилгааны агуулга бүтээлт, түгээлтэд хэрэглэгчийн үнэ цэнийг тусгах. Мөн хэрэглэгчийн нас болон амьдрах хэв маягийн онцлогоос шалтгаалан юуг чухалчилж байгаа, ямар үнэт зүйлийг эрхэмлэж байгаа нь брэндийн имиж бүрдүүлэлтэд нөлөөлөх аж. ■

АФРИК БА БНХАУ



АШИГТ МАЛТМАЛААС Ч ИХ

Орчуулсан Р.ГАНТУЛГА

БНХАУ, Африкийн худалдаа өргөжихийн хэрээр нео-колончлолын айдас хэрээс хэтрэв

Бээжингээс таван жуулчин хувийн онгоцоороо Африкийн Кени уулын доохнуур өнгөрч, цавчим хөндийгөөр аялж яваа нь энэ ажээ. Тэдний очих газар бол мөчиргүй шар мод болон манан шиг өнгөтэй хинийн модны мөчрөөр хүрээлэгдсэн онгоц буух шороон зурвас. Тэрбээр эрээн тахь, анааш хэрэн тэнүүчлэх ногоон цоорхойг хөндлөн гулд алхаж, зураг татангаа одос үхрийг уурлуулчих вий хэмээн болгоомжилно. Тэд ширээгээ засч суух үедээ өлссөн янзтай боловч санаа зовсон шинжгүй. Тэдний дунд гэрийн эзэгтэй хоёр байх бөгөөд нэг нь “Өнгөрсөн жил би өмнөд туйл руу найзуудтайгаа аялсан” гэж хэлээд мөнх цэвдэг дээгүүр сүрэлгэх оцон шувууны зургийг iPhone утаснаасаа үзүүлэв.


БНХАУ-ын иргэд сүүлийн үед Африкт олноороо суурьших болсон нь аялах, ажиллах болон худалдаа эрхлэхэд тохиромжтой газар гэж үзэж байгаатай холбоотой. Арван жилийн өмнө Африкт ажиллаж, амьдарч байсан хятад иргэдийн тоо хэдхэн мянгаар хэмжигдэж байсан бол өнөөдөр нэг сая гаруй хүн суурьшсан, цаашдаа ч улам нэмэгдэх хандлагатай гэсэн тооцоо байна.

Өмнөд Африк руу аялах жуулчдын тоогоороо Хятад дөрөвт эрэмблэгдэж байгаа аж. Тэдний дунд БНХАУ-ын шинэ удирдагч Си Жинпин ч мөн цохиж явна. Тэрбээр Ерөнхийлөгч болсноосоо хойш Танзани болон Конго улс руу анхныхаа албан ёсны айлчлалыг хийж буй нь энэ.

Урд хөршийн маань сэтгэлийг Африк юунд тэгтлээ их татах болсныг мэдэж цөхөөд байх зүйлгүй. БНХАУ-ын үйлдвэрлэлд шаардагдах олон төрлийн түүхий эд Сахар болон Калахари цөлийн хооронд газрын хэвлийд нуугдаж буй. Сүүлийн үед БНХАУ газрын тосны импортоороо АНУ-ыг ардаа орхиж, хамгийн том импортлогч болоод байгаа билээ. Харин Африкаас импортолж буй бүтээгдэхүүнийх нь 80 гаруй хувийг ашигт малтмал эзэлж байна. Мөн Африкийн бизнесийн “топ” түнш болсон бөгөөд худалдааны үнийн дүн нь 166 тэрбум ам.доллар даваад байгаа аж. Гэхдээ мэдээж бүгд ашигт малтмал биш. БНХАУ-аас Африк руу чиглэсэн экспорт бол янз бүрийн зүйлийн цуглуулгаас бүрдэнэ (Хүснэгтийг харна уу). Үүнд машин техник 29 хүртэлх хувийг эзэлж байгаа юм.

Ашигт малтмал, тоног төхөөрөмж

БНХАУ, Африкийн худалдаа, 2010 он, ам.доллараар



БНХАУ-аас Африкт хийсэн шууд хөрөнгө оруулалтын хэмжээг гаргах нь худалдааны хэмжээг гаргахаас хэцүү. Өнгөрсөн зун БНХАУ-ын худалдааны сайд Чэн Дэминг шууд хөрөнгө оруулалт 14.7 тэрбум ам.доллар давж, 2009 оныхоос 60 хувиар нэмэгдсэн талаар хэлжээ. Үүнд мэдээж Африкт хийгдсэн хөрөнгө оруулалтын талаар Засгийн газартаа тайлагнасан тоо, баримт байж таараа. Харин БНХАУ-аас Өмнөд Африкт суугаа Онц бөгөөд Бүрэн эрхэт Элчин сайд Тиан Шүэжүн “Африкт манай улсаас ▶

▶ олон төрлийн хөрөнгө оруулалт хийж байгаа бөгөөд нийт үнийн дүн 40 тэрбум ам.доллар давсан” гэж хэлсэн бөгөөд үүнд дэлхий дахины татвараас зайлсхийгчдээс БНХАУ-ын сангуудаар дамжин урсан орж ирж буй тооцоо багтаж байгаа юм.

Сино-Африкийн харилцаа сүүлийн хэдэн жил улам өргөжин тэлсээр. Тэдний өнөөгийн харилцаа Африк тивд олон орон байдаг шиг л төрөлжих болсон. 1970-аад оны үед Герман гаралтай АНУ-ын дипломатч, бизнесмэн Хэнри Альфред Киссинжер Европын орнуудад нөлөөлж чадах ганц ч болов утасны дугаарыг олох гэж домогт эрлээ эхэлж байсан түүхтэй. Үүний нэгэн адил Ерөнхийлөгч Си Жинпин Африкийн орнуудад үгийг нь дамжуулан хүргэж чадах ганц ч болов Африкийн тэргүүний и-мэйл хаягийг олох мухар эрэлд мордох нь лавтай.


БНХАУ саяхныг хүртэл Алжир, Холбооны Бүгд Найрамдах Нигери улс, Өмнөд Африк, Судан болон Замби зэрэг байгалийн нөөц ихтэй цөөн хэдэн оронд анхаарлаа хандуулж байсан юм. Харин өнөөдөр байгалийн нөөц, баялгаар хомс, ашигт малтмал олборлоход ихээхэн хүндрэлтэй Этиоп, Конго зэрэг орон анхаарлын төвд орж эхэлсэн нь ашигт малтмалаас бусад салбарт бизнесээ өргөжүүлэх сонирхолтой хятад иргэдийн тоог улам нэмэгдүүлэх болжээ. БНХАУ-ын төрийн өмчит компани болон хувийн хэвшлийнхэн өөр хоорондоо өрсөлдөж, эх орондоо олдог ашгаас нь хавьгүй илүү ашигтай байгаад аль аль нь соронзон мэт татагдах болов. Шинээр байгуулагдаад удаагүй хувийн сангууд Африк руу мөн хошуурах болжээ.

Африкчууд дарамт шахалтад ортлоо л хол. Африкийн Засгийн газрууд өөрсдөө гайхмаар итгэл төгс байгаагаа харуулсан байна. Африкийн хамгийн залуу орон болох Өмнөд Судан нутгаасаа хөөн зайлуулах ёстой ганц хүн бол хятад хүн гэж үзэх болжээ. Түүнийг Лю Яинцай гэх бөгөөд Хятад-Малайзийн хамтарсан газрын тосны компанийн захирал, Засгийн газрын хамгийн том үйлчлүүлэгч юм. Тэрбээр 815 сая ам.долларын хулгайн хэрэгт

холбоотой болох нь тогтоогджээ. Конго улс таваарын хоёр хятад наймаачинг луйвар хийсэн хэргээр Кивү бүс нутгаасаа хөөн зайлуулсан байна. Алжир улсын шүүх БНХАУ-ын хоёр компанийг авлигын хэрэгт буруутгаж, олон нийтийн тендерт оролцохыг нь хоригложээ. Габон улсын Засгийн газар мөн ашигт малтмалын таатай бус хэлцлийг хэрэгсэхгүй хаясан. Кени болон Өмнөд Африкийн хуучинсаг үзэлтнүүд зааны яс болон хирсний эврийн худалдаагаа нэн даруй зогсоохыг БНХАУ-аас шаардаж байна.

Африкийн элитүүд хөгжиж

БНХАУ-ын талаарх имиж Африкт өмнө нь үл итгэл төрүүлж, сэвтэж байсан бол өнөөдөр өөрчлөгдөж байна. Хятадын өрсөлдөөнтэй нүүр тулсан бизнесмэнүүд, тэр дундаа фермер, жижиглэнгийн худалдаа болон жижиг бизнесийн салбарынхан гомдоллосон хэвээр. Малави, Танзани, Уганда болон Замби гэсэн оронд хятад хүмүүс ажиллаж болох бүхий л үйлдвэр, бизнесийн талбарыг хориглосон шинэ журам гаргасан байгаа юм. Гэтэл хятадуудыг ажлын байр бий болгож, ур чадвараа өвлүүлж, орон нутгийн эдийн засагт мөнгө зарцуулж байгааг хэлэх



буй орнуудын дунд БНХАУ-ыг өөрсдийнхөө хамгийн том бизнес түнш хэмээн зөвхөн BRICS (Бразил, ОХУ, Энэтхэг, БНХАУ, Өмнөд Африк)-ийн нүдээр л харж байна. Бразил, ОХУ, Энэтхэг, түүнчлэн Турк, Өмнөд Солонгос гэх мэт зарим орон БНХАУ-ын замаар замнаж буй. Энэтхэгийн компаниуд Сино-Африкийн худалдааны гуравны нэгээр хэмжигдэх гэрээ, хэлцэл хийгээд байгаа бөгөөд уг хэмжээ 50 хувь болж нэмэгдэж байгаа талаар зарим баримт байдаг. Өнгөрсөн гуравдугаар сарын 26-27-нд BRICS-ийн тэргүүнүүд Өмнөд Африкт уулзсан нь санамсаргүй хэрэг биш бөгөөд тэд бүгд өрсөлдөгч юм.

африкчуудын тоо нэмэгдсээр байна. Ялангуяа Африкийн жижиг орнуудад Азийн хамгийн том гүрэн айдас төрүүлж буй боловч өөрчлөлт гарч байгаа нь илт анзаарагдаж байгаа юм. Замби улсын Ерөнхийлөгч Майкл Сата БНХАУ-ыг удаан хугацаанд шүүмжилж байгаа бөгөөд 2011 онд сөрөг хүчин байх үедээ бодлоо өөрчилж байсан удаатай. Өнгөрсөн жил тэрбээр Хятад болон Энэтхэгийн бизнесийн ашиг сонирхлыг хурцаар шүүмжилдэг Хөдөлмөрийн сайдаа албан тушаал бууруулж байжээ. Мөн өөрийн Эх оронч фронт хөдөлгөөн нам болон БНХАУ-ын Коммунист намын хоорондох харилцааны талаар хэлэлцүүлэх зорилгоор Дэд ▶

► ерөнхийлөгчөө Бээжин рүү илгээж байжээ.

Өнөөг хүртэл Африкийн ардчилал сэвтээгүй явсаар ирсэн. БНХАУ хүний эрх зөрчигдөж байгаа асуудлыг мэдсээр байж үл тоомсорлодог хэрнээ ардчилсан байгуулал болон конвенцид нааштай хандсаар иржээ. Үүний тод жишээ бол БНХАУ Зимбабве улсын Ерөнхийлөгч Роберт Мугабетэй хамтын ажиллагаа тасралтгүй өрнүүлэхийн хажуугаар сөрөг хүчний тэргүүн Морган Цвангирайг Бээжинд урьсан явдал байв. Мөн өнгөрсөн жил БНХАУ-ын лидерүүд Сенегал улсад ардчилсан өөрчлөлт гарахад дэмжлэг үзүүлж байв. Тухайн үед Сенегал улсын дипломат нэр хүндийг Тайваниас БНХАУ руу эргүүлж гавьяа байгуулсан Сенегалын Ерөнхийлөгч Абдулей Вэйд эрх мэдлээ алдаж байжээ.

БНХАУ-ын оролцоо улам өргөжин тэлж байгаагаас үүдэлтэй зарим нэг айдас ор үндэсгүй болох нь батлагджээ. Үүнд, Хятад улс зэвсэгт мөргөлдөөнийг ерөөсөө турхирч байгаагүй. Харин ч эсрэгээрээ өөрийн хувийн ашиг сонирхолдоо хөтөлгдөн энх тайвныг тогтоогч дүрд байнга тоглосоор ирсэн. Судан болон Өмнөд Судан аль аль нь БНХАУ-ын худалдааны томоохон түншүүд. Гэтэл хоёр улсын хооронд өнгөрсөн жил дайн болох шахах байх үед БНХАУ бусад гүрэнтэй хамтран дипломат сувгаар хөндлөнгөөс оролцож байв.

Харин Африкийн хамгийн том эдийн засгуудын хувьд БНХАУ ач холбогдлоороо өөр юм. Тэдгээр улс адилхан түвшинд өрсөлдөгчид мэт харагддаг. Өмнөд Африкийн Ерөнхийлөгч Жакоб Зума БНХАУ-тай харилцаагаа удаан хугацаанд сайжруулсаар ирсэн. Түүнийг энэхүү үзэл бодлоо өөрчлөхийг шаардсан орон нутгийн чанартай шүүмжлэл өнгөрсөн жилээс чих дэлсэх болсон. Нигери улсын Төвбанкны захирал хятадуудыг “Колончлолын багахан шинж тэмдэг” үзүүлэх болсон тухай сүүлийн үед муучлах болжээ. Харин бусад африкчуудын хувьд энэ тал дээр тохуурхангуй инээх ажээ. Өнгөрсөн үед тэд гол төлөв өөрсдийн зах зээлээ эзэлж чадсан Нигери болон Өмнөд Африкийнхан байсан юм. ■

Эх сурвалж: *The Economist*

ХОЙД ХӨРШ

ОРОСЫН ШАРХАДСАН АВАРГА

Орчуулсан Х.БУЛГАН

Хуучин ЗХУ-ын үед байгуулагдсан дэлхийн хамгийн том байгалийн хийн үйлдвэрлэгч “Газпром” нь олон жил тэнгэрт хадсан ханшаараа ноёрхлоо. ОХУ-аас Европ руу хий урсан, нутаг руугаа томоохон ашиг болж буцаж ирдэг байлаа. Дэлхийн 30-аад оронд шингэн хий нийлүүлэгч тус компанийн ашиг өнөөдөр буурах төлөвтэй байна. Америкаас нийлүүлж буй их хэмжээний занарын ачаар дэлхийн зах зээл дээр шатахуун элбэгших төлөвтэй боллоо. “Газпром”-ын Европ ►



▶ дахь үйлчлүүлэгчид хий импортлох нэг бус сонголттойгоо мэдэрч эхэлжээ. Үүнтэй холбоотой хойд хөршийн хийн үнэ уналтад орж буй.

Олон жил хялбар аргаар хөрөнгөжсөн “Газпром” Оросын хийн 75 хувийг хангадаг. Түүнчлэн Баруун Европын шатахууны 25 хувийг нийлүүлдэг байсан газын монополичлол саяхан хүртэл эдгээр орнуудын зах зээлийг атгадаг байлаа. “Газпром” жирийн нэгэн компани биш ээ. Хоёр эзэнд үйлчилдэг. Гадаадын хөрөнгө оруулагчтай компанийн хувьд урт хугацаанд ашгаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй. Нөгөөтэйгүүр төрийн мэдлийн компани учир улс төрийн зорилгоо мөн мөрддөг аж.

Газын аварга хоёр эзнийхээ нэгд нь илүү хичээнгүй зүтгэдэг. Ерөнхийлөгч Путин эрх мэдлээ 2000-аад оны эхээр бэхжүүлсний дараа “Газпром”-ыг улсынхаа шинэ капитализмын гол арга хэрэгсэл болгосон. Тэрбээр өөрийн холбоотнуудаа компанийн удирдах албан тушаалд томилсон байдаг.



Тэгээд эл бизнесийг гадаад бодлогын чухал хэсгээ болгосон. Тухайлбал, Гүрж, Украин, Беларусь, Молдав зэрэг оронтой улс төрийн маргалдаан үүссэн үед хийн хангамжаа шууд зогсоодог байж.

“Газпром”-ын зузаан ашиг ноён Путинд эх оронд нь ч ач тусаа үзүүлсэн. Хийг хямд үнээр дотоодын зах зээлд нийлүүлж, нимгэн түрийвчтэй олон хүнийг дулаан өвөлжүүлсэн. Эрчим хүчний компани телевиз, сонин худалдаж авсан нь сонирхолтой гэхээс аргагүй. Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төр засагтаа “элэгтэй” аж. “RusEnergy”-ийн зөвлөх Михаил Крутихин нэгэнтээ “Газпром нэг л менежертэй. Тэр нь Путин” гэж хэлсэн удаатай.

Томоохон албан газруудад олон найзтай “Газпром” бага татвар төлсөөр ирсэн. Гэтэл компанийн үйл ажиллагааны зардал өссөөр л. Ялангуяа удирдлагадаа гар татдаггүй. 2008 оны төндөрт л гэхэд хиймэл нарны туяан шарлага, моринд зориулсан ванн хийхээр тусгасан байсан. Олон улсын эдийн засгийн Петерсоны институтын тооцоолсноор, “Газпром” 2011 онд 46 тэрбум ам.долларын ашиг олсон ч 40 тэрбум ам.доллар авлига, үр ашиггүй зардалд зарцуулсан гэнэ.

Мөн Путины гардан хэрэгжүүлсэн зарим нэг төслийн үнэ цэнэ тун эргэлзээтэй. Жишээлбэл, тэрбээр 21 тэрбум ам.долларын үнэтэй Зүүн Европоор дамжсан Оросын өмнөд хэсэг, Австри хоорондын хий дамжуулах хоолой тавихыг зөвшөөрөөгүй. Учир нь төслийг хэрэгжүүлэхийн тулд Европт хий гаргах гол гарц улсаар Украин тодроод байсан аж. Цагтаа мөнгөнд живж байсан компанийн үнэлгээ өнгөрсөн сарын 4-ний байдлаар 2008 оныхоос гурав дахин бага болсон гэж хөрөнгө оруулагчид үзэж байна.

“Газпром”-ын гол үйлчлүүлэгч бол Европын орнууд. Эдгээр нь компанийн нийт орлогын 40 хувийг бүрдүүлдэг аж. Гэтэл гол түншүүд өнөөдөр Америкаас байгалийн шингэн хий авах боломжтой болсон. Ийнхүү бэлэн бүтээгдэхүүний зах зээлээс хийг авах нь урт хугацааны гэрээгээр нийлүүлэх Оросын хийнээс хамаагүй

хямд аж. “Газпром” дурамжхан үнээ буулгасан бөгөөд энэ нь 4.7 тэрбум ам.доллартай тэнцэх алдагдал болох урьдчилсан тооцоо гарчээ.

Миллерийн үлгэр

“Газпром”-ын дарга нар олон жилийн турш бизнест тулгарч болзошгүй аюулыг няцаасаар ирсэн. Гүйцэтгэх захирал Алексей Миллер элбэг болох занарыг “үлгэр” гэж үзэж байжээ. Путин харин саяхнаас нойрноосоо сэрсэн мэт. Тэрбээр өнгөрсөн онд “Занарын хувьсгал” гарсан бөгөөд ОХУ харилцагчидтайгаа хоёр талын хүлээн зөвшөөрсөн хэлбэрээр хамтран ажиллахаа мэдэгдсэн.

“Газпром” дотоод зах зээл дээрээ ч ширүүхэн өрсөлдөөнтэй тулгарах магадлалтай. Хоёр том өрсөлдөгч компани гарч ирлээ. Нэг нь Путины хуучин танил Геннадийн Тимченкогийн эзэмшлийн байгалийн хий үйлдвэрлэгч “Новатек”. Хоёрдах нь Путины итгэмжлэгдсэн зөвлөх Игорь Сечинээр удирдуулсан төрийн өмчит “Роснефть”.

“Газпром” хийн шинэ эх үүсвэр болон шинэ зах зээлтэй болох хэрэгтэй байна. Эдгээрийн аль нь ч амар биш. Түүнчлэн компанийн техник технологи хуучирч байгаа нь дараагийн бэрхшээлийг үүсгэж байна. Компанийн үйл ажиллагаа сайжирч чадвал Азийн зах зээлд хий нийлүүлэх томоохон боломж нээлттэй буй. Үүний тулд хийг шингэн хэлбэрээр усан замаар тээвэрлэх, эсвэл хоолойгоор дамжуулж болно. Хий нийлүүлэх Оросын хамгийн том зах зээл бол Хятад улс атал хоёр улс үнэ дээрээ тохиролцож чадахгүй л байна. Урд хөрш Төв Ази, Австрали, Ойрхи Дорнод, Африкийн баруун хэсгээс байгалийн хий импортлох гэрээ байгуулаад буй. Өөрөөр хэлбэл хойд хөршөөс бусад гол хий эхлүүлэгчид тохиролцож эхэлсэн гэсэн үг.

“Газпром” олон давуу талтай. Байгалийн хийн асар их нөөцөөс эхлээд хийн хэрэгцээтэй хөрш орнууд байна. Бүх шийдвэр зөвхөн Путины гарт л байна. Тэрбээр хүлээгээд суугаад байваас “Газпром” болон түүнд олон сонголт үлдэхгүй. ■